

**НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ
ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГ
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА**

ШҮҮХИЙН ПРАКТИК

Улаанбаатар
2020

ННА-67
ДАА-340
Н-615



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

СУДАЛГААНЫ БАГ:

- Зөвлөх:** А.Бямбажаргал, Хууль зүйн ухааны доктор (S.J.D), Эрдэмтэн нарийн бичгийн дарга МУИС-ийн Хууль Зүйн Сургууль
- Багийн ахлагч:** Р.Мөнхзул, Магистрант, МХХ-ны Захиргааны эрх зүйн хорооны УЗ-ийн гишүүн, Байгаль орчны эрх зүйн дэд хорооны зохицуулагч
- Судлаачид:** Д.Баяр, Хууль зүйн магистр (LL.M.), МХХ-ны гишүүн, МУИС-ын Хууль зүйн сургуулийн багш
- Д.Бадамцэцэг, Хууль зүйн магистр (LL.M.), МХХ-ны гишүүн, Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш
- С.Билгүүн, Хууль зүйн магистр (LL.M.), Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн ахлах референт

Судалгааны хүрээнд гаргасан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форум болон шүүхийн байгууллагын албан ёсны байр суурийг шууд илэрхийлэхгүй болно.

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9574-3-8

АГУУЛГА

БҮЛЭГ I. УДИРТГАЛ	5
1.1 Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тогтолцоо ..	5
1.2 Судалгааны объект	6
1.3 Судалгааны ач холбогдол ба судлах зүйлс	7
1.4 Судалгаа хийсэн байдал	8
1.5 Судалгааны ажлын цар хүрээ	10
БҮЛЭГ II. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	13
2.1 Нийтийн ашиг сонирхлын маргаантай холбоотой хууль хэрэглээний зарим асуудал	14
2.1.1 ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2 дахь заалтын хэрэглээ	14
2.1.2 Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар тогтоосныг хэрэглэсэн талаар ..	18
2.1.3 Хангалттай сонирхол илэрхийлсэн байх, нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй тухай хуульд заасан шаардлага	20
2.1.4 ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн хэрэглээ	22
2.2 Шүүхийн шийдвэрийн ач холбогдолтой байдал	23
2.3 Төрийн бус байгууллагаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход анхаарах зарим асуудал	26
БҮЛЭГ III. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ	27
3.1 Нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах эрхийн тухай ойлголт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал	27
3.2 Бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон болон нэхэмжлэлийг буцаах захирамжийн хүрээнд	35
3.2.1 Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон захирамжийн үндэслэл	35
3.2.2 Нэхэмжлэлийг буцаах тухай захирамжийн үндэслэл	38
3.2.3 Шүүхээс бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон хийгээд нэхэмжлэлийг буцаасан захирамжтай холбоотой дүгнэлт	39
3.3 Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн хүрээнд тулгамдаж буй асуудал	43

3.3.1	ЗХШХШтХ—ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шаардлагыг хангаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай	44
3.3.2	Шүүхийн харьяалал зөрчсөн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай	46
3.3.3	Шүүхэд нэхэмжлэл гаргах итгэмжлэлийн асуудлаар.....	47
3.3.4	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамжийн тухай.....	48
3.3.5	Тодорхой нутаг дэвсгэрийн харьяаллаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлаж болох уу?.....	49
3.3.6	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжтай холбоотой дүгнэлт	50
3.4	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудал.....	58
3.4.1	Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг	58
3.4.2	Улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал.....	59
3.4.3	ЗХШ-ийн шийдвэр гүйцэтгэл.....	61
БҮЛЭГ IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....		64
4.1	Судалгааны Дүгнэлт	64
4.1.1	ТББ-тай холбоотой дүгнэлтүүд.....	64
4.1.2	Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээний тухайд.....	65
4.1.3	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үе шаттай холбоотой дүгнэлт	70
4.1.4	Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн тухай.....	71
4.2.	Судалгааны зөвлөмж	71
4.2.1.	Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр.....	71
4.2.2	Шүүхээс хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх чиглэлээр.....	72
4.2.3	ТББ-ыг мэргэшүүлэх, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр	73
ХАВСРАЛТ		75
ХАВСРАЛТ 1. Шүүхийн шийдвэр.....		75
ХАВСРАЛТ 2. Шууд бус хамааралтай нэхэмжлэлтэй холбогдон гарсан захирамжууд		83
ХАВСРАЛТ 3. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон захирамж		86
ХАВСРАЛТ 4. Нэхэмжлэлийг буцаах тухай захирамж.....		89
ХАВСРАЛТ 5. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамж... 91		
ХАВСРАЛТ 6. Шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй этгээдийн гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж 98		
ХАВСРАЛТ 7. Нэхэмжлэлийн бүтэц, бүрдүүлбэрийн санал.....		102



БҮЛЭГ I. УДИРТГАЛ

1.1 НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛӨН НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ТОГТОЛЦОО

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16.14-т “Монгол Улсын иргэд ... хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” болохыг тунхаглажээ. Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн үүрэг нь “Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлж хэрэг, маргааныг хянан хэлэлцэж шийдвэрлэх” зэрэг Үндсэн хуулийн зохицуулалтаар илэрдэг. Тэгвэл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд хандах эрх нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх, нийтийн ашиг сонирхлыг зөрчиж буй эсэхэд шүүхээс хяналт тавих, улмаар эрх мэдлийг тэнцвэржүүлэхэд онцгой ач холбогдолтой байдаг.

Дэлхий дахинд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн хоёр хэлбэр байдаг. Үүнд: (1) Нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаарддаг болон (2) уг зөрчлийг шаарддаггүй тогтолцоо багтана. Монгол Улсын хувьд ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дугаар заалт нь нэхэмжлэгч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын зөрчлийг сэргээлгэх шаардлагыг тодорхойлохгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхлын хүрээнд нэхэмжлэл гаргахыг зөвшөөрсөн зохицуулалт юм.

Энэ төрлийн зохицуулалт нь өөрийн давуу болон сул талыг агуулдаг. Эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, иргэний нийгмийг чадавхжуулах болон нийтийн хяналтын тогтолцоог хөгжүүлэхэд энэ төрлийн зохицуулалт эерэг үр дүнтэй. Харин нийтийн ашиг сонирхол нэрийн дор түүний эсрэг

нэхэмжлэл гаргах, улс төрийн болон бусад явцуу ашиг сонирхлоор ашиглавал ардчилал, эрх мэдэл харилцан хяналт-тэнцэлтэй байх, шүүхийн хараат бус, бие даасан байдалд зарим талаар сөрөг үр дагаврыг үүсгэж болзошгүй байдаг.

1.2 СУДАЛГААНЫ ОБЪЕКТ

ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө манай улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд хандах эрхийг сумын Засаг дарга, Хүний эрхийн Үндэсний комисс, Сав газрын захиргаа, иргэний нийгмийн байгууллага гэх мэт хэд хэдэн субъектэд олгосон байв. Харин нэхэмжлэлийн шаардлагын тухайд буруутай этгээдээс улс, нийтэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэх ба хэрэг маргаан нь иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдэж байв.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь зүйл заалтаар үндсэн дөрвөн агуулга бүхий асуудлаар захиргааны хэргийн шүүхэд хандан нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрхийг нээж өгчээ. Хэдийгээр уг тогтолцоо манай эрх зүйн орчны хүрээнд шинэ тутам боловч эрх зүйн зохицуулалтын хууль зүйн агуулга, зорилгын хэрэглээ, шүүхийн практикт тулгамдаж буй асуудал зэргийг нээн илрүүлэх шаардлага хэдий нь бий болжээ.

Иймд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн хэрэгжилтийн өнөөгийн бодит байдлыг толилуулан улмаар цаашид боловсронгуй болгох асуудлыг энэхүү судалгаагаар авч үзлээ. Ингэхдээ судалгааны баг ЗХШХШТХ-ийн 18.3-т заасан дөрвөн үндсэн агуулга бүхий нийтийн ашиг сонирхлын хүрээнд эдүгээ хянан шийдвэрлэгдсэн бүхий л тохиолдол, энэ төрлийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд бүхэлд нь дүн шинжилгээ хийлээ.



1.3 СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ БА СУДЛАХ ЗҮЙЛС

Уг судалгааны ажлын ач холбогдлыг дараах агуулгаар тодорхойлж байна. Үүнд:

- Улсын хэмжээнд шүүхэд гаргасан нэхэмжлэлийн агуулга, нэр төрөл, тоон мэдээлэл, тэдгээрийг шийдвэрлэсэн байдалд дүгнэлт өгөх;
- Төрийн бус байгууллага (ТББ)-аас шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болохоо нотлох, нэхэмжлэлийг хүлээн авах эсэхийг шийдвэрлүүлэх, хэрэг маргааныг хянан шийдвэрлүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох замаар ТББ-уудад арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс хуулийг хэрхэн ойлгож, хэрэглэх, шүүхийн байгууллага ямар асуудалд анхаарах, улмаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал зөвлөмж өгөх;
- Цаашид энэ төрлийн хэрэг маргаан, шүүхийн практикийг сонирхон судлах хэн бүхэнд судалгааны эх сурвалж бий болох.

Судалгаа нь дор дурдсан нэр бүхий бүлэг асуудалд чиглэгдэх ба улмаар тайланг энэхүү агуулгын хүрээнд боловсруулсан болно. Үүнд:

- Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан үндэслэл, нэхэмжлэгчид тавигдах шаардлагад дүн шинжилгээ хийх;
- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн явц, хэлэлцүүлгээр шийдвэрлэж буй асуудал, түүний үндэслэлд дүн шинжилгээ хийх;
- Анхан шатны шүүхээс гарч буй захирамж, тогтоолыг дээд шатны шүүхээс хянаж, нийтийн ашиг сонирхлын маргааныг шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх;
- Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах хэрэг маргааны хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан бусад шийдвэрт дүн шинжилгээ хийх;

- Хэрэг эцэслэн шийдвэрлэсэн шийдвэр, тогтоол, магадлалд дүн шинжилгээ хийх;
- Шүүхийн нэгдмэл шинж-интегрити буюу ижил төрлийн хэрэг маргааныг өөр өөр шүүхэд хэрхэн шийдвэрлэсэн байдал буюу хуулийг нэг мөр хэрэглэж буй эсэхэд дүн шинжилгээ хийх.

1.4 СУДАЛГАА ХИЙСЭН БАЙДАЛ

Судалгааны ажлыг 1) судалгааны баримт сэлт, мэдээлэл цуглуулах; 2) дүн шинжилгээ хийх гэсэн үндсэн хоёр үе шаттайгаар явууллаа.

Нэгдүгээрт, Судалгааны ажлын хүрээнд мэдээллийг шүүхээс болон бусад гэсэн үндсэн хоёр хэлбэрээр цуглуулсан болно. Үүнд:

Шүүхээс мэдээлэл цуглуулах хүрээнд, Монголын Хуульчдын холбооноос Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэхийг хүссэн албан тоот, түүний хариуд судалгааны ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн хийхийг зөвшөөрсөн албан бичгийг үндэслэн захиргааны хэргийн анхан шатны нийт шүүхээс мэдээлэл цуглууллаа. Эдгээр мэдээллийг аймаг, нийслэл дэх захиргааны хэргийн шүүх, шүүхийн төрөлжсөн архив, шүүхийн хэргийн хөдөлгөөний бүртгэл, хяналтын систем зэрэгт тулгуурлан баталгаажуулсан болно. Мэдээллийг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан агуулгаар ямар нэхэмжлэгч хэнд холбогдуулан, ямар үндэслэл, шаардлага тавьж шүүхэд нэхэмжлэл гаргасан, нэхэмжлэлийг хүлээн авах эсэхийг шийдвэрлэсэн захирамж, тогтоолын дугаар, хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дугаар зэргийг багтаасан судалгааны асуулгыг шүүхүүдээс авлаа.

Бусад аргаар мэдээлэл цуглуулах хүрээнд, нийтийн ашиг сонирхлын маргаанд нэхэмжлэгчийг төлөөлөн оролцсон төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзалт хийх, Монголын хуульчдын холбооны цахим хуудас, түүний дэргэдэх Захиргааны эрх зүйн хорооны нийт гишүүдийн цахим хаяг, 100 орчим ТББ-ын нэгдсэн цахим хаяг зэрэгт хандаж нийтийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар гарсан хэрэг маргааны талаар мэдээлэл ирүүлэхийг хүссэн захидал хүргүүлж,

Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа стратегийн өмгөөллийн мэдээлэл зэрэгт тулгуурлан цуглуулав. Ийнхүү цуглуулсан мэдээлэл нь шүүхээс ирүүлсэн мэдээллийг баталгаажуулах, мэдээлэл орхигдсон эсэхийг шалгах, энэ төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан бэрхшээл, асуудлыг нэгтгэхэд ач холбогдолтой юм.

Хоёрдугаарт, судалгааны хүрээнд цугларсан мэдээллийг (1) судалгааны ач холбогдол, хамаарал бүхий байдал, түүнчлэн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоон буцаасан болон хүлээн авахаас татгалзсан зэрэг нэхэмжлэл хүлээн авах эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, (2) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан бусад шийдвэр, тогтоол, (3) захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол гэсэн төрлөөр ангилан ялгалаа.

Судалгааны үр дүнгээс үзэхэд нийтийн ашиг сонирхлын маргааны төрөл, тоон үзүүлэлт төдийлөн их биш байсан тул тэдгээрийн агуулга, нэхэмжлэл бүрийн онцлогийг тайланд бүрэн тусгаж танилцуулах, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг тулгарч буй асуудлыг илрүүлэх, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх гэсэн шалгуураар дүн шинжилгээ хийж бүтцийг тодорхойлон тайланг боловсруулсан болно.

Судалгаанд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд шүүхэд хянан шийдвэрлэгдэж байсан нийтийн ашиг сонирхлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хамруулсан бөгөөд эдгээрээс зарим нь дараа онд үргэлжилж, судалгааны тайланд дурдсан нөхцөл байдал өөрчлөгдсөн байхыг үгүйсгэхгүй.

Судалгаанд ашигласан мэдээлэл бодитой байх, уншигч тухайн асуудалд холбогдох тохиолдол, жишээтэй шууд танилцах боломжийг хангаж, тохиолдол бүртэй холбогдон гарсан шийдвэр, захирамжийг огноо, дугаартай нь судалгааны тайланд хавсралтаар орууллаа. Байгууллага, хувь хүний нууц, нэр төр, алдар хүндийг хүндэтгэх зорилгоор судалгаанд тухайн субъектийн оноосон нэрийг товчилсон болно.

1.5 СУДАЛГААНЫ АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

Энэхүү судалгааны хүрээнд цугларсан мэдээллийг нэгтгэж үзэхэд нийт 48 нэхэмжлэгчийн бие даасан 50 нэхэмжлэл байв. Эдгээр 50 нэхэмжлэлтэй холбоотойгоор шүүхээс 61 шийдвэр, захирамж, тогтоол гарсан байна.

Эдгээр шийдвэрийг нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нь шалгуур болгон нийтийн ашиг сонирхолд *шууд хамааралтай*, шууд бус хамааралтай, хамааралгүй гэж 3 ангилав. Шууд хамааралтай гэдэг нь ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан агуулга, зорилгын хүрээнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлж байгаа, *шууд бус хамааралтай* гэдэг нь хэдийгээр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгыг агуулсан байж болох ч хууль зүйн хувьд шаардлага хангаагүй, *хамааралгүй* гэдэг нь нэхэмжлэлийн зорилго, агуулгын хувьд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөөгүй гэж тайлбарлагдана.

Шууд бус хамааралтай хэмээн ялгаж авч үзсэн нь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалахад нэхэмжлэгч нар ямар алдаа гаргасан, түүнийг хэрхэн сайжруулж нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоо бүрэн хэрэгжүүлж болох талаар зөвлөмж өгөх ач холбогдолтой юм. Ийнхүү судалгааны хүрээнд цугларсан мэдээллээс 10 нэхэмжлэлийг шууд бус хамааралтай гэж үзсэн болно.

Хамааралгүй гэсэн ангиллын тухайд мэдээлэл цуглуулах үе шатанд цугларсан 50 нэхэмжлэлээс 16 нь нийтийн ашиг сонирхолд хамааралгүй байв. Гэвч зарим шүүхээс тэдгээр нэхэмжлэлийг нийтийн ашиг сонирхолд хамаатай гэж үзэн мэдээнд ирүүлсэн байлаа. Энэ нь шүүхийн захиргааны ажилтан, хуульчдын дунд нийтийн ашиг сонирхлын хэрэг маргаан, түүний онцлогийн талаарх хууль зүйн мэдлэг дутмаг, ойлголт нэг мөр болоогүйг харуулж байгаа нь цаашид анхаарвал зохих асуудал юм.

Хамааралтай гэж үзсэн нэхэмжлэлүүдийг дараах байдлаар тоон мэдээлэлд оруулан илэрхийлж болохоор байна.



1. Нэхэмжлэлийг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан нийтийн ашиг сонирхлын хүрээнд авч үзвэл:

Ашиг сонирхлын төрөл	Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн тоо
Хүрээлэн буй орчин	16
Хүүхдийн эрх	3
Нийтийн эрүүл мэнд	3
Нийтийн өмч	2
Нийт тоо	24

2. Нэхэмжлэл гаргасан оноор харьцуулахад:

Нэхэмжлэл гаргасан он	Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн тоо
ЗХШХШТХ мөрдөгдөж эхлэхээс өмнө нэхэмжлэл гаргасан ба мөрдөгдөж эхэлсний дараа шийдэгдсэн	2
2016	2
2017	9
2018	11

ЗХШХШТХ нь 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр батлагдаж, мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэн. Хууль батлагдсан онд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд хандсан нэхэмжлэл цөөн байсан бол 2017, 2018 онд өссөн байна.

3. Нэхэмжлэлийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллаар авч үзвэл:

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж	Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн тоо	Анхан шатны шүүхийн шийдвэрийн тоо
Нийслэл	18	10
Баянхонгор аймаг	1	1
Дархан-Уул аймаг	1	1
Дорнод аймаг	3	3
Ховд аймаг	1	0 ¹

¹ Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн.

Баянхонгор, Дархан-Уул, Дорнод аймагт гаргасан нэхэмжлэлүүд нь хүрээлэн буй орчин, Ховд аймагт гаргасан 1 нэхэмжлэл нь нийтийн өмчийг хамгаалах зорилготой байна.



БҮЛЭГ II.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ЗХШХШТХ-ийн 18.3-т шууд хамааралтай 24 нэхэмжлэл шүүхэд гаргасны 13 нэхэмжлэлд хэрэг үүсгэж, хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр гарсан байна.

Шийдвэрийг ашиг сонирхлын төрлөөр ангилбал:

Ашиг сонирхлын төрөл	Хүлээн авахаас татгалзсан нэхэмжлэлийн тоо
Хүрээлэн буй орчин	9
Хүүхдийн эрх	2
Нийтийн эрүүл мэнд	1
Нийтийн өмч	1

Эдгээр 13 хэргээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан 4, зарим хэсгийг хангасан 3, нэхэмжлэлийн шаардлага хангаагүй 4, шүүх хуралдаанаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэрэгсэхгүй болгосон 2 хэрэг байна. Хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдлын дүгнэлтийг “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн үндэслэл” бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Хэргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллаар авч үзвэл Баянхонгор аймагт 1, Дорнод аймагт 2, Дархан-Уул аймагт 1, Нийслэлд 9 хэрэг тус тус шийдэгдсэн байна.

Нэхэмжлэлийн шаардлагыг агуулгаар нь ангилж үзвэл:

1. Төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлээгүй эс үйлдэхүйг тогтоолгож, тодорхой үйлдэл хийхийг даалгуулах;
2. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, тэр дундаа хүрээлэн буй орчны асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтан болон компанийн хооронд байгуулсан захиргааны гэрээг илт

хууль бус болохыг тогтоолгох;

3. Төрийн эрх бүхий байгууллагаас аж ахуйн нэгжид олгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах;
4. Хүүхдийн эрхийг хамгаалах зэрэг болно.

Шүүхийн шийдвэрт хийх дүн шинжилгээг судалгааны ач холбогдолтой байдлыг харгалзан дараах агуулгын хүрээнд хийлээ. Үүнд:

1. Нийтийн ашиг сонирхлын маргаантай холбоотой хууль хэрэглээний зарим асуудал;
2. Шүүхийн шийдвэрийн ач холбогдол бүхий байдал;
3. ТББ-аас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход анхаарах зарим асуудал зэрэг болно.

Дүн шинжилгээг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс боловсруулсан “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга, аргачлал”-ыг удирдамж болгон, судалгааны онцлогт тааруулан ашиглалаа. Шүүхийн шийдвэрийн танилцуулгыг Хавсралтаас үзнэ үү.

2.1 НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН МАРГААНТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛ

Нийтийн ашиг сонирхлын хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэртэй танилцахад шүүхээс хуулийг харилцан адилгүй байдлаар хэрэглэх, тайлбарлах явдал цөөнгүй байна. Хууль хэрэглээний асуудлыг дараах агуулгаар бүлэглэн судалж авч үзлээ. Үүнд:

2.1.1 ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2 дахь заалтын хэрэглээ

Нэхэмжлэгч нь ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасны дагуу шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг шүүхэд хандах үед нь анхлан шалгадаг. Шүүх нэхэмжлэл нь зохих бүрдүүлбэр хангасан эсэхийг





шалгаад хуульд заасан шаардлага хангасан байна гэж үзвэл захиргааны хэрэг үүсгэнэ. Хуулийн 18.3 дахь заалтыг харилцан адилгүй хэрэглэх буюу нэг шүүгч А шаардлагыг хангагдаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байхад нөгөө шүүгч А шаардлагыг огт харгалзалгүйгээр хэрэг үүсгэн маргааныг шийдвэрлэсэн тохиолдлууд ажиглагдаж байна. Үүнд:

а) **Шүүхийн зарим шийдвэрт нэхэмжлэгч нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх талаар дүгнэсэн байхад зарим шийдвэрт огт дүгнээгүй болох тухайд:** Нийтийн ашиг сонирхолд хамааралтай гэж үзсэн 15 шүүхийн шийдвэрийг судлахад 10 шийдвэрт нэхэмжлэгч нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй талаар дүгнэлт өгсөн, үлдэх 5 шийдвэрт огт дүгнэлт өгөөгүй байна. Энэ талаар хуульд нарийвчилсан зохицуулалт байхгүй боловч 18.3.1, 18.3.2-т заасан шалгуурыг хэрхэн хангасан талаар шүүхийн шийдвэрт тусгах нь чухал ач холбогдолтой. Учир нь (1) нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангуулах, буцаах болон нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай захирамж нийтэд ил байдаггүй тул хуулийн дээрх заалтуудыг харилцан адилгүй хэрэглэх эрсдэл үүсэхээс сэргийлнэ, (2) ТББ-ууд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд хандах эрхтэй болохоо нотлоход шаардагдах баримт бичгийг зөв бүрдүүлэх боломж олгоно, (3) шүүхийн байгууллага хараат бус ажилласан болохоо олон нийтэд харуулах боломжтой болно, (4) Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үйл явц зөв хөгжих, нийтийн ашиг сонирхлыг шүүхийн журмаар хамгаалах эрх зүйн соёл, хандлага төлөвших, нийтийн эрх ашгийг хөндсөн төрийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдах зэргээр нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Иймд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нэхэмжлэгчид тавигдах шаардлага нь захиргааны актын маргааны нэхэмжлэгчид тавигдах шаардлагаас онцлогтой тул шүүх үүнийг чухалчлан авч үзэж, зохих дүгнэлт өгч байх нь зүйтэй.

Нэхэмжлэгчийг ямар үндэслэлээр нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзсэн талаар шүүхийн шийдвэрт дүгнээгүй нөхцөлд хэргийн оролцогч хийгээд олон нийтэд тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж байгаа юм. Тухайлбал, шүүхийн шийдвэрт (*Хавсралт 1. Шийдвэр 1-ийг*



цзнэ цц) нэхэмжлэгч ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг цуцлуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан ба гол үндэслэлээ түүх, соёлын дурсгалт зүйл устаж үгүй болох, түүнийг зайлшгүй хамгаалах шаардлагатай хэмээн тайлбарлажээ. Хэрэв тухайн ТББ-ын дүрмийн зорилго нь байгаль орчныг хамгаалахад чиглэгдсэн бол нэхэмжлэлийн шаардлага нь байгууллагын дүрмийн зорилгод нийцэхгүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах дүрмийн зорилготой бол хуулийн §18.3-т заасан нийтийн өмч гэсэн хүрээнд хамааруулж нэхэмжлэлийн үндэслэлээ тодорхойлох шаардлагатай юм. Харин энэ тохиолдолд нэхэмжлэгч нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрх бүхий этгээд мөн эсэхийг нотлох ажиллагаа хийлгүйгээр захиргааны хэрэг үүсгэн улмаар нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ. Түүнчлэн хариуцагч байгууллагын зүгээс Нэхэмжлэгч нэхэмжлэл гаргах эрхгүй талаар тайлбарласан боловч шүүх түүнд дүгнэлт өгөөгүйн дээр нэхэмжлэгч өөрийгөө нэхэмжлэл гаргах эрхтэй болохоо ч мөн тайлбарлаагүй байна. Шүүхийн шийдвэрт энэ тухай дурдаагүй учраас нэхэмжлэгч үнэхээр нэхэмжлэл гаргах эрхтэй байсан уу, түүнийгээ нотлох баримтыг шүүхэд ирүүлсэн үү, шүүх нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргасан бүх ТББ-д ижил хандаж чадаж байна уу, хуулийг нэр мөр хэрэглэсэн үү гэх мэт олон тодорхойгүй асуултыг үүсгэж байна.

б) **ТББ дүрмийн зорилгын дагуу гурваас доошгүй жил тогтвортой ажилласан тухай нотлох баримтыг шүүхээс үнэлсэн байдал:** Шүүхийн шийдвэртэй танилцахад (*Хавсралт 1. Шийдвэр 2-ыг цзнэ цц*) нэхэмжлэгч сүүлийн 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан болохоо нотолж, нэхэмжлэлийн шаардлагад дурдсан асуудлаар төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн албан бичиг, түүний хариу зэргийг нэхэмжлэлд хавсаргасныг шүүх дээрх шаардлагыг хангасан гэж үзэж, нэхэмжлэлийг хүлээн авчээ. Хариуцагч нь нэхэмжлэгчийг нэхэмжлэл гаргах эрхгүй гэж маргасан, түүнчлэн улсын бүртгэлийн байгууллагаас нэхэмжлэгч нь ТББ-ын үйл ажиллагааны тайлан өгч байгаагүй гэсэн лавлагаа ирүүлсэн боловч өмнө дурдсан баримтын хүрээнд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж шүүх үзсэн. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагааны тайлангаа улсын бүртгэлийн байгууллагад заавал хүргүүлсэн байх, санхүүгийн тайланг нэхэмжлэлд хавсаргасан байх, татвар төлсөн





тайланг ирүүлэх зэрэг бусад ТББ-д нийтлэг байдлаар тавьдаг шаардлагыг энэ тохиолдолд шүүх шаардаагүй байна. Түүнчлэн зарим тохиолдолд шүүх тухайн ТББ-ыг нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нь нийтэд илэрхий (*Хавсралт 1. Шийдвэр 8-ыг үзнэ үү*) гэж үзвэл ямар нэг баримт шаардалгүйгээр нэхэмжлэлийг хүлээн авч хэргийг шийдвэрлэжээ. ТББ-ууд дүрмийн зорилгын дагуу 3 жилийн хугацаанд тогтвортой ажилласан болохоо харилцан адилгүй байдлаар нотолж байгааг буруу гэж үзэх боломжгүй. Харин энэ шаардлагыг хэрхэн нотлох талаар хуулийн зохицуулалтыг нарийвчлан нэг мөр болгох шаардлагатай байна.

в) Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй гэж үзсэн шүүхийн дүгнэлтийн үндэслэл хангалтгүй болох нь: Нэхэмжлэгч нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй болохыг шүүхийн шийдвэрт үнэлэхдээ ТББ-ын дүрмийн зорилго нь нэхэмжлэлийн шаардлагатай нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөлгүйгээр зөвхөн байгуулагдсан огноог дүрмийн зорилгын хамт дурдаад өнгөрөх, 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсныг нотлох зорилго бүхий баримтыг хэлбэрийн төдий үнэлэх, эсвэл хамааралгүй үйл баримтад үндэслэн дүгнэлт хийсэн тохиолдлууд ажиглагдаж байна. Жишээ нь, зөвхөн дор дурдсан үндэслэлээр нэхэмжлэгч ТББ-ыг хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангасан гэж дүгнэжээ:

“ТББ нь 2009 оноос эхлэн “Боловсролын өнөөгийн тогтолцоог шинэчлэх, судалгаа хийх, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг дэмжих” гэсэн үндсэн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулдаг, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага байна” (Хавсралт 1. Шийдвэр 7-г үзнэ үү).

“ТББ нь ЗХШХШтХ-ийн 3.1.9-д зааснаар захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, мөн хуулийн 18.3-д зааснаар нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд байна гэж шүүх үзсэн болно. Тодруулбал, дээрх хуулийн 18.3-т заасан шаардлагуудыг хангаж байгаа нь уг ТББ-ын улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, судалгааны ажил зэрэг баримтаар тогтоогдож, маргааны зүйл нь нийтийн өмчийг хамгаалахтай холбоотой байна” (Хавсралт 1. Шийдвэр 6-г үзнэ үү).



Шүүхийн шийдвэрт ЗХШХШТХ-ийн 18.3 дахь зүйл заалт, ТББ-ын зорилго, байгуулагдсан оныг тус тус дурдаад, “ТББ-ын Удирдах зөвлөлийн хурлын дугаар бүхий тогтоолоор Д овогтой Г-г тэргүүнээр улируулан сонгосон байна, дүрмийн 7.2-т Удирдах зөвлөлийн тэргүүн, дарга нь ТББ-ыг гадаад, дотоодод төлөөлөх, Удирдах зөвлөлийн хурлыг даргалах, Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах бүрэн эрхтэй” гэж заажээ. Иймд Д овогтой Г нь шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болох нь нэхэмжлэл, дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ зэрэг нотлох баримтуудаар нотлогдож байна” (Хавсралт 1. Шийдвэр 5-ыг үзнэ үү) гэжээ.

Нэхэмжлэл гаргах эрхийг ийм тодорхойгүй шалгуураар тогтоох нь ТББ-уудын дунд төөрөгдөл үүсгэх, буруу жишиг тогтоох эрсдэлтэй юм. Ингэснээр дараа дараагийн ТББ-ууд энэхүү буруу жишигт үндэслэн нэхэмжлэл гаргах, түүнийг нь шүүх хүлээн авахгүй байх, цаашлаад нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах эрхээ хэрэгжүүлж чадахгүйд хүрэх эрсдэлтэй байна.

2.1.2 Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар тогтоосныг хэрэглэсэн талаар

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд 2010 онд нэмэлт өөрчлөлт оруулснаар байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий ТББ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болсон юм. Ийнхүү ТББ-ууд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэх эрхтэй болохыг анх удаа хуульчлан баталгаажуулсан нь 2016 оноос өмнө нийтийн ашиг сонирхол, тэр дундаа байгаль орчны хохирлыг нэхэмжлэх чиглэлээрх ТББ-уудын нэхэмжлэлийн цорын ганц гэж хэлж болох үндэслэл болж байлаа.





Судалгаанд хамрагдсан дараах тохиолдлуудад нэхэмжлэгч ТББ нь нэхэмжлэл гаргах эрхтэй болохоо Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дээрх заалтыг үндэслэн тодорхойлсон байх ба шүүх ч мөн уг заалтыг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгтэй хамт давхар баримталж шийдвэрлэсэн байна. (*Хавсралт 1. Шийдвэр 8-ыг үзнэ үү*).

Харин өөр нэг тохиолдолд (*Хавсралт 1. Шийдвэр 9-ийг үзнэ үү*), ЗХШХШТХ мөрдөгдөж эхэлснээс 20 орчим хоногийн дараа гарсан шүүхийн нэгэн шийдвэрт нэхэмжлэгч “Д” ТББ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1-ийг үндэслэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхтэй болохоо тайлбарласан байна. Энэ тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах нэхэмжлэлийн шаардлага гаргасан нь “байгаль орчны хохирлыг нэхэмжлэх” гэсэн тус заалтын агуулгад хамаарахгүй байв. Гэвч шүүх нийтийн ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх ямар үндэслэлээр үүсэж байгааг тайлбарлалгүй хэргийг шийдвэрлэжээ. Түүнчлэн шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “*хууль болон нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн нь тогтоогдохгүй байх тул түүнийг хүчингүй болгох үндэслэлгүй гэж шүүх дүгнэв*” гэсэн нь нийтийн ашиг сонирхлын маргаанд субъектив эрх зөрчигдсөн байхыг шаардаж, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32.1.1 болон ЗХШХШТХ-ийн 18.3 дахь хэсгийн аль алинд заагаагүй шаардлага тавьжээ. Эсхүл шүүх нэхэмжлэгчийн эрх гэдгийг энэ маргааны тухайд хэрхэн ойлгож байгаагаа тайлбарлах шаардлагатай. Нэхэмжлэлийг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг дагаж мөрдөгдөхөөс өмнө гаргасан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль хэрэгжиж эхэлсний дараа явагджээ. Гэтэл шүүх уг хэргийг шийдвэрлэхдээ нэхэмжлэх эрхийг дээрх заалттай холбон тайлбарлаагүй байна. Шүүх энэ асуудалд дүгнэлт хийгээгүй учир ТББ нь ЗХШХШТХ-ийн 18.3-т заасан шаардлагыг хангаагүй боловч Байгаль орчныг хамгаалах хуулийн 32 дугаар зүйл заалтыг баримтлан нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар захиргааны хэргийн шүүхэд хандах боломжтой гэсэн ойлголттой болж байгаа юм. Энэхүү хууль хэрэглээний асуудлаар бид тайлангийн дүгнэлт хэсэгт дурдсан болно.



2.1.3 Хангалттай сонирхол илэрхийлсэн байх, нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй тухай хуульд заасан шаардлага

ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 болон 52 дугаар зүйлийн 52.5.5-д тус тус зааснаар ТББ нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэлийн шаардлагыг дүрмийн зорилгод нийцүүлж тодорхойлох, дүрмийн зорилгын дагуу сүүлийн 3 жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх, тухайн асуудлаар нэхэмжлэл гаргах хангалттай сонирхол илэрхийлсэн байх, нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн эсхүл зөрчигдөж болзошгүй талаар нэхэмжлэлдээ тодорхой дурдах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, эдгээр нь нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэх хууль зүйн гол үндэслэл болох учиртай.

ЗХШХШТХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.5-д заасан зохицуулалт нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэлийн хамгийн гол бөгөөд онцлог шаардлага юм. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн хийгээд зөрчигдөж болзошгүй нөхцөл байдлын талаар шүүхэд хандах ба шүүх шийдвэр гаргахдаа түүнд бодит дүгнэлт өгөх учиртай. Гэтэл нэг талаараа шүүхийн шийдвэрт тухайн маргаан хуульд заасан 4 агуулга бүхий нийтийн ашиг сонирхлын аль нь болох, түүнийг ягаад нийтийн ашиг сонирхлын маргаан гэж үзэж байгаагаа тэр бүр нарийвчлан тодорхойлдоггүй байна. Нөгөө талаар, нэхэмжлэгч талаас ч нийтийн ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж байгаа болон зөрчигдөж болзошгүй тухай үндэслэлээ мөн хангалттай тодорхой илэрхийлж чаддаггүй. Ингэснээр нэхэмжлэгч ТББ-ууд болон шүүхээс маргаан бүхий захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэхэд гол анхаарлаа хандуулж, тухайн зөрчигдсөн буюу зөрчигдөж болзошгүй нийтийн ашиг сонирхолд төдийлөн анхаарал хандуулдаггүй нөхцөл ажиглагдаж байна. Тодруулбал, хүрээлэн буй орчны талаарх маргаанд хариуцагч захиргааны байгууллагаас гаргасан акт, түүнийг гаргах процесс, гуравдагч этгээдийн ашиг сонирхол зэрэгтэй холбоотой баримтын хүрээнд л мэтгэлцэж, маргааныг шийдвэрлэдэг. Нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй шүүхийн шийдвэрийн тухайд ч мөн адил захиргааны акт нь хуульд заасан нөхцөл журмын дагуу гарсан бол түүнийг





хууль зөрчөөгүй буюу нийтийн ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэж нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй байдаг. Энэ нь захиргааны акт, үйл ажиллагаа нь агуулга, үйл явцын хувьд хууль зөрчөөгүй боловч нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, эсвэл зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүсгэж байгаа тохиолдлыг шүүхэд нэхэмжлэх, шүүх нь нийтийн ашиг сонирхлыг сэргээн хамгаалах зэрэг энэ төрлийн нэхэмжлэлийн үндсэн зорилго, ач холбогдлыг бууруулах эрсдэл дагуулж байна.

Захиргааны акт, гэрээ, хэм хэмжээний акт, эс үйлдэл нь хууль бус байснаар нийтийн ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж байгаа хийгээд зөрчигдөж болзошгүй, нэхэмжлэлийн шаардлагыг хангаснаар нийтийн ашиг сонирхол хэрхэн сэргэж хамгаалагдах талаар шүүх бүрэн дүгнэлт хийдэггүй. Жишээлбэл, дараах тохиолдолд нэхэмжлэгчийн зүгээс компаниудын хууль бус үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчин, хүний амь, нийтийн ашиг сонирхол, эрүүл мэндэд ямар хохирол учруулж байгаа талаар нэхэмжлэлдээ дурдсан байх боловч шүүх шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт энэ талаар дүгнэлт хийгээгүй буюу компаниудын үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхол, хүрээлэн буй орчинд ямар хохирол учруулсан болоод учруулах эрсдэлтэйг огт тайлбарлалгүй орхижээ. *“Шүүх шийдвэр гаргахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн үйл ажиллагаа явуулж буй талбай нь НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай 50 дугаар тогтоолоор батлагдсан хамгаалалтын бүстэй давхцаж байгаа тул тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо”* гэж дүгнэсэн (Хавсралт 1. Шийдвэр 3-ыг үзнэ үү). Өөрөөр хэлбэл, шүүхийн уг шийдвэрийг НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолтой давхцаж байгаа нь хууль зөрчиж байна, ийнхүү хууль зөрчиж байгаа нь нийтийн ашиг сонирхлыг зөрчиж байна гэж ойлгож болохоор байна.

Судалгаанд хамрагдсан нийт шүүхийн шийдвэртэй танилцахад нийтийн ашиг сонирхлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь өнөөдрийн байдлаар шүүхэд нэхэмжлэл гаргахаас бусад шатанд субъектив эрхийн маргааныхтай адил байгаа бөгөөд нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх, түүнийг сэргээн хамгаалах, зөрчлөөс сэргийлэхэд чиглэсэн онцлог зүйл ажиглагдахгүй байна. Ийнхүү



шүүхээс нийтийн ашиг сонирхлын хэргийг хянан шийдвэрлэхдээ нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл байдалд анхаарал хандуулахгүй байгаа нь нэхэмжлэл хүлээн авах, захиргааны хэрэг үүсгэх гэх мэт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үе шатуудад ч буруу жишиг тогтоох үр дагавартай байна. Тухайлбал, нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэлийг хүлээн авах, захиргааны хэрэг үүсгэх шатанд нэхэмжлэгч нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй юу, түүнийгээ нотолж чадах эсэхэд голчлон анхаарч, нийтийн ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй байдлыг үнэлдэггүй явдал нийтлэг байна. Энэ нь цаашлаад энэ төрлийн өмгөөллийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна эцсийн дүндээ нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд сэргээн хамгаалах захиргааны хэргийн шүүхийн зорилго, ач холбогдлыг бууруулах сөрөг нөлөөтэй.

Түүнчлэн нөгөө талаас, зарим ТББ-ын нэхэмжлэл гаргах болсон шалтгаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байдал, шүүхийн хэлэлцүүлгийн явц дахь тайлбар зэрэг нь хэт субъектив байсныг ч энд бас тэмдэглэх нь зүйтэй. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалахдаа “чинхүү нийт олны төлөө, хоёргүй сэтгэлээр”, мэргэжлийн үүднээс хандах чухал юм.

2.1.4 ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн хэрэглээ

ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3-т “Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргана...” гэж заасны дагуу нийтийн ашиг сонирхолтой холбоотой маргааныг шийдвэрлэхэд хууль хэрэглээний хувьд анхаарвал зохих зарим зүйл ажиглагдсан болно. Нэхэмжлэгч эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, тодорхой үйлдэл хийхийг даалгах, хууль бус актыг хүчингүй болгох зэрэг нэхэмжлэлийн шаардлага гаргасан байхад шүүх зөвхөн 106 дугаар зүйлийн 106.3.13-т зааснаар “*нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох*”, эсхүл 106.3.12-т заасны “*нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангах*” гэсэн заалтыг хэрэглэсэн байдаг (*Хавсралт 1. Шийдвэр 5 болон 7-г тус тус үзнэ үү*). Шүүгч шийдвэртээ материаллаг хуулийг хэрэглэсэн боловч





нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэж байгаагийнхаа хувьд захиргааны шийдвэр, үйл ажиллагаа, эс үйлдэхүйг шүүх хэрхэн дүгнэж байгаагаа буюу ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн нийтийн ашиг сонирхолтой холбогдуулан 106.3.4, 106.3.10 болон бусад зүйл заалтыг хэрэглээгүй тохиолдол ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж гаргасан нэхэмжлэлд нийтийн ашиг сонирхолтой холбоотой хуулийн зүйл заалт болоод бусад заалтыг тайлбарлан хэрэглээгүй. Түүнчлэн шүүх ЗХШХШТХ-ийн 106.3.2 “захиргааны акт, захиргааны гэрээ нь илт хууль бус болохыг тогтоох” гэсэн заалтыг баримталсан боловч Захиргааны ерөнхий хуулийн 55 дугаар зүйлд заасан захиргааны гэрээ илт хууль бус болох тухай 14 үндэслэлээс аль нь энэхүү хэрэг маргаанд хамааралтай болох талаар дүгнэлт хийгээгүй байна. (*Хавсралт 1. Шийдвэр 2-ыг үзнэ үү*).

2.2 ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ БАЙДАЛ

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс зөв жишиг тогтоох, хуулийг нийтийн ашиг сонирхлын үүднээс зөв бөгөөд бүтээлчээр тайлбарлах, улмаар энэ төрлийн үйл ажиллагааны цаашдын хөгжилд хувь нэмэр оруулахуйц дүгнэлтүүдийг өгсөн тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал,

- Нийтийн өмч гэдэгт төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас төрд учруулсан хохирлыг хамааруулан ойлгож болохыг шүүхийн шийдвэрээр тогтоожээ. (*Хавсралт 1. Шийдвэр 6-г үзнэ үү*). Энэ нь өргөн агуулгаараа нийтийн өмчид төсвийн хөрөнгийг багтаах гэсэн агуулгаар тайлбарлах боломжийг олгосон чухал шийдвэр юм. Учир нь нийтийн өмч гэсэн ойлголтод сүм хийд, дурсгалт газар, байгууламжийг нийтлэг ойлгож ирсэн ба төсвийн хөрөнгийн асуудлыг хамруулах эсэх талаар судлаачдын дунд нэгдсэн ойлголт бий болоогүй байсан билээ.² Энэ шийдвэрийн тухайд улсын төсвийн хөрөнгийн

² Нээлттэй Нийгэм Форум., Шүүхийн шийдвэрийн шинжилгээ, УБ., 2018 он., 50-р тал



асуудлаар нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд хандсаныг буруутгаагүй нь цаашид улсын төсвийн захиран зарцуулалттай холбоотой асуудлаар захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах боломжтойг харуулж байна.

- “ЕБС-ийн 1-5 дугаар ангийн “Иргэний боловсрол (ёс суртахууны унших эх)” сурах бичгийг Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичиг зохиох, хэвлүүлэх, тцгээх журмын дагуу бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах MNS5418:2008 стандарт шаардлагад нийцүүлэн дахин зохиож хэрэглээнд нэвтрүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд даалгах” гэсэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн (Хавсралт. Шийдвэр 7-г үзнэ үү) тохиолдол байна. Энэ шийдвэр нь ЗХШХШТХ-ийн 18.3-т заасан хүүхдийн эрх гэсэн агуулгыг цаашид өргөн хүрээнд тайлбарлан хэрэглэж, хүүхдийн эрхийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах боломжтойг харуулсан бөгөөд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах агуулгыг баяжуулахад чухал ач холбогдолтой юм.
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог хангаагүй нь нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэж шийдвэрлэжээ. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог хангах нь уул уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаанд иргэдийн хяналтыг дээшлүүлэх, цаашлаад байгаль орчныг хариуцлагагүй уул уурхайгаас хамгаалах, нутгийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ нь нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл шүүхэд хандах боломжтой болохыг харуулсан шийдвэр юм. Нэхэмжлэгч шүүхэд хандахдаа нарийвчилсан үнэлгээнд иргэдийн оролцоог хангаагүй нь хуульд заасан процессыг зөрчсөн, төсөл хэрэгжсэн нөхцөлд байгаль орчинд хохирол учрах эрсдэлтэй гэж маргасан. Ингэхдээ үнэлгээ хийсэн байгууллагын дүгнэлт хийсэн арга зүйг няцаах судалгаа баримт шүүхэд ирүүлээгүй байна. Шүүх үүнийг мэргэжлийн байгууллага үнэлгээ хийсэн тул аливаа эрсдэл гарсан нөхцөлд тухайн байгууллага хариуцна хэмээн үзэж шийдвэрлэсэн байна.





Үүнээс үзэхэд цаашид байгаль орчны нарийвчилсан үнэлгээний талаарх маргаанд хэдийгээр үнэлгээ хийх үйл явц процессын дагуу явсан боловч үнэлгээг арга зүйн хувьд буруу хийгдсэн, энэ нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц байна гэсэн асуудлаар шүүхэд хандах боломжтой байна. Шүүхийн шийдвэрт хэрэв хариуцагч хуульд нийцүүлэн 2 сарын хугацаанд дахин шинэ акт гаргаагүй нөхцөлд одоо үйлчилж буй байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэр хүчингүй болохоор заажээ. Ингэснээр нарийвчилсан үнэлгээг дахин хийх, түүнийг мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулах үйл явцад ТББ, иргэд идэвхтэй оролцож, үнэлгээ хийх арга зүйн талаар санал, тайлбар гаргах боломжтой байна. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд олон нийт, иргэд, ТББ идэвхтэй оролцох нь байгаль орчинд учрах эрсдэлийг хамгийн анхан шатны түвшинд зардал багатайгаар бууруулах боломж тул энэ шийдвэрийн тухайд байгаль орчны нарийвчилсан үнэлгээг захиргааны акт, үйл ажиллагаа гэж үзэн захиргааны хэргийн шүүхийн хяналтад оруулж ирсэн нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үйл хэрэгт чухал ач холбогдолтой тохиолдол болсон гэж үзэх үндэстэй байна (*Хавсралт 1. Шийдвэр 11-ийг үзнэ үү*).

- Төрийн байгууллагад хэм хэмжээний акт гаргахыг даалгах нэхэмжлэлийн шаардлага гаргах боломжийг нээсэн шүүхийн шийдвэр: Тухайн төрийн байгууллага нь хуулиар хэм хэмжээний акт батлан гаргах эрхийг шилжүүлэн авсан боловч түүнийгээ хэрэгжүүлээгүй эс үйлдэхүй гаргасан, түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн бол хэм хэмжээний акт гаргуулахыг даалгах агуулгатай нэхэмжлэл гаргах жишгийг шүүхийн шийдвэрээр бий болгожээ. (*Хавсралт 1. Шийдвэр 4-ийг үзнэ үү*).
- Түүнчлэн, нийтийн ашиг сонирхлыг зөвхөн захиргааны актын хүрээнд бус мөн захиргааны гэрээ нь нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл түүнийг хүчингүй болгох боломжтой болохыг шүүхийн шийдвэрээр харуулсан болно. (*Хавсралт 1. Шийдвэр 2-ыг үзнэ үү*).



2.3 ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХОД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэсэн хэдий ч шүүхийн хэлэлцүүлгийн явцад хүлээн авахаас татгалзах нөхцөл байдал илэрсний улмаас хэргийг хэрэгсэхгүй болгосон хоёр тохиолдол байна. Тухайлбал, нэхэмжлэгч ТББ нь сүүлийн 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан болохоо хангалттай нотолж чадаагүй, дүрэмдээ өөрчлөлт оруулаад 3 жил болоогүй байхдаа нийтийн ашиг сонирхлын хүрээнд нэхэмжлэл гаргасан зэрэг шалтгаанаар татгалзсан байдаг. Энэ нь ТББ-ын хувьд цаг хугацаа алдсан, илүү үргүй зардал болох тул нэхэмжлэл гаргахаасаа өмнө эдгээр зүйл баримтыг сайтар анхаарч шалган эрсдэлийг урьдчилан тооцоолох нь чухал юм.

Тэрчлэн нэхэмжлэлийн шаардлага хангаагүй гэж үзэх өөр нэг үндэслэл нь маргаан бүхий захиргааны шийдвэрийг шүүх хуульд нийцсэн гэж үзсэн тул түүнийг хүчингүй болгох тухай нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй байх явдал юм. Өөрөөр хэлбэл, захиргааны шийдвэр нь хуулийн дагуу гарсан учир нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн гэж шүүх үзээгүй тохиолдол байна. Хууль тогтоомжид заасан процедурын талаасаа захиргааны шийдвэр хуульд нийцсэн болохыг шүүх тогтоосон ба энэ нь тухайн шийдвэрийн гол үндэслэл болжээ. Тодруулбал, энд зөвхөн тухайн захиргааны шийдвэр хуульд нийцсэн эсэх тухай маргаан өрнөж байгаа юм. Үүнийг өмнө дурдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээтэй холбоотой жишээн дээр тайлбарлавал, захиргааны шийдвэр гаргах процесс хэдийгээр хуулийн дагуу явагдсан боловч (жишээлэхэд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог хангасан, хуульд заасны дагуу батлуулсан гэх мэт) үнэлгээ нь арга зүйн хувьд буруу, байгаль орчинд хохирол учруулах нь илт гэж үзвэл байгаль орчны шинжлэх ухааны үндэслэл бүхий бусад судалгаа, тайлан, туршилт зэрэг хууль тогтоомжийн бус үндэслэл, нотолгоог ашиглан нийтийн ашиг сонирхлын үүднээс зэрэг мэтгэлцэх боломжтой юм. Энэ төрлийн судалгаа дутмагаас нийтийн ашиг сонирхлыг бүрнээ хамгаалахад бэрхшээл тулгарч байна.



БҮЛЭГ III. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Энэ бүлэгт нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нэхэмжлэлтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй зарим асуудлыг хөндөж, түүнийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий зөвлөмж, дүгнэлтийг санал болгох болно. Тулгамдаж буй асуудлыг дараах агуулгаар авч үзлээ. Үүнд, (1) нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах эрхийн тухай ойлголт дутмаг байдал, (2) захиргааны хэргийн шүүхэд хандахад тулгамдаж буй асуудлууд, (3) нийтийн ашиг сонирхлын хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зарим асуудал зэрэг болно.

3.1 НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ШҮҮХЭД ТӨЛӨӨЛӨН ХАМГААЛАХ ЭРХИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Судалгааны хүрээнд цуглуулсан нэхэмжлэлүүдийг нийтийн ашиг сонирхолд хамааралтай байдлаар нь гурав ангилсан талаар өмнө нь дурдсан билээ. Энэ нь судалгааны ажлын үндсэн зорилго биш боловч ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн §18.3-т заасан агуулга, харилцааны талаар шүүхийн захиргааны зарим ажилтан, хуульч, эрх зүйч, ТББ-ын дунд хууль зүйн нэг мөр ойлголт бий болоогүйгээс ТББ л нэхэмжлэл гаргасан бол нийтийн ашиг сонирхолд холбоотой хэмээн андуурч, судалгааны мэдээлэл болгон ирүүлсэнтэй холбоотой. Иймд шүүхийн журмаар нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, энэ төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөгжүүлэхэд оролцогч талууд хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэж хэвших нь чухал байгааг дахин онцолж байна. Нийтийн ашиг сонирхолд **хамааралгүй** нэхэмжлэлийг авч үзэхэд дараах байдал ажиглагдаж байна.

- *Нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөх эрхгүй этгээдийн гаргасан нэхэмжлэл.* Судалгаанд ирүүлсэн мэдээнд СӨХ-ны оршин суугчдынхаа эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг нийтийн ашиг сонирхолд хамаатуулан ирүүлсэн байв. Өөрөөр хэлбэл, шүүхийн захиргааны ажилтан СӨХ-г нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд, нөгөө талаас оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн 18.3-т заасан нийтийн ашиг сонирхолтой хамтатган ойлгосон байна. СӨХ нь зөвхөн оршин суугч болох тодорхой хэсэг бүлэг этгээдийн эрхийг хамгаалах чиг үүрэгтэй бөгөөд хуулийн 18.3-т заасан шалгуурыг хангах субъект бус юм.
- *ТББ-ын гаргасан нэхэмжлэл бүрийг нийтийн ашиг сонирхолд хамаатуулан авч үзэх.* Нэхэмжлэгч нь ТББ бол түүний гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг нарийвчлан авч үзэлгүйгээр нийтийн ашиг сонирхолд шууд хамаатуулж мэдээнд ирүүлсэн тохиолдол байна. Гэтэл тухайн нэхэмжлэлийн шаардлагатай танилцахад нэхэмжлэгч нь хэдийгээр нийтийн ашиг сонирхлын төлөөлөн нэхэмжлэх эрхтэй байж болох ТББ мөн боловч нэхэмжлэлийн шаардлага нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах бус зөвхөн өөрийн байгууллагын зөрчигдсөн гэх эрх, ашиг сонирхлыг сэргээлгэх зорилготой байна. Үүнийг дараах жишээнээс харах боломжтой:

Жишээ 1: “Г” НҮТББ-аас “...манай ТББ-тай одоо зохион байгуулагдаагүй байгаа 6 толгой Алтайн угалз агнах гэрээг байгуулах, холбогдох тусгай зөвшөөрөл олгохыг БОАЖЯ-нд даалгах”, “Л” ТББ-аас “...манай ТББ-аас гаргасан хүсэлтийн дагуу газар ашиглах шийдвэр гаргахыг хариуцагчид даалгах”, “М” ТББ-аас “... манай ТББ-ыг эзэмшиж байгаа газраа чөлөөлөхийг шаардсан захирамжийг хүчингүй болгуулах” гэх мэт шаардлага бүхий нэхэмжлэлүүд буюу тухайн хуулийн этгээд зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд гаргасан нэхэмжлэлийг судалгаанд ирүүлсэн байна.

Жишээ 2: “ЛДРА” ТББ-аас гаргасан “Байгаль орчин, аялал жуулчлалын сайдыг хариуцагчаар татаж, тус байгууллагаас гаргасан





хүсэлтийн дагуу газар ашиглах шийдвэр гаргахыг хариуцагчид даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг мөн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой гэж үзсэн байх бөгөөд дээрх нэхэмжлэл нь угтаа нийтийн ашиг сонирхлыг хамгаалах бус харин уг ТББ дархан цаазат газрын тодорхой хэсэгт өөрийн санаачилсан төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой, хувийн ашиг сонирхлыг хөндсөн газрын маргаан юм.³

Жишээ 3: “Х” ТББ нь нэхэмжлэлдээ: “манай байгууллага 1998 онд байгуулагдсан, Монгол Улсад хүний эрхийг хангах, хамгаалах, нийт иргэдийн эрх ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах зорилготой ТББ юм. 2005 оноос эхлэн хүний эрх, байгаль орчны зөрчилтэй хэргүүдэд нийтийн эрх ашгийн өмгөөлөл, нөлөөллийн ажлуудыг хийж байна. Манай байгууллагаас 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдөр “Агаарын тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгаа тухай” тайлан мэдээлэл хүсэж, Монгол Улсын Засгийн газарт хандан өргөдөл гаргасан боловч өнөөдрийг хүртэл хариу ирээгүй байх тул Монгол Улсын Засгийн газрын эс үйлдэхгүйг хууль бус болохыг тогтоож, өргөдлийг шийдвэрлэн хариу өгөхийг даалгаж өгнө үү” гэжээ. Түүнчлэн нэхэмжлэлдээ “манай ТББ нь өөрийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргаж байх тул...” гэж тодотгосон байна.

Шууд бус хамааралтай нэхэмжлэлийн тухайд: Шууд бус хамааралтай нэхэмжлэл нь хэдийгээр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой боловч дор дурдсан шалтгаануудын улмаас нэхэмжлэл нь хуульд заасан шаардлага хангаагүй, улмаар шүүхэд нэхэмжлэлээ гаргаж шийдвэрлүүлж чадаагүй тохиолдлууд юм. Энэ нь нэхэмжлэл гаргаж буй ТББ, түүнд зөвлөгөө өгч ажиллаж буй хуульч, өмгөөлөгчийн нийтийн ашиг сонирхлын талаарх ойлголт, мэдлэг, ур чадвартай хамааралтай гэж үзэх үндэстэй. Дараах нийтлэг шалтгааны улмаас ТББ-аас шүүхэд гаргасан нэхэмжлэлийг нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгыг бүрнээ илэрхийлж чадаагүй гэж үзэж болохоор байна. Үүнд:

³ Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхийн 128/ШШ2018/0587 шүүхийн шийдвэрийг үзэх.



- *Хувийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилготой эсэх нь тодорхой бус байх.* ТББ нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх нэхэмжлэл гаргахдаа нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах хийгээд өөрийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах гэсэн хоёрдмол утгыг нэгэн зэрэг дурдсан нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болж байна. Нэхэмжлэгч нар нэхэмжлэлдээ нийтийн ашиг сонирхлыг хамгаалах талаар дурдсан боловч нэхэмжлэлийн шаардлагаа зөвхөн мэдээлэл авах байдлаар тодорхойлсон тохиолдол байх бөгөөд энэ үед шүүх нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойлох буюу нэхэмжлэгч шүүхээс юу хүсэж байгааг мэдэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна. Хэрэв ТББ зөвхөн мэдээлэл хүсэх шаардлага гаргаж байгаа тохиолдолд шүүх нийтийн ашиг сонирхлын хүрээнд бус зөвхөн мэдээлэл авах эрхийн зөрчил хэмээн үзэж маргааныг төрөөс мэдээлэл авах шаардлагын хүрээнд шийдэх билээ.

Энэ нь нөгөө талаас, ЗХШХШтХ-д нийтийн ашиг сонирхлыг явцуу хүрээнд (зөвхөн 4 чиглэлээр) хязгаарлан тодорхойлсонтой холбоотой байж болох юм. Тухайлбал, төрийн байгууллага хууль тогтоомжийн дагуу холбогдох мэдээллийг нийтэд ил тод болгоогүй буюу мэдээлэл авах эрх гэх мэт Үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн асуудлыг нийтийн ашиг сонирхлын зөрчилд тооцон шүүхэд төлөөлөн нэхэмжлэх эрхийг нээж өгөх нь чухал юм.

- *Өргөдөл, гомдолд хариу авах эрхийн хүрээнд гаргасан нэхэмжлэл.* Нийтийн ашиг сонирхлын төлөөлөх эрх бүхий этгээд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар захиргааны байгууллагад хандахад түүнд нь хариу өгөөгүй эс үйлдэхгүйг хууль бус болохыг тогтоолгох, хариу өгөхийг даалгах шаардлага бүхий нэхэмжлэл нь хуулийн 18.3-т хамаарахгүй гэж шүүх шийдэж байна. Учир нь тухайн маргаанд хөндөгдөж буй асуудал нь хэдийгээр нийтийн ашиг сонирхлын маргааны шинжтэй боловч хууль зүйн утгаараа захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэл нь тухайн нэхэмжлэгчийн мэдээлэл олж авах эрх чөлөөг хөндсөн байдаг. Гэвч мэдээлэл олж авахаар хандаж буй





ТББ-ын үйлдэл нь зөвхөн өөрийн дотоод хэрэгцээнд байхаас гадна нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, нийтэд захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлийн талаар мэдээлэх, цаашлаад хууль бус үйлдлийг таслан зогсоох, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар шүүхэд хандахаасаа өмнө баримт бүрдүүлэх зорилгоор хандах ч тохиолдол байж болно. Тухайлбал, “У” ТББ-ын нэхэмжлэлтэй, Монгол Улсын Засгийн газарт холбогдох хэрэгт⁴ нэхэмжлэгч нь Засгийн газраас утааны эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбоотой 10 төрлийн асуулт тавьж хариулт авахыг хүссэн боловч хариуцагч хариу ирүүлээгүйн улмаас шүүхэд хандсан. Асуултын агуулгад утаа бууруулж чадаагүйгээ тайлбарлаж тайлангаа тавих, утааны эсрэг яаралтай цогц арга хэмжээ авах ажлын хэсгийг яаралтай гаргаж мэдэгдэх, утааны эсрэг ямар хэмжээний төсөв зарцуулагдсаныг тайлагнах, утааны голомтод очиж нөхцөл байдал дээр Засгийн газар хуралдах зэрэг 10 асуултад хариу авахыг хүсжээ. Хэдийгээр асуултууд нь нийтийн ашиг сонирхлын шинжтэй байгаа хэдий ч нэхэмжлэлийн шаардлагын хувьд асуултдаа хариулт авах шаардлага байгаа тул хуулийн 18.3-т заасны дагуу нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэл гэж үзэхгүй. Хариуцагч ЗГ-ын төлөөлөгч нар шүүхэд тайлбарлахдаа, *“Нэхэмжлэгч ТББ-ын нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрч байна. Нэхэмжлэгчээс ирцүлсэн 2017 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн шаардлагад дурдсан 10 асуултын хариуг 2017 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн дотор ТББ-д хүргүүлэхийг зөвшөөрч байна”* гэжээ. Өөрөөр хэлбэл, ТББ-ын хүссэн мэдээллийг гаргаж өгөх нь нийтийн ашиг сонирхлыг шууд хамгаалахад чиглэхгүй юм.

- ТББ болон иргэд хамтран гаргасан нэхэмжлэлийн тухай. ТББ нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах агуулга бүхий нэхэмжлэл гаргахдаа нэр бүхий иргэдтэй хамтарсан байна. Энэ тохиолдолд ЗХШХШТХ-д зааснаар зөвхөн ТББ л нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй бөгөөд иргэдэд ийм эрх олгогдоогүй. Иймд

⁴ НЗХАШШ, 2017.07.17, 128/ШШ2017/0551



иргэд болон ТББ хамтран гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэхэд эргэлзээтэй байдал үүсэж байна. Тухайлбал захирамжид “... иргэд нэхэмжлэл гаргаж буй эсэх, эсхүл иргэдийн нэрийн өмнөөс итгэмжлэгдсэн төлөөлөгч иргэн нэхэмжлэл гаргаж байгаа эсэх, иргэдийг төлөөлөн төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргаж байгаа эсэхийг нэг мөр, тодорхой, ойлгомжтой болгон ирцүлэх нь зүйтэй байна” гэж дүгнэжээ (Хавсралт 2. Тохиолдол 1-ийг үзнэ үү).

Мөн иргэд өөрийн бэлчээр, нутаг орчим, хүрээлэн буй орчныг хамгаалж шүүхэд хандахдаа ТББ-д итгэмжлэл олгосон тохиолдол байна. Өөрөөр хэлбэл, иргэд хэдийгээр өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахаар шүүхэд хандсан ч ЗХШХШТХ-ийн 18.3-ыг ойлгохдоо хүрээлэн буй орчны асуудлыг нийт олон буюу нийтийн ашиг сонирхол гэж үзэн, түүнийг зөвхөн ТББ төлөөлөх эрхтэй гэж үзэн ТББ-д итгэмжлэл олгох замаар шүүхэд ханджээ. Уг нь иргэд өөрийн эрх ашгийг хамгаалах бол заавал ТББ гэлтгүй өөрсдийнхөө дундаас төлөөлөгч томилон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой билээ. Нэхэмжлэлийн шаардлагадаа иргэд өөрсдийн эрх ашгаар дамжуулан хүрээлэн буй нутаг орчмоо буюу нийтийн ашиг сонирхлыг хамгаалах шинжийг давхар агуулж бичсэн нь нэхэмжлэгчийн субъектив эрхийн зөрчлийг арилгах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах гэсэн 2 зорилгыг давхар илэрхийлж байна. Энэ нь шүүхээс тухайн нэхэмжлэлийн шаардлагыг зөв тодорхойлж, хэргийг шийдвэрлэхэд мөн бэрхшээл учруулж байна.

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэх ТББ-д тавих шаардлага буюу ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг мөр хэрэглэх практик тогтоогүй байгаа нь энэ чиглэлээр ажиллаж байгаа ТББ-уудад бэрхшээл үүсгэж байгааг тайлангийн өмнөх хэсэгт дурдсан билээ. Иймд ТББ-ууд дээрх шаардлагыг хангахгүй тохиолдолд тухайн асуудлаар эрх ашиг нь хөндөгдсөн иргэдийг төлөөлөн нэхэмжлэх замаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж байна. Энэ тохиолдолд нэхэмжлэлийн шаардлага нь





нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байгааг үл харгалзан зөвхөн нэхэмжлэгч нь ТББ буюу ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан этгээд бус гэсэн үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлага үүсэж байна. Ийнхүү нийтийн ашиг сонирхолд хамаарах асуудлыг нэхэмжлэгчээс хамааран тодорхойлж байгаа нь тэмдэгтийн хураамж, шүүхийн нөхөн төлөгдөх зардлаас чөлөөлөгдөх, хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тооцох зэрэг нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэгчийн хувьд эдлэх хуульд заасан бусад боломжийг эдлэх нөхцөлийг хязгаарлаж байна.

Иймд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэх ТББ-д тавьж буй шаардлагыг эргэн харах, нэг мөр ойлгон хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг зөвхөн ТББ-аас гадна тухайн асуудлаар хангалттай ашиг сонирхол илэрхийлэх бусад этгээд, тэр дундаа иргэд төлөөлөн нэхэмжлэх зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

- *Хуулиар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх олгогдоогүй этгээдийн гаргасан нэхэмжлэл.* Тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага (ИТХ) хийгээд (*Хавсралт 6. Тохиолдол 1-ийг үзнэ үү*), төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч (Засаг дарга) нар тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа нийт иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдол байх ба үүнийг өнөөгийн эрх зүйн орчны хүрээнд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтын хүрээнд нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл гэж тооцох боломжгүй байна. Харин Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 57 дугаар зүйлд “*Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус цйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцлийг болон байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүцлгэх, мал, амьтныг тухайн нутаг дэвсгэрээс шилжүүлэхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр сум, дүүргийн Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргана*”, 17 дугаар зүйлийн 17.2.9-д “*энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад*



заасан үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх” гэж заасны дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй. Энэ нь буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирол гаргуулахад илүү чиглэгдсэн зохицуулалт юм. Иймд орон нутгийн удирдлагууд ТББ-тай хамтран ажиллаж хуулийн 18.3-т заасан агуулгаар шүүхэд хандах боломжтой юм.

- ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан үндсэн дөрвөн агуулгаас бусад асуудлын хүрээнд нийтийн ашиг сонирхлыг хамгаалж гаргасан нэхэмжлэлийн тухайд. Судалгааны явцад иргэд хийгээд ТББ-аас нийт иргэдийн өдөр тутмын амьдралд шууд хамааралтай хот хоорондын тээврийн үйлчилгээг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, төрийн үйлчилгээ нь иргэдийн ая тухтай байдлыг алдагдуулсан агуулга бүхий шийдвэрийг хүчингүй болгуулахаар тус тус шүүхэд хандсан байдаг. Эдгээр асуудал нь хэдийгээр хуулийн 18.3-т заасан асуудлын хүрээнд биш ч хуульд нэмэлт оруулан захиргааны хэргийн шүүхийн хяналтын объект болгох хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. (Хавсралт 2. Тохиолдол 4 ба 5-ыг үзнэ үү).

Судалгааны хүрээнд нийт 24 нэхэмжлэлийг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т хамааралтай гэж үзсэн бөгөөд эдгээрээс 15 тохиолдолд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох, нэхэмжлэлийг буцаах, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж гарсан байна. Энэ нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар гаргасан нэхэмжлэлийн дийлэнх хувьд нийтлэг тохиолдож байгаа бөгөөд нэхэмжлэгч шүүхэд хандах, түүнийг хүлээн авах эсэх асуудлыг шийдвэрлэх үе шат нь ТББ-уудын хувьд хамгийн тулгамдсан асуудал болохыг харуулж байна.

Энэ бүлэгт шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахгүй байх нийтлэг шалтгааныг харуулахыг зорилго. Эдгээр нь зарим тохиолдолд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох хийгээд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн хувьд





давхацсан байна. Энэхүү дэд хэсгийг (1) нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох болон буцаах, (2) нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзах захирамжийн хүрээнд авч үзлээ.

3.2 БҮРДҮҮЛБЭР ХАНГУУЛАХААР ХУГАЦАА ТОГТООСОН БОЛОН НЭХЭМЖЛЭЛИЙГ БУЦААХ ЗАХИРАМЖИЙН ХҮРЭЭНД

ЗХШХШтХ-ийн 18.3-т шууд хамаарах 24 нэхэмжлэлийн 7-д нь бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон шүүгчийн захирамж гарсан ба бүрдүүлбэр хангаж ирүүлээгүй гэсэн үндэслэлээр 4 нэхэмжлэлийг буцаажээ. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон болон буцаасан 7 нэхэмжлэлийг нийтийн ашиг сонирхлын төрлөөр ангилбал:

Ашиг сонирхлын төрөл	Бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон нэхэмжлэлийн тоо	Буцаасан нэхэмжлэлийн тоо
Хүрээлэн буй орчин	3	2
Хүүхдийн эрх	2	0
Нийтийн эрүүл мэнд	1	1
Нийтийн өмч	1	1

3.2.1 Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон захирамжийн үндэслэл

ЗХШХШтХ-ийн 52 дугаар зүйлд нэхэмжлэлд тусгах зүйлийг дурдсан байдаг. Хэрэв нэхэмжлэгч 52 дугаар зүйлд заасан зүйлсийг нэхэмжлэлд бүрэн тусгаагүй буюу нэхэмжлэл нь хуульд заасан шаардлагыг хангаагүй бол түүнийг хүлээн авсан шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломжийг нэг удаа олгодог. Үүнийг хуульд зааснаар *нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох тухай захирамж* гэж нэрлэж байна. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон захирамжийн үндэслэлийг авч үзвэл (1) хариуцагчаа зөв тодорхойлж шүүхэд ирүүлээгүй, (2) ЗХШХШтХ-ийн 52 дугаар



зүйлийн 52.5.5-д “*нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй*” гэсэн шаардлагыг хангаагүй, (3) шүүхэд ирүүлсэн баримт хуулийн шаардлага хангаагүй, (4) ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шаардлагыг хангаагүй зэрэг болно.

- *Хариуцагчаа зөв тодорхойлж шүцхэд ирцүлээгүй.* Нэхэмжлэгч нь хариуцагчийг буруу тодорхойлж ирүүлсний улмаас нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар буцаасан байна. Тухайлбал, Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжоор тухайн асуудал эрхэлсэн сайд болон яам нь тусдаа эрх зүйн субъект болохыг мэдэлгүй хариуцагчийг буруу тодорхойлсон буюу нэхэмжлэлийн шаардлагад дурдсан асуудал нь хариуцагчаар татсан субъектийн эрхлэх асуудалд хамаарахгүй байсан гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг буцаажээ. (*Хавсралт 3, тохиолдол 1-ийг үзнэ үү*).

Энэ нь нэг талаас тухайн ТББ-ын өмгөөллийн тактик байж болохоос гадна нөгөө талаас захиргааны хэрэг маргаанд мэдээлэл, чадавх, эрх мэдлийн хувьд харилцан адилгүй талууд оролцдог, төрийн байгууллагын бүтэц тогтолцоо, түүнд орсон өөрчлөлтөөс хамааран төрийн байгууллага, албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүргийг тэр бүр оновчтой тодорхойлох боломжгүй байдгийг харгалзан Захиргааны хэргийн шүүх дэмжлэг үзүүлэх зохицуулалт бий. ЗХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд “*Хариуцагчаар татагдсан этгээд нэхэмжлэгчийн жинхэнэ хариуцагч биш болох нь тогтоогдвол түүнийг шүүгч нэхэмжлэгчийн зөвшөөрснөөр жинхэнэ хариуцагчаар солино. Нэхэмжлэгч хариуцагчийг солихыг зөвшөөрөөгүй бол шүүгч тухайн этгээдийг хамтран хариуцагчаар татан оролцуулна*” гэж заасан байдаг. Иймд дээрх тохиолдолд шүүх хуулиар хүлээсэн дээрх үүргээ хэрэгжүүлээгүй гэж үзэж болохоор байна.





- *ЗХШХШтХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.5⁵-д заасан шаардлагыг хангаагүй. Нэхэмжлэгчээс байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг хууль бусаар баталсан, хуульд заасан нөхцөл журмыг зөрчиж баталсан тул түүнийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байсныг шүүх “ЗХШХШтХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.5-д заасны дагуу нэхэмжлэгчийн болон нийтийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн хөндөгдөж байгаа болон уг маргаан бүхий актыг хүчингүй болгуулснаар тэдний ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн сэргэх талаар нэхэмжлэлдээ тодорхой дурдаагүй” гэж үзэж нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах захирамж гаргажээ. Судалгааны явцад шүүхээс захиргааны акт, эс үйлдэл нь нийтийн ашиг сонирхлыг хэрхэн зөрчиж байгааг яв цав нотлохыг төдийлөн шаардаж байгаагүй, нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэсэн л бол цаашид хууль зөрчсөн эсэх асуудлыг шалгах байдлаар буюу төрийн байгууллага, албан тушаалтан хууль зөрчсөн гэдэг нь агуулгаараа нийтийн ашиг сонирхлыг зөрчиж байна гэж тайлбарлаж байгаа нь ажиглагдсан. Өөрөөр хэлбэл, шүүх нэхэмжлэлийг хүлээн авах эсэхийг шийдэхдээ хуулийн 52.5.5 дахь заалтыг нарийн баримтлах боловч хэргийг шийдвэрлэхдээ энэ заалтыг төдийлөн хэрэглэхгүй байгаа юм. Гэхдээ энэ нь ТББ нэхэмжлэлийн агуулгадаа нийтийн ашиг сонирхлын зөрчлийг дурдах шаардлагагүй гэсэн үг биш юм. ТББ нь бодит байдалд тулгуурлан нэхэмжлэлийн шаардлагаа нийтийн ашиг сонирхол, өөрийн дүрмийн зорилготой холбон ойлгомжтой, тодорхой тайлбарлах шаардлагатай ба боломжит бүхий л баримтаар дэмжих нь зайлшгүй юм. Учир нь энэ бол нийтийн ашиг сонирхлын маргааны гол онцлог билээ (Хавсралт 3, тохиолдол 2-ыг үзнэ үү).*

⁵ ЗХШХШтХ-ийн 52.5.5 “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй”



- *Шүүхэд ирүүлсэн баримт хуулийн шаардлага хангаагүй.* ТББ-ын үүсгэн байгуулах баримт бичгийг шүүхэд ирүүлээгүй, ирүүлсэн хэдий боловч хүчин төгөлдөр эсэх нь эргэлзээтэй, нэхэмжлэлд гарын үсэг зурсан этгээд нь ТББ-ыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй болохоо нотлоогүй, түүгээр зогсохгүй нэхэмжлэл гаргасан ТББ нь улсын бүртгэлд бүртгэлтэй эсэх нь тодорхойгүй баримт бичгийг бүрдүүлэн шүүхэд ирүүлснээс нэхэмжлэлийг буцаасан тохиолдол ажиглагдсан (*Хавсралт 3, тохиолдол 2 ба 3-ыг үзнэ үү*).
- *ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шаардлагыг хангасан эсэх нь нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангуулахаар хугацаа тогтоох хийгээд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн аль алиных нь үндэслэл болж байна.* Энэ талаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах гэсэн хэсэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

3.2.2 Нэхэмжлэлийг буцаах тухай захирамжийн үндэслэл

Нэхэмжлэгч шүүхээс тогтоосон хугацаанд бүрдүүлбэрийг хангаж шүүхэд ирүүлээгүй бол ЗХШХШТХ-ийн 53 дугаар зүйлийн 53.4-т “*нэхэмжлэгч тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй бол уг нэхэмжлэлийг шүүгч буцаана*” гэж заасны дагуу буцаадаг. Гэхдээ энэ тохиолдолд ТББ-ууд ихэвчлэн нэхэмжлэлээ дахин боловсруулж шүүхэд шинээр хандах замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үргэлжлүүлэн оролцсон байдаг.

Нэхэмжлэгчээс бүрдүүлбэр хангасан гэж үзэн шүүхэд ирүүлсэн баримт, тайлбар нь ЗХШХШТХ-ийн 52 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй бол нэхэмжлэлийг мөн буцаадаг байна. Шүүхээс нэхэмжлэлийг буцаасан нь нэхэмжлэгч шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлахгүй. Тухайлбал, шүүх нэхэмжлэгчээс 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан тухай баримтад татварын тайлан шаардаж бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон боловч нэхэмжлэгч уг тогтоосон хугацаанд багтаж





татварын байгууллагаас тайлангийнхаа хуулбарыг авч чадаагүй тул бүрдүүлбэрийг хангах боломжгүй байна гэсэн тайлбарыг шүүхэд өгсөн байдаг. Энэ тохиолдолд нэхэмжлэгч татварын байгууллагаас тайланг авсан нөхцөлд дахин шүүхэд хандах эрхтэй. Түүнчлэн буцаах захирамжид *“нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох тухай шүүгчийн захирамжийн хүрээнд тогтоосон хугацаанд нэхэмжлэлээ дахин гаргаж ирүүлсэн байх боловч бүрдүүлбэрийн шаардлагын зарим хэсэг тодорхой бус, гүйцэд биш байх тул нэхэмжлэлийг буцааж шийдвэрлэв”* гэсэн байх ба нэхэмжлэгч ямар баримтыг бүрдүүлэх, бүрдүүлбэрийг хэрхэн хангах талаар заалгүйгээр ийнхүү хэт ерөнхий дүгнэлт хийн буцаах нь учир дутагдалтай (*Хавсралт 4, тохиолдол 1 ба 2-ыг үзнэ үү*).

Энэ захирамжийн тухайд зөвхөн нийтийн ашиг сонирхлын маргаанд хамааралтай гэхээсээ илүү захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэг үндсэн хэсэг юм. Харин нийтийн ашиг сонирхлын маргаанд хамааралтай талаас нь авч үзвэл зарим шүүгч татварын тайлан шаардах, зарим нь шаардахгүй байх гэхчлэн хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-ыг шүүх харилцан адилгүй ойлгож, хэрэглэж байгаад асуудлын мөн чанар оршиж байгаа юм.

3.2.3 Шүүхээс бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон хийгээд нэхэмжлэлийг буцаасан захирамжтай холбоотой дүгнэлт

Нэхэмжлэгч ТББ, тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч нартай хийсэн уулзалт, ярилцлага болоод судалгааны явцад нэхэмжлэлийг бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох, буцаах захирамж, бусад баримтад хийсэн судалгаанаас дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Шүүх нэг нэхэмжлэлд өөр өөр үндэслэлээр удаа дараа нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох захирамж гаргадаг. Өөрөөр хэлбэл, нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн эсэхийг хангалттай илэрхийлэх, 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан болохоо нотлох гэх мэт шүүгчийн захирамжид дурдсан бүрдүүлбэрийг ханган шүүхэд хүргүүлмэгц



дахин өөр үндэслэлээр бүрдүүлбэр хангуулах захирамж гаргадаг байна. Энэ нь зөвхөн хуулийн 18.3-т заасан агуулга бүхий хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ч бус ерөөс нийтлэг байгаа нь нэхэмжлэгч нарыг чирэгдүүлэх, цаашлаад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар дахин шүүхэд хандах эрмэлзлийг бууруулах сөрөг үр дагавартай.

- Бүрдүүлбэр хангуулах шаардлага нь төрийн байгууллага, бусад байгууллагаас баримт, мэдээлэл гаргуулахтай холбоотой тохиолдолд 7-14 хоног нь хэт богино байна. Жишээ нь, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар 30 хүртэл хоногт багтаан хүсэлт, гомдолд хариу өгөх зохицуулалт нь дээрх хугацаатай уялдахгүй байгаа юм. Гэхдээ энэ нь захиргааны хэрэг үүсгэхээс өмнөх үе шат тул шүүх нэхэмжлэлийг буцаасан хийгээд хүлээн авахаас татгалзсан ч шаардлагатай баримтаа бүрдүүлсний дараа дахин нэхэмжлэл гаргах боломж нээлттэй байдаг. Иймд бүрдүүлбэр хангуулахаар тогтоосон хугацаа 7-14 хоног байгаа нь нэхэмжлэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагаас мэдээлэл өгөхийг хүлээх хийгээд тэрхүү мэдээлэл гармагц шүүхэд дахин нэхэмжлэл гаргах нь нэхэмжлэгчийн эрхийг дордуулах эрсдэл харьцангуй бага юм.
- Хэд хэдэн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон тохиолдолд, чухам аль бүрдүүлбэрийг хангасан, эс хангасан талаарх тайлбар, үндэслэлийг захирамжид тодорхой тусгахгүй байна.
- Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох хийгээд буцаах захирамжид нэхэмжлэгчийн гаргасан алдаа, зөрчлийг дурдаж байгаа боловч түүнийг хэрхэн залруулах талаар тайлбарлахгүй байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч шүүхэд дахин нэхэмжлэл гаргахдаа бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох болон буцаах захирамжид дурдсан зөрчлийг арилгаж гэмээнэ шүүх нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэдэг. Гэтэл захирамж өөрөө тодорхойгүй гарснаар нэхэмжлэгч өмнө нь ямар алдаа гаргасан, түүнийгээ хэрхэн залруулахыг мэдэх





боломж хумигдаж, дахин гаргасан нэхэмжлэл мөн л буцаагдах эрсдэлийг бий болгож байна. Хэдийгээр ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “*нэхэмжлэлийг энэ хуулийн 54.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг дахин гаргах, эсхүл хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж, нэхэмжлэлийг буцаана*” гэж заасан нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжид хамаарч байгаа боловч бүрдүүлбэр хангуулах болон буцаах захирамжид ч энэхүү заалтыг нэгэн адил хэрэгжүүлэх нь зүйтэй. Түүнчлэн захирамжид алдааг хэрхэн залруулах талаар тайлбарлаагүйгээс шүүгч ямар фактыг бүрдүүлбэр хангасан эсхүл хангаагүй гэж үзэхийг субъектив байдлаар үнэлэх боломжийг өөртөө бий болгож байна. Хэрэв захирамж тодорхой бол нэхэмжлэгчийн зүгээс захирамжид заасны дагуу залруулга хийсэн хэмээн шүүхэд мэтгэлцэх боломжтой болж улмаар субъектив байдлаар хандах хандлагыг бууруулах юм.

- Түүнчлэн шүүгчийн захирамжид: “*энэхүц нэхэмжлэлийг буцаасан шүүгчийн захирамжийг нэхэмжлэгч мэдсэн буюу гардан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тус шүүхийн шүүгчийн ... дугаар бүхий захирамжид заасан шаардлага, бүрдүцлбэрийг болон энэ захирамжид заасан шаардлага бүрдүцлбэрийг ханган тус шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрх нээлттэй гэжээ*”⁶ ЗХШХШтХ-д бүрдүүлбэр хангаагүйн улмаас буцаасан нөхцөлд 30 хоногийн дотор дахин нэхэмжлэл гаргана гэсэн хугацааны хязгаарлалт бүхий зохицуулалт байхгүй. ЗХШХШтХ-ийн 14 дүгээр зүйлд шууд шүүхэд хандах агуулга бүхий зохицуулалт байгаа боловч энэ тохиолдолд хамаарахгүй юм. Захиргааны хэргийн шүүхийн практикт нэхэмжлэгч шүүх хуралдаанд ирээгүйн улмаас нэхэмжлэлийг буцаасан нөхцөлд дахин нэхэмжлэл гаргах хугацааг 30 хоногоор хязгаарлаж болох бөгөөд энэ хязгаарлалт нь хууль ёсны эсэх нь маргаан дагуулдаг. Шүүх хэрэв дахин нэхэмжлэл гаргах хугацааг ийнхүү 30 хоногоор хязгаарлаж гэмээнэ нийтийн ашиг сонирхлыг

⁶ НЗХАШШ, 2018.06.11-ны өдрийн 128/ШЗ2018/3706 дугаар захирамж



хамгаалах маргаанд нэлээд ноцтой үр дагавар үүсгэж мэдэх юм. Учир нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэлийн хувьд ТББ нь хуульд заасан 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй байна гэсэн үндэслэлээр захирамж гарган нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хийгээд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах явдал нийтлэг гарч байна. Жишээлэхэд, ТББ анх удаа нэхэмжлэл гаргаад буцаагдсанаас хойш нэг жилийн дараа 3 жил гэсэн болзлыг ханган дахин шүүхэд хандахад анхны нэхэмжлэлийг буцааснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд хандах ёстой байсан хэмээн дахин буцаах болж байна. Судалгаанд хамрагдсан захирамжуудын хүрээнд хугацааны хязгаарлалт тогтоосон нэг л тохиолдол байснаас үзэхэд энэ нь зөвхөн тухайн шүүгчийн хууль хэрэглээний асуудал байсан гэж үзэх үндэстэй юм.

- Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүйн улмаас буцаахдаа тодорхой бус, гүйцэд биш гэсэн үндэслэлээр буцааж байгаа нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж, нэхэмжлэгч зөрчлийг арилгасан гэж үзээд дахин шүүхэд хандахад мөн л буцаагдах эрсдэлийг бий болгож байна. Нөгөө талаар, энэхүү захирамжийн үндэслэл хэт ерөнхий, товч байгаа юм. Шүүхээс нэхэмжлэлийг буцаасан захирамжийн хамтаар бүрдүүлсэн материалыг нэхэмжлэгчид буцаан олгодог тул судалгааны хүрээнд зөвхөн захирамжаас гол мэдээллийг авч дүгнэлт хийх шаардлага гарсан болно. Гэвч зарим захирамж, тогтоол өөрөө хэт ерөнхий байгаа нь судалгааны ач холбогдол, цаашлаад шийдвэр хууль ёсны байх зарчимд ч нийцэхгүй юм.
- Дээрхээс үзэхэд шаардлага хангаагүй баримт шүүхэд ирүүлэх, нэхэмжлэл гаргах эрхтэй болохоо хангалттай нотлоогүй зэрэг асуудал нь ТББ-ын зохион байгуулалт, чадавхтай холбоотой байна. Харин шүүхээс нийтийн ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж буйг тайлбарлахыг нэхэмжлэгчээс шаардаж буйг буруутгах аргагүй боловч шүүхийн шийдвэрт энэ талаар хангалттай дүгнэлт хийдэггүй, нийтийн ашиг сонирхлын бус ердийн маргааны нэгэн адил хэлэлцүүлэг өрнөж, шүүхийн шийдвэр бичигддэг. Энэ нь шүүх нэгдмэл биш байгааг илэрхийлж байгаа юм.





ТББ нь хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангаагүй үндэслэлээр бүрдүүлбэр хангуулахаар буцаасантай холбоотой дүгнэлтийг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн дүгнэлт хэсэгт нэгтгэн оруулсан болно.

3.3 НЭХЭМЖЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ ЗАХИРАМЖИЙН ХҮРЭЭНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийг зохицуулсан. Нэхэмжлэл нь хуулийн 54 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж шүүх үзвэл хүлээн авахаас татгалзана. Гэхдээ нэхэмжлэгч ийнхүү хүлээн авахаас татгалзсан шалтгааныг арилган дахин шүүхэд хандах эрхтэй.

ЗХШХШтХ-ийн 18.3-т хамааралтай 24 нэхэмжлэл шүүхэд гаргасны 8 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр, захирамж гарсан байна. Эдгээрийг нийтийн ашиг сонирхлыг хамгаалах байдлаар авч үзвэл:

Ашиг сонирхлын төрөл	Хүлээн авахаас татгалзсан нэхэмжлэлийн тоо
Хүрээлэн буй орчин	5
Хүүхдийн эрх	0
Нийтийн эрүүл мэнд	2
Нийтийн өмч	1

Бид нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 15 захирамжийн агуулгад дүн шинжилгээ хийсэн ба дараах 5 үндсэн агуулгын хүрээнд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ. Үүнд: (i) ЗХШХШтХ—ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шаардлагыг хангаагүй 5 тохиолдол, (ii) шүүхийн харьяалал зөрчсөн 2 тохиолдол, (iii) шүүхэд нэхэмжлэл гаргах итгэмжлэл хуульд заасан шаардлага хангаагүй 1 тохиолдол, (iv) шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан 2 тохиолдол, (v) нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон 4 тохиолдол тус тус байна.



3.3.1 ЗХШХШтХ—ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шаардлагыг хангаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах этгээд нь ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1 “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх”, 18.3.2 “3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх” гэсэн шаардлагыг хангасан байхыг шаарддаг. Хуулийн энэ заалтын тухайд илүү нарийвчилсан зохицуулалт байхгүй бөгөөд үндсэн агуулга нь тухайн ТББ нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах эрх бүхий этгээд мөн болохоо шүүхэд илэрхийлэхэд чиглэгдсэн болно. ЗХШХШтХ—ийн 18.3-т заасан шаардлагын хүрээнд тулгарч буй дараах нийтлэг асуудал байна. Үүнд:

- *ТББ нь үүсэн байгуулагдаад 3 жил болоогүй байхдаа нэхэмжлэл гаргасан. Шүүх нэхэмжлэгчийн шүүхэд ирүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм зэргийг үндэслэн 3-аас доошгүй жилийн өмнө байгуулагдсан эсэхийг шалгах ба баримт дутуу гэж үзвэл бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох, эсхүл шүүхэд нэхэмжлэл гаргах эрх үүсээгүй байна гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байна (Хавсралт 5, тохиолдол 1-ийг үзнэ үү).*
- *Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс 3 жилийн хугацааг тооцох эсэх. Нэхэмжлэгч нар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх зорилгоор дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулан шүүхэд нэхэмжлэл гаргадаг ба 3 жилийг тоолохдоо нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөсөө бус анх байгуулсан өдрөөсөө тоолж шүүхэд ханддаг. Энэ тохиолдолд шүүх анх байгуулагдсан огноог бус харин хуулийн 18.3-т заасны дагуу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх хэзээ үүссэн буюу дүрэмд нэмэлт, өөрчлөлт орсон өдрөөс эхлэн тоолж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байна. Тухайлбал, шүүгчийн захирамжид: “нэхэмжлэлд хавсаргасан баримт болох хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ ёсоор “Т” ТББ нь 2014 онд анх үүсгэн байгуулагдахдаа баталсан ТББ-ын дүрмийн 2.1-д хүний эрх, эрх чөлөө, ардчилсан, чөлөөт*



нийгмийн үнэт зүйл, зарчмыг эрхэлсэн, хүний эрхийг хангах, хамгаалах, эрх зүйн үнэт зүйлсийг бэхжүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилгоор үйл ажиллагаа явуулна гэсэн байна. Харин 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд орсон өөрчлөлтөөр байгаль орчноо хайрлан хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг дэмжих үйл ажиллагааны чиглэлийг нэмж оруулсан байна. Мөн ТББ нь 2016, 2017, 2018 онуудад татварын албанд гаргасан тайландаа үйл ажиллагаа явуулаагүй гэж тайлагнасан болох нь тогтоогдож байна. Иймд ТББ нь... сүүлийн 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх хуулийн шаардлагыг хангахгүй гэж үзэх үндэслэлтэй тул нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэлээ” гэжээ (Хавсралт 5, тохиолдол 4-ийг үзнэ үү).

Энд шүүх зөвхөн тухайн ТББ-ын татварын байгууллагад гаргаж өгсөн тайланд үндэслэн сүүлийн 3 жилийн хугацаанд дүрмийн зорилгын дагуу тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй гэсэн дүгнэлт хийжээ. Гэтэл “дүрмийн зорилгын дагуу тогтвортой үйл ажиллагаа явуулсан” гэдгийг хэрхэн ойлгох, нотлох талаар ЗХШХШтХ-ийн 18.3.2-т нарийвчлан зохицуулаагүй буюу санхүүгийн гүйлгээ хийгдэж, татварын байгууллагад тайлагнасан байхыг заавал шаардахгүй. Иймд энэ тохиолдолд ТББ-ын тогтвортой үйл ажиллагааг илэрхийлэх бусад баримтуудыг шүүх авч үзэх боломжтой гэж үзэж болохоор байна. Учир нь иргэний нийгмийн үйл ажиллагааг дэмжих тогтолцоо бүрдээгүй манай орны хувьд ТББ-ууд зарим үед санхүүжилт олж чадахгүй байх нь түгээмэл юм. Ийнхүү санхүүгийн гүйлгээ хийгдээгүй бол татварын байгууллагад үйл ажиллагаа явуулаагүй гэсэн байдлаар тайлагнадаг. Гэхдээ санхүүжилт байхгүй гэдэг тухайн байгууллагаа огт үйл ажиллагаа явуулаагүй гэсэн үг бус бөгөөд нийтийн тусын тулд цалин хөлсгүйгээр ажиллах тохиолдол түгээмэл хэмээн судалгаанд оролцогчид онцолж байсан болно. Иймд нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөх боломжийг өргөжүүлэх чиглэлээр ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 3



дахь хэсгийг эргэн харах, нэг мөр ойлгон хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна.

- *Нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцээгүй. Байгууллагын дүрмийн зорилго нь хуулийн 18.3-т заасан дөрвөн агуулгад нийцээгүй, тусгаагүй байхад нэхэмжлэл гаргасан нөхцөлд шүүх хүлээн авахаас татгалзаж байна. Тухайлбал шүүгчийн захирамжид: “Ш” ТББ-ын дүрэмд байгууллагын зорилгыг “Орон нутгийн хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын хөгжлийг дэмжих, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, нийгэмд чиглэгдсэн соёл гэгээрлийн үйл ажиллагаа явуулах” гээд зорилгоо хэрэгжүүлэхийн тулд 6 төрлийн үйл ажиллагааг явуулахаар тусгажээ. Үүний дотор нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой үйл ажиллагаа буюу “нийтийн өмчийг хамгаалах” асуудал хамаарахгүй байна. Иймд “Ш” ТББ нь нийтийн өмчийг хамгаалах асуудлаар нэхэмжлэл гаргах эрхгүй байна. Нэгэнт нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх хуулийн шаардлагыг хангахгүй байх тул дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг шалгах шаардлагагүй гэж үзлээ” (Хавсралт 5, тохиолдол 5-ыг үзнэ үү).*

3.3.2 Шүүхийн харьяалал зөрчсөн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалан шүүхэд хандах нэхэмжлэлийн нийтлэг нэг шаардлага нь хууль зөрчиж гаргасан байж болох хэм хэмжээний актыг шүүхээр хүчингүй болгуулах тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл, хэм хэмжээний акт нь хуулийн нэгэн адилаар бүх нийтээр дагаж мөрдөх шинжтэй тул нийтийн ашиг сонирхлыг ямагт хөндөж байдаг эрх зүйн эх сурвалж билээ. ЗХШХШТХ-ийн 112 дугаар зүйлийн 112.1-д “Дараах төрлийн маргааныг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ”, 112.1.1-д “улсын хэмжээний, эсхүл хоёр болон түүнээс дээш засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд





үйлчлэх захиргааны хэм хэмжээний акттай холбоотой маргаан” гэж заасан. Зарим төрлийн хэм хэмжээний акт тухайлбал, тодорхой нэг сумын ИТХ-аас баталсан хог хаягдлын тухай журам нь зөвхөн тухайн сумандаа л үйлчлэх ба бусад сум, аймагт хамааралгүй байдаг. Энэ тохиолдолд захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандаж болох ба харин хэм хэмжээний актын үйлчлэл нь нэг бус хоёроос дээш засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үйлчлэх бол давж заалдах шатны шүүхэд хандах юм. Тухайлбал, нэхэмжлэгч Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017.05.03-ны өдрийн А/115, А/176, 142 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын “Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ” хэсгийн 2 ба 4-т заасан “Бэлгийн гэмт хэргийн үзлэг”, “Гэмтлийн зэрэг тогтоох үзлэг” гэснийг хүчингүй болгуулах шаардлага гаргасныг “*маргаан бүхий тушаалын хавсралт нь улсын хэмжээнд үйлчлэх захиргааны хэм хэмжээний акт тул ЗХШХШТХ-ийн 112.1.1-н дагуу давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэнэ*” гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан. Шүүхийн харьяалал зөрчсөн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй нь нэхэмжлэгчийн чадавхтай холбоотой асуудал юм (*Хавсралт 5, тохиолдол 6 ба 7-г үзнэ үү*).

3.3.3 Шүүхэд нэхэмжлэл гаргах итгэмжлэлийн асуудлаар

Хэрэв аливаа байгууллага (бидний судалгааны хүрээнд ТББ)-аас шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдолд нэхэмжлэлд тухайн байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, тухайлбал гүйцэтгэх захирал гарын үсэг зурж баталгаажуулахыг хуулиар шаарддаг. Гэвч энэ шаардлагыг хангаагүйн улмаас нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болсон байна. Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийг ТББ-ын Удирдах зөвлөлийн хурлын тогтоолоор томилж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн улсын бүртгэлийн гэрчилгээний арын хэсэгт тэмдэглэлээ хийлгэдэг. Итгэмжлэл нь хуульд зааснаар агуулгын болоод хэлбэрийн шаардлагыг хангасан байхыг шаардах ба хангаагүй бол итгэмжлэлийг хүчин төгөлдөр гэж үздэггүй. ЗХШХШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.2-д “*Хууль, эрх зүйн бусад*



акт болон үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлнө” гэж, 27.4-д “Итгэмжлэл нь дараах шаардлагыг хангасан байна; 27.4.1. итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх; 27.4.2. олгосон он, сар, өдрийг заах; 27.4.3. хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх; 27.4.4. захиргааны ямар маргаанд оролцохыг тодорхой заах; 27.4.5. итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах”; 27.5-д “Энэ хуулийн 27.4-т заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1.5-д “...нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй болон болон нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан бол шүүгч нэхэмжлэл хүлээн авахаас татгалзана” гэж заасан. Судалгааны явцад итгэмжлэл олгогдсон эсэх асуудлаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байсан тул энэхүү тайланд оруулсан болно. Итгэмжлэл нь хуулийн шаардлага хангахгүй шалтгааны улмаас нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь ТББ-ын хууль зүйн мэдлэг, чадавхын асуудал бөгөөд цаашид иймэрхүү “жижиг” хэмжээний алдаанаас шалтгаалж шүүхэд хандах цаг хугацаа алдах эрсдэлтэй болохыг анхаарах нь зүйтэй.

3.3.4 Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамжийн тухай

ЗХШХШТХ-ийн 109 дүгээр зүйлийн 109.2-т “энэ хуулийн 54.1-д заасан үндэслэл хэргийг хянан шийдвэрлэх явцад, эсхүл шүүх хуралдааны явцад тогтоогдвол шүүгч, шүүх бүрэлдэхүүн хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана” гэж заасан. Хэдийгээр шүүх нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэсэн ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл бий болбол хүлээн авахаас татгалздаг байна. Иймд нэхэмжлэгч нар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ч нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг





хянаж, шалгаж байх нь зүйтэй юм. Учир нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ийнхүү нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь анх нэхэмжлэл шүүхэд гаргаад хүлээн авахаас татгалзсанаас цаг хугацааны хувьд илүү уршигтай. Өөрөөр хэлбэл, анх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нөхцөлд шалтгааныг тухайн үед арилгах арга хэмжээ авч болох бол шүүх хуралдааны үеэр татгалзсан нөхцөлд хэрэг үүссэн хийгээд шүүх хуралдаан хүртэлх хугацааг алдаж байна гэсэн үг юм.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон үндэслэлд өмнө дурдсанчлан хариуцагчийг буруу тодорхойлох, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх зорилгоор дүрэмд өөрчлөлт оруулсан хугацаа нь 3 жилд хүрээгүй гэсэн шалтгаанууд хамаарч байна. Эдгээрээс анхаарал татсан шийдвэр нь ТББ нь өөрийн эрхийг хамгаалах агуулга бүхий нэхэмжлэл гаргасан байхад шүүх нэхэмжлэгчид хуулийн 18.3-т заасан шалгуурыг тавьж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдол юм. Түүнчлэн энэхүү ТББ нь нийгэмд бус гишүүддээ үйлчлэх зорилготой атал мөн хуулийн 18.3-т хамаатуулан дүгнэсэн нь буруу юм. Иймд шүүхээс ТББ-аас гаргасан нэхэмжлэлд хянуур хандаж нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг сайтар судлах шаардлагатай болж байна.

3.3.5 Тодорхой нутаг дэвсгэрийн харьяаллаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлаж болох уу?

ТББ нь зөвхөн тодорхой нэг нутаг дэвсгэрт хамаарах оноосон нэрийг сонгосон, эсхүл зөвхөн нэг гол, нэг нуур гэх мэт нарийвчилсан байдлаар зорилгоо тодорхойлоод хожим нь тэдгээрээс өөр нутагт байгаа болон өөр асуудлаар нийтийн ашиг сонирхлыг хамгаалах бол шүүх хүлээн авахаас татгалзжээ. Жишээлэхэд, Хөвсгөл далайг хамгаалах зорилготой бол нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хүрээлэн буй орчныг хамгаалахаар нэхэмжлэл гаргах боломжгүй гэж үзсэн тохиолдол байна. Гэвч хуульд ийнхүү нарийвчлан заагаагүй тул шүүх ТББ-ын дүрмийн зорилгыг нэхэмжлэлийн шаардлагатай уялдуулж тайлбарлан нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэхийг



үгүйсгэхгүй. Энэ нь ТББ-ын хувьд нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоо хэрэгжүүлэхэд хязгаарлалт болж байна. Үүнийг тухайн байгууллага ЗХШХШТХ батлагдахаас өмнө үүсгэн байгуулагдсан, мөн хуульд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрхийн зохицуулалт ямар байхыг мэдэх боломжгүй байсантай холбоотой гэж үзэж болох юм.

3.3.6 Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжтай холбоотой дүгнэлт

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалахаар захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан асуудлыг судалж үзээд хууль хэрэглээ буюу шүүхийн үйл ажиллагаанд хамааралтай болон нэхэмжлэгч буюу ТББ-д холбоотой байдлаар дараах дүгнэлтийг гаргаж байна.

- ТББ-аас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохтой холбоотой зарим дүгнэлт
 - Шүүхээс санхүүгийн тайлан шаардсан тохиолдлуудыг ажиглахад ТББ анх нэхэмжлэл гаргахдаа тогтвортой үйл ажиллагаа явуулсан талаараа хангалттай баримт бүрдүүлээгүй тохиолдол нийтлэг гарсан байна. Зарим тохиолдолд хэзээ байгуулагдсанаа буюу 3-аас доошгүй жилийн өмнө байгуулагдсан эсхүл дүрмийн зорилго нь нэхэмжлэлийн шаардлагатай нийцэж байгаа эсэхээ хангалттай нотлоогүй, эргэлзээтэй байв. Бидний үзэж байгаагаар хэрэв ТББ-ын санхүү, татварын тайлан нэхэмжлэл гаргах үед бүрэн бус байгаа нөхцөлд бусад баримтыг сайтар бүрдүүлж, энэ талаараа нэхэмжлэлд тодорхой дурдаж тайлбарлах нь зүйтэй. Хэрэв бусад баримт хангалттай нөхцөлд татварын тайланг заавал шаардах үндэсгүй. Учир нь бидний ажигласнаар хэргийг нэгэнтээ шийдвэрлэсэн хэргийн материалтай танилцахад шүүгч тухайн ТББ-ыг гурван жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгахдаа ихэвчлэн санхүүгийн тайланд бус бусад баримтын хүрээнд үнэлж хэрэг үүсгэсэн байв.





- Шийдвэрлэгдсэн хэргийн материалтай танилцахад бусад баримт гэдгийг дараах байдлаар ойлгож болохоор байна. Тухайлбал, жилийн гэхдээ заавал гурван жил дараалсан бус үйл ажиллагааны тайлан, явуулж байсан нөлөөллийн ажлууд, зурагт хуудас, өөрийн болоод бусад этгээдийн хийсэн судалгааны ажил, түүний тайлан, судалгааны ажил гүйцэтгэх хийгээд бусад ажил гүйцэтгэх гэрээ, сургалт явуулсан бол тухайн үеийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, төрийн байгууллага болоод бусад байгууллагад хүргүүлж байсан албан бичиг, тэдгээрийн хариу, ТББ-ын дэлгэрэнгүй мэдээлэл, үйл ажиллагааны товч мэдээлэл, ТВ-ийн мэдээнд орж байсан бичлэгийн зураг гэх мэт. Мөн үйл ажиллагаа явуулдаг болох нь нийтэд илэрхий, ТББ нь үйл ажиллагааныхаа талаар олон жилийн туршид нийтэд тогтмол мэдээлж байсан түүнийг нь нийтээрээ мэддэг бол шүүгч түүнийг үнэлж захиргааны хэрэг үүсгэж болдог. Харин захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлын хамгаалах нэхэмжлэл гаргасан ТББ-ууд эдгээр бүх баримтыг нэг бүрчлэн нотлох баримтын шаардлага хангасан байдлаар шүүхэд хүргүүлж чадаагүй байдал нийтлэг байна. Өөрөөр хэлбэл, зарим баримтыг нотариатаар батлуулалгүй нэхэмжлэгч өөрөө тайлбарлан хавсаргаж байсан. Түүнчлэн нэхэмжлэл бүрд хавсаргасан нотлох баримт харилцан адилгүй ба нэхэмжлэгч нар боломжийнхоо хэмжээнд бүрдүүлснийг шүүх хүлээн авч үнэлсэн байдаг. Эдгээр баримтууд нь ЗХШХШтХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.5 “*нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй*” гэсэн нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж байгаагаа нотлох цаашид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх, хэргийг амжилттай шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.



- Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлд⁷ зааснаар ТББ үйл ажиллагааны тайлангаа улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж байхыг шаарддаг. Шүүх энэ тайланг заавал шаарддаггүй гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, бусад баримтын хүрээнд гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан болохыг үнэлж байжээ. Тухайн хэргийн хариуцагч шүүх хуралдааны явцад нэхэмжлэгч улсын бүртгэлийн байгууллагад тайлан өгөөгүй учраас тогтвортой үйл ажиллагаа явуулсан гэж үзэхгүй гэж маргахад шүүх бусад баримтыг иш үндэс болгон шийдвэр гаргасан байдаг⁸. Бусад баримт гэдэгт ТББ нь өөрийн явуулж буй үйл ажиллагаа, шүүхэд нэхэмжлэл гаргасан асуудлаар өмнө төрийн байгууллагад хүргүүлж байсан албан бичиг, тэдгээрийн хариу зэрэг болно. Гэсэн хэдий ч ТББ-ууд Төрийн бус байгууллагын тухай хуульд заасны дагуу үйл ажиллагааны тайлангаа холбогдох байгууллагад хүргүүлж хэвших нь зүйтэй бөгөөд түүнийг нэхэмжлэлдээ хавсаргаснаар захиргааны хэрэг үүсэх магадлал нэмэгдэх боломжтой байна.

⁷ 2. Төрийн бус байгууллага үйл ажиллагааныхаа тайланг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх бөгөөд түүнд дараах асуудлыг тусгана:

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

- 1/ төрийн бус байгууллагын хаяг;
- 2/ үйл ажиллагааны тухай товч мэдээлэл;
- 3/ жилийн орлого, зарлагыг дор дурдсан ангиллаар:
 - а/ хандивын;
 - б/ дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны;
 - в/ өвлүүлсэн эд хөрөнгө.
- 4/ 700000-аас дээш төгрөгийн хандив буюу өвийн хөрөнгө өгсөн байгууллага, иргэний нэр, зүйлсийн жагсаалт;
- 5/ удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирлын нэр, хаяг.

3. Төрийн бус байгууллагад өргөсөн хандивыг хэрхэн зарцуулсан тухай хандивлагчдад тайлагнах эсэхээ тэдгээртэй байгуулсан гэрээнд тусгана.

4. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайланг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тус байгууллага нь 10-аас доошгүй жил хадгална.

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

⁸ Баянхонгор аймаг дахь ЗХАШШ, 2018.11.06, дугаар 111/ШШ2018/0028





- ТББ-ын дүрмийн зорилго, нэхэмжлэлийн шаардлагын агуулга болоод хуулийн §18.3 дахь заалтын агуулгатай нийцсэн байх гэсэн шаардлагыг шүүх хатуу баримталсан гэж үзэхээргүй байна. Тухайлбал, нэхэмжлэгч ТББ-ын дүрмийн зорилго нь ЗХШХШтХ-ийн 18.3-т заасан хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчид шууд хамаарахгүй боловч *“Монгол Улсын хууль зүйн салбарын хөгжил шинэтгэлд хувь нэмрээ оруулах, эрх зүйт төр, эрх зүйт нийгмийг бүрдүүлэх”* гэж тодорхойлсон зорилгын хүрээнд нийтийн өмчийн асуудлаар Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан нэхэмжлэлийг хуульд заасан шаардлага хангасан гэж үзсэн байна⁹.
- Түүнчлэн тухайн ТББ үйл ажиллагаа явуулдаг нь нийтэд илэрхий гэсэн үндэслэлээр захиргааны хэрэг үүсгэсэн байдаг. Тухайлбал¹⁰, *“...ТББ нь дүрэмдээ заасан дээрх үйл ажиллагааг олон жил эрхлэн явуулж байгаа нь нийтэд илэрхий үйл баримт бөгөөд энэ нэхэмжлэл ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-д заасан шаардлагыг хангасан байна”* гэжээ. Энэ тохиолдолд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг нь нийтэд илэрхий гэж шүүгч үзвэл ТББ-ын дүрмийн зорилгыг нэхэмжлэлийн шаардлагатай уялдаж байгаа эсэхийг шалгаад тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг нягтлан шалгах шаардлагагүй гэж үзсэн байна.
- Хугацааны хувьд нэхэмжлэл гарах өдрөөс гурван жилийн өмнө байгуулагдсан байх шаардлагыг шүүх нэг мөр хатуу баримтлах тул ТББ-ын дүрэм, гэрчилгээний хуулбарыг нотлох баримтын шаардлага хангах байдлаар бүрдүүлж нэхэмжлэлд хавсаргах.
- Тохиолдол хэсэгт дурдсан шүүхийн болон хэргийн харьяалал, итгэмжлэлийн асуудлаар буцсан, татгалзсан нэхэмжлэлүүд

⁹ 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 128/ШЗ2018/2482

¹⁰ НЗХАШШ, 2017.09.04, дугаар 653



нь ТББ, түүний хуульч, өмгөөлөгчид илүү анхааралтай ажиллахыг сануулсан тохиолдол юм.

- Хууль хэрэглээтэй холбоотой зарим дүгнэлт

- Энэ хэсгийн дүгнэлтэд шүүхээс нэхэмжлэлийг хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангасан гэж үзээд хүлээн авч захиргааны хэрэг үүсгэн улмаар шийдвэрлэсэн хэрэг маргааны тохиолдлыг харьцуулалт хийх зорилгоор хамтатган оруулсан болно.
- Шүүхээс ТББ нэхэмжлэл гаргах үед багадаа гурван жилийн өмнө байгуулагдсан байх, дүрмийн зорилгоо хуулийн §18.3-т нийцүүлэн өөрчилсөн бол өөрчлөлт оруулж улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс гурван жилийн хугацааг тоолох байдлаар хуулийг нэг мөр хэрэглэж иржээ. Гэвч шүүх бүх тохиолдолд нэгдмэл байсан гэж үзэх боломжгүй байна. Тухайлбал, шүүхийн шийдвэрт: “...ТББ нь нэхэмжлэл гаргах эрхтэй. Энэ нь... ТББ-ын 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Дүрэмд өөрчлөлт оруулах тухай 2 дугаар тогтоолоор тогтоогдож байна” гэсэн байдаг. Нийтлэг байдлаар үзвэл 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр шүүхэд нэхэмжлэл гаргах эрх үүсэхээр байгаа боловч шүүх нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэжээ.
- ЗХШХШТХ-ийн 18.3.2-т “*дүрмийн зорилгын дагуу сүцлийн гурваас доошгүй жил тогтвортой цйл ажиллагаа явуулсан байх*” гэж заасан. Хуульд үүнээс өөр зохицуулалт байхгүй тул шүүгчид ТББ нь тогтвортой үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгаж тогтоохдоо харилцан адилгүй баримт шаардаж, харилцан адилгүй үнэлж байна. Тухайлбал, зарим шүүгч санхүүгийн тайлан шаардсан байхад нөгөө нь шаардалгүйгээр бусад баримтын хүрээнд үнэлсэн байдаг. Түүнчлэн санхүүгийн Х тайланг 3 жил үйл ажиллагаа явуулаагүй байна гэж тайлбарласан шүүгчийн захирамж ч байгааг тэмдэглэх нь зүйтэй.





- Шүүхээс нэхэмжлэгч нь ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шаардлагыг хангаагүй байна гэж үзэхдээ бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох захирамж, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн аль алиныг гаргаж байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийг хүлээн аваад нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох уу, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамж гаргах уу гэдгийг шүүгч сонгож байна. ЗХШХШТХ-ийн 52, 53 дугаар зүйлд бүрдүүлбэр хангуулах нөхцөлүүдийг заасан бөгөөд хууль хэрэглээний хувьд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан үндэслэлээр бүрдүүлбэр хангуулах захирамж гаргах заалт хуулийн 52 дугаар зүйлд байхгүй. Тиймээс ч бидний судалгаа хийсэн захирамжуудын хүрээнд хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангуулахаар хугацаа тогтоосон захирамж гаргахдаа хуулийн 52 дугаар зүйлийг хэрэглэлгүй, шууд 53 дугаар зүйлийн 53.3 *“нэхэмжлэл нь энэ хуулийн 52.2, 52.3, 52.5-д заасан бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүцгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно”* гэснийг баримталдаг. Шүүгч хуулийг ийнхүү хэрэглэж байгаа нь нэхэмжлэгчид боломж олгож буй нэг хэлбэр юм. ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нөхцөлүүдийг заасан. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн хувьд ЗХШХШТХ-ийн 18.3-т заасан шаардлагыг хангаагүй үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.5-д *“нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй болон нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан”* гэсэн үндэслэлийг дурдаж байна. Учир нь ЗХШХШТХ-ийн 18.3 дахь хэсэг нь тухайн ТББ нийтийн ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг шалгадаг шалгуур бүхий заалт юм. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох болон нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамж



гарсан нь нэхэмжлэгчийн дахин шүүхэд хандах эрхийг хязгаарлахгүй тул холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн дахин шүүхэд хандах эрхтэй. Харин захиргааны хэрэг үүсгэсний дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж хэргийг хэрэгсэхгүй болгох нь нэхэмжлэгч талд ашиггүй юм. Учир нь ЗХШХШТХ-ийн 63 дугаар зүйлийн 63.1-д “хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ” гэж заасан ба зарим тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд зааснаас урт хугацаанд үргэлжилдэг. Ийнхүү урт хугацааны дараа нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах эрсдэл байгаа тул нэхэмжлэгч нэхэмжлэл гаргахдаа өөрийн нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх шалгуурыг сайтар нягтлах нь зүйтэй юм.

- ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Нэхэмжлэлийг энэ хуулийн 54.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг дахин гаргах, эсхүл хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж, нэхэмжлэлийг буцаана” гэж заасан. Шүүгч ямар үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байгаагаа захирамжид дурддаг боловч тухайн зөрчлийг хэрхэн засаж залруулахыг төдийлөн зааж өгөхгүй байна. Өөрөөр хэлбэл, шүүх тус хуулийн 54.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа юм.
- ЗХШХШТХ-ийн 52.5.1 “захиргааны акт, захиргааны гэрээг хүчингүй болгуулах, илт хууль бус болохыг тогтоолгох, эсхүл эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, захиргааны акт гаргуулахыг даалгах нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн”, 52.5.5-д “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл





зөрчигдөж болзошгүй” гэж тус тус заасан. Тохиолдол хэсэгт хуулийн энэ хоёр заалтыг хамтад нь хэрэглэж бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон захирамж бий. Энэ нь нэг талаас нэхэмжлэгч өөрийн эрх ашгийг хамгаалах зорилго агуулсан байж болох, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах агуулгыг нэг нэхэмжлэлд давхардуулан хамтад нь бичсэн байсантай холбоотой юм. Нөгөө талаар 52.5.5 дахь заалтын хүрээнд нэхэмжлэгч хангалттай сонирхол илэрхийлж нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй талаар нэхэмжлэлдээ тайлбарлахыг шаарддаг. Нэхэмжлэгч 52.5.5-д заасны дагуу тайлбарласны дараа шүүхээс 52.5.1-д заасан нэхэмжлэлийн төрөлд дурдсанчлан аль нэг шийдвэр гаргахыг шүүхээс хүсэх нь гарцаагүй юм. Өөрөөр хэлбэл, ТББ нь ЗХШХШТХ-ийн 52.5.1-д заасан нэхэмжлэлийн төрлүүдээс тухайн тохиолдолд тохируулан аль нэгийг сонгох ба тэрхүү нэхэмжлэлээ шүүхээр амжилттай шийдвэрлүүлснээр ТББ-ын нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилго биелэх юм. Жишээлэхэд, тохиолдол хэсэгт дурдсанчлан захиргааны байгууллага болон компани хооронд байгуулсан захиргааны гэрээ нь хууль зөрчсөн, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээр байгаа тул ТББ шүүхэд хандаж гэрээг хүчингүйд тооцуулахаар нэхэмжлэл гаргасан. Нэхэмжлэлийн шаардлага нь гэрээг хүчингүй болгуулахыг хүссэн тул 52.5.1-д заасны дагуу нэхэмжлэгч болох ТББ-ын эрх ашиг хэрхэн зөрчигдсөнөө тайлбарла гэж шаардах нь үндэслэлгүй юм. Энэ тохиолдолд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь нийт, нийт олны сайн сайхан, ашиг сонирхол бөгөөд түүнийг төлөөлж ТББ нэхэмжлэл гаргасан гэж тайлбарлах нь оновчтой байна. Иймд ТББ нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд хандсан нөхцөлд 52.5.1-д заасан “...нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн” болохыг шалгахдаа шүүх зөвхөн нэхэмжлэл гаргасан тухайн ТББ-ын эрх яаж зөрчигдсөн бэ гэхээс илүүтэй тухайн ТББ нь нийтийн ямар ашиг сонирхлыг төлөөлж байгаа вэ гэдэг талаас нь хуулийн 52.5.5-д заасантай нэгэн адилаар нийтийн ашиг



сонирхол хэрхэн зөрчигдсөн хийгээд зөрчигдөж болзошгүй байгаа вэ гэсэн байдлаар хандах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэлийн хувьд 52.5.1, 52.5.5 дахь заалт нь нийтийн ашиг сонирхол талаасаа агуулга нэг байж болохоор байгаа юм.

- Шүүхээс итгэмжлэл хуулийн шаардлага хангахгүй байна гэж дүгнэхдээ үйл баримт, үндэслэлийг тодорхой дурдалгүйгээр зөвхөн хуулийн зүйл, заалт бичсэн нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч захирамжтай танилцаад итгэмжлэлийг хэрхэн өөрчилж, хуульд нийцүүлсэн нөхцөлд шүүх хүлээн авахыг ойлгож, мэдэх боломжгүй байна. Судлаачийн зүгээс ч мөн адил, удирдах зөвлөлийн даргыг шүүхэд төлөөлөх эрхгүй гэж шүүх үзсэн үү, эсхүл ТББ-ын Гүйцэтгэх захирлаас итгэмжлэл олгоогүй, итгэмжлэл хэлбэрийн шаардлага хангаагүй гэх мэт ямар үндэслэлээр фактын хувьд хууль зөрчсөнийг ойлгох боломжгүй байгаа юм.

3.4 ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ БУСАД АСУУДАЛ

3.4.1 Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг нь ЗХШХШТХ-ийн 70 дугаар зүйлээр зохицуулагддаг. Урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой үүсдэг гол маргаантай асуудал бол хэлэлцүүлгээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж хэргийг хэрэгсэхгүй болгосон асуудал юм. Гэхдээ урьдчилсан хэлэлцүүлгийн явцад гарч буй эдгээр шийдвэр нь зөвхөн ЗХШХШТХ-ийн 18.3 дахь заалттай холбоотой гэхээс илүүтэй бусад нэхэмжлэлийн хүрээнд ч нийтлэг гардаг асуудал юм.

Хуулийн 18.3-тай холбоотой нэхэмжлэлийг урьдчилсан хэлэлцүүлгээр хэрэгсэхгүй болгосон нь бусад олон тохиолдлын нэг л хэсэг юм (*... мөн нэхэмжлэгч төрийн бус байгууллага нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн*





18.3-д заасан шаардлагыг хангаагүй байх тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.5¹¹-д заасан нөхцөл байдал үүсэж байна).¹² Шүүхээс ийнхүү шийдэх нь үндэслэлтэй эсэх тухай асуудлыг тусад нь нарийвчлан судлах шаардлагатай. Тухайлбал, хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.4-т заасан “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс урьдчилсан хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудал” гэсэн заалтыг хуулийн 52, 54 дэх зүйл заалттай хэрхэн холбож тайлбарлах гэх мэт цаашид нарийвчлан судлах замаар хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм. Энэ зүйл заалтад дурдсан бусад асуудал гэдэг нь өргөн агуулгатай, шүүгчийн эрх хэмжээний хүрээнд асуудал шийдэх эрхийг олгосон заалт юм. Бидний жишээн дээр дурдсанчлан хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангаагүй тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нөхцөл үүсэж байна гэж дүгнэн хүлээн авахаас татгалзаж буй нөхцөлд энэ нь нэг талаас нэхэмжлэгч талд ашигтай. Учир нь энэ нөхцөл байдлыг шүүх хуралдааны явцад буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төгсгөл хэсэгт тогтоосон нөхцөлд нэхэмжлэгч цаг хугацаа ихээр алдах эрсдэлтэй. Урьдчилсан хэлэлцүүлэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхэн үед явагддаг тул заавал шүүх хуралдаан хүргэлгүйгээр нөхцөл байдлыг тогтоож хугацаа алдалгүйгээр дахин нэхэмжлэл гаргах боломж үүсэж байгаа юм. Шүүх хуралдааны явцад ч хуулийн 18.3-т заасан шаардлага хангаагүй үндэслэлээр хүлээн авахаас татгалзах боломжтой тул анх нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх фактыг сайтар нягтлах нь чухал.

3.4.2 Улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал

Нийтийнашигсонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь ЗХШХШТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.3-д “Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжилж байгаа этгээдийг шүүхийн зардлаас чөлөөлнө” гэж

¹¹ Нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй болон нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;

¹² НЗХАШШ, 2017.05.16-ны 128/ШЗ2017/3303



заасны дагуу шүүхийн зардлаас чөлөөлөгдөж болно. Тус хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 “... хуульд заасан бусад үндэслэл байвал Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу шүүгч улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлж, захирамж гаргана” гэснийг үндэслэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.13 “Захиргааны хэргийн шүүхэд хандаж нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн гаргасан нэхэмжлэл” гэж зааснаар шүүгчийн захирамжаар тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх мөн боломжтой. Гэхдээ нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд болон иргэн, хуулийн этгээд хамтран нэг нэхэмжлэл гаргасан, эсхүл нийтийн ашиг сонирхлын зөрчил болон нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын зөрчлийг зэрэгцүүлэн тодорхойлж нэхэмжлэл гаргасан тохиолдолд хуулиар олгосон дээрх эерэг зохицуулалтыг хэрэглэх боломж хязгаарлагдаж байна. Түүнчлэн хөндөгдөж буй асуудал нь нийтийн ашиг сонирхол боловч нэхэмжлэлийн шаардлага нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тухайн асуудлаар мэдээлэл авах, захиргааны байгууллага, албан тушаалтны хариу өгөхгүй байгаа эс үйлдэхүйг илт хууль бусад тооцох зэрэг нэхэмжлэгч ТББ-ын мэдээлэл авах эрхийг хөндсөн тохиолдолд шүүхээс улсын тэмдэгтийн хураамж төлөхийг шаардаж байна. Мөн “нэхэмжлэгч УТХТХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.1.13 дахь заалтыг дурдаж улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх хүсэлт гаргасан боловч дээр дурдсанчлан сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсныг нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй байх тул тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх үндэслэлгүй байна¹³ гэж шүүх дүгнэсэн тохиолдлыг энд тэмдэглэх нь зүйтэй.

Түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах сонирхлоо бүрэн илэрхийлсэн нэхэмжлэл гаргасан боловч ТББ-ууд тэмдэгтийн хураамж төлсөн тохиолдлууд гарчээ. Шүүх нэхэмжлэлийг хангаж шийдсэн нөхцөлд төлсөн тэмдэгтийн хураамжийг улсын орлогод хэвээр үлдээж, хариуцагчаас гаргуулахаар шийдэж байна. Угаас нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий нэхэмжлэлийг

¹³ НдЗХАШШ, 2017.12.05-ны 128/ШЗ2017/7702





улсын тэмдэгтийн хураамжаас хуулиар чөлөөлж байгаа нөхцөлд нэгэнтээ төлсөн тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэгчид шууд буцаан олгох нь зүйтэй юм. Нэхэмжлэгч нар хуулийн энэ боломжийг ашиглан шүүхэд хүсэлт гаргаж хураамжаас чөлөөлөгдөж байгаа хэдий боловч шүүхэд илүү ойлгомжтой, хангалттай тайлбарлаж анхнаасаа тэмдэгтийн хураамж төлөлгүйгээр нэхэмжлэл гаргах нь зүйтэй.

3.4.3 ЗХШ-ийн шийдвэр гүйцэтгэл

Эрүү, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй харьцуулахад захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл онцлогтой. Захиргааны хэргийн нэг тал нь захирамжилсан шийдвэр гаргах эрхтэй нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтан, эсхүл нийтийн чиг үүргийг гэрээ болон хуулиар шилжүүлэн авсан этгээд байх бөгөөд тэдгээр субъектэд албадлага хэрэглэн шүүхийн шийдвэр биелүүлэх зохицуулалт бүрэн дүүрэн хэрэгждэггүй. Зарчмын хувьд хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг төр, иргэн, хуулийн этгээд хэн боловч биелүүлэх үүрэгтэй. Шүүхийн шийдвэрийг сайн дураар эсхүл шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар буюу албадлагаар биелүүлдэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.2.-т “*...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр уламжлан энэ хуульд заасан хугацаанд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилогдож, чөлөөлөгддөг бусад албан тушаалтны асуудлыг Засгийн газарт, Улсын Их Хурлаас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтны асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.*” гэж заасан хэдий ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа агентлаг болохын хувьд дээрх хуулийн заалтыг практикт хэрэгжүүлэхэд төвөгтэй байдал үүсдэг. Энэ талаар судалгааны явцад хэргийн оролцогчидтой хийсэн уулзалтын бодит жишээн дээр тайлбарлаж байсан болно. Нөгөө



талаас, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын механизм хангалттай биш байна.

Жишээ нь шүүхээс “... Төвийн бүсийн хаврын уралдааныг Төв аймгийн Аргалант суманд 2017 оны 3 дугаар сарын 5-ны өдөр товлосон нь нийтэд илэрхий, Хөвсгөл, Говь-Алтай аймагт 2017 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Хаврын бүсийн морин уралдааныг тус тус товлосон байх бөгөөд уг тогтоолын улмаас бага насны хүүхдийн эрүүл мэнд, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй байх тул...” захиргааны актын дээрх хэсгийн биелэлтийг түдгэлзүүлэх тухай захирамжийг 2017 оны 3 дугаар сарын 3-ны өдөр гаргасан.¹⁴

Хэдийгээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамжийг заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд энэ талаар хүний эрхийн ТББ-ууд, хуульчид, өмгөөлөгчид удаа дараа байр сууриа илэрхийлж, олон нийтийн шүүмж гарч байсан ч хариуцагч болон уралдаан зохион байгуулагчдын зүгээс шүүгчийн захирамжийг хэрэгжүүлэлгүй, уралдааныг зохион байгуулсан. Зохион байгуулагчдын зүгээс “... Бидэнд одоо болтол шүүхийн шийдвэр ирээгүй. ... Цаг нь тулчихсан болохоор хойшлуулах боломж байгаагүй.”¹⁵ зэргээр шүүгчийн захирамжийг биелүүлээгүй үндэслэлээ тайлбарласан ч хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, тогтоол, шүүгчийн захирамжийг заавал биелүүлэх үүрэгтэй байсан. Захирамжийг зөрчсөн буруутай этгээдэд хариуцлага ногдуулах хуулийн зохицуулалт ч тодорхой бус байна. Зөрчлийн тухай хуулийн 15.27-д шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх, эрүүгийн хуулиар хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн төрлийг тус тус хуульчилсан боловч захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх захирамжийг зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлагад хамаарах уу,

¹⁴ Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн “Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай” 2017 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 128/ШЗ2017/1643 дугаар захирамж.

¹⁵ Өнөөдөр сонин, “Шүүх хориглосон ч Дүнжингарав 2017-г зохион байгууллаа.” 2017.03.06, цахим холбоос: <http://unuudur.mn>





шүүгчийн захирамжийг үл хайхарсан явдалд хэн, ямар хариуцлага хүлээх вэ гэсэн асуултад хариу өгөөгүй.

Түүнчлэн нийтийн ашиг сонирхолтой холбоотой захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн мөн нэг шийдвэр нь гарснаасаа хойш нэг жил орчмын дараа биелэгдсэн байна. Энэ хугацаанд нэхэмжлэгч шийдвэр гүйцэтгэхийг хариуцагчаас шаардаж нийт гурван удаа биечлэн уулзсан, түүнчлэн хариуцагч шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажилд хойрго хандаж ээлжийн амралт, бүх нийтийн амралт зэрэг баяр ёслолыг далимдуулж удаашруулж байсан талаар судалгаанд оролцогчид дурдсан болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нарын тухайд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, тэр дундаа нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хэргийн шүүхийн шийдвэрийн талаар бүрэн мэдээлэлгүй байгаа нь энэ талаар тодруулга авах үед ажиглагдсан. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэг шийдвэр гүйцэтгэлийн тухайд ШШГА-аас хариуцагчид албан бичиг хүргүүлэх, шаардах гэсэн ажиллагааны хэлбэрээр шийдвэрийг гүйцэтгэсэн байна. Цаашид нэхэмжлэгч нар зорилгодоо хүрсэн шүүхийн шийдвэр гаргуулсан нөхцөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандаж шийдвэрийн биелэлтийг хангуулах байдлаар нийтийн ашиг сонирхлыг бүрнээ хамгаалах буй заа. Монгол Улсад байгаа төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, хэн боловч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.2-т заасны дагуу шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй байсан бөгөөд энэ үүргээ зөрчсөн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан хууль дээдлэх зарчим, бусад хууль тогтоомжид заасан хууль дээдлэх, хууль биелүүлэх үүргээ зөрчсөн явдал учраас түүнд зохих хариуцлагыг заавал хүлээлгэх ёстой. Иймд цаашид захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг боловсронгуй, үр нөлөөтэй болгох шаардлага зайлшгүй байна.



БҮЛЭГ IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1 СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

4.1.1 ТББ-тай холбоотой дүгнэлтүүд

- Хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан шаардлагыг бүрэн хангах ТББ байгууллага цөөн байна. Энэ нь нэг талаар ТББ-ын чадавх, хариуцлагатай холбоотой байж болох авч нөгөө талаар шүүхээс хуулийн шаардлагыг нэг мөр хэрэглэдэггүй практик нөхцөл байдлаас шалтгаалж байна. Шүүх нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэхэд нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн эсэхэд нэн тэргүүнд анхаарал хандуулах бус хэн нэхэмжлэл гаргасан, тэр нь хуулийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд голлон анхаарч, шаардлага хангаагүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг буцаах, хүлээн авахаас татгалзахыг урьтал болгож байгаа байдал нийтлэг байна. Хамгийн гол нь ийнхүү нэхэмжлэгчид тавьж буй шаардлага нь харилцан адилгүй байх тул хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн ойлголт, хэрэглээг нэг мөр болгоход анхаарах шаардлагатай байгаа нь судалгаагаар харагдлаа.
- Нэхэмжлэлийн шаардлагатай танилцахад хүрээлэн буй орчныг хамгаалах агуулга бүхий нэхэмжлэл дийлэнх хувийг эзэлж байгаа ба эдгээр нь ерөнхийдөө ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох буюу захиргааны актыг хүчингүй болгоход түгээмэл чиглэсэн байна. Харин байгаль орчны бусад салбар асуудлыг хөндсөн, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээхийг зорьсон агуулга бүхий шаардлага цөөн байна. Нийтийн ашиг сонирхол бол





зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлахаар хязгаарлагдахгүй өргөн хүрээтэй асуудал гэдгийг анхаарах нь зүйтэй. Түүнчлэн нийтийн өмч, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэндийн асуудлаар гаргасан нэхэмжлэл маш цөөн байна.

- Хариуцагчийг буруу тодорхойлсон үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдол цөөнгүй байна. Энэ нь ТББ-ын чадавхтай шууд холбоотой гэхээс илүү захиргааны шүүх нь хариуцагчийг солих, жинхэнэ хариуцагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулах зэрэг хуулиар хүлээсэн эрх, үүргээ хангалттай хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой юм.
- Нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд болохоо бүрэн нотлох баримтыг шүүхэд ирүүлээгүй, нэхэмжлэлд гарын үсгийг буруу этгээдээр зуруулсан, итгэмжлэл нь хуульд нийцээгүй зэрэг шалтгаанаар нэхэмжлэл буцаагдсан тохиолдлууд цөөнгүй байгаа нь нэхэмжлэл гаргах бэлтгэл, хууль зүйн боловсрол хангалттай бус байгаагийн илрэл мөн.
- Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох хийгээд буцаасан захирамж, түүнчлэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамжийн гол үндэслэлд нэхэмжлэгч ТББ нь ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2-т заасан шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэл нийтлэг байна.

4.1.2 Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээний тухайд

А. Хууль хэрэглээний тухайд

- ЗХШХШТХ-ийн 18.3.1, 18.3.2-т заасан шалгуурыг нэхэмжлэл гаргах үед болон нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэсэн хэргийн хувьд харилцан адилгүй байдлаар хэрэглэсэн байна. Тодруулбал, шүүхээс захиргааны хэрэг үүсгэхдээ хуулийн §18.3.1, 18.3.2 дахь заалтыг нэг мөр, зөв мөрдөж хэрэглэсэн гэж үзэхээргүй байна. Энэ нь эцэстээ хуулийн үндсэн үзэл баримтлалыг гажуудуулах, ТББ-ууд нийтийн ашиг



сонирхлыг шүүхийн журмаар хамгаалах үйл явцад саад учруулах, улмаар цаашдын хөгжилд сөрөг нөлөөтэй байж болохыг дурдах нь зүйтэй.

Зарим шүүхийн шийдвэрт ТББ нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргах “болзол” хангасан эсэх талаар дүгнэсэн байхад, дийлэнх шийдвэрт энэ талаар огт дүгнэлт хийгээгүй байна. Түүнчлэн хариуцагч, гуравдагч этгээдийн хувьд ч энэхүү асуудлаар тэр болгон бие даасан сонирхол илэрхийлж, мэтгэлцдэггүй байна. Иймд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нэхэмжлэгчид тавигдах шаардлага нь нэхэмжлэлд тавигдах нийтлэг шаардлагаас онцлог тул шүүхээс нэхэмжлэлийн шаардлага, нэхэмжлэгчдийн эрх зүйн байдалд бүрэн дүүрэн, зөв дүгнэлт өгч байх нь зүйтэй.

- Нэхэмжлэлийн шаардлагыг хангасан шүүхийн шийдвэртэй танилцахад дийлэнх нь даалгах агуулга бүхий шийдвэр байна. Гэвч шийдвэртээ тодорхой үйлдэл хийхийг даалгах агуулга бүхий 106 дугаар зүйлийн 106.3.4-ийг хэрэглэлгүй зөвхөн 106.3.12,106.3.13-ыг хэрэглэсэн тохиолдол байна. ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.10¹⁶ дахь заалт огт хэрэглэгдээгүй бөгөөд энэ нь нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой юм. Шүүх хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь заалтыг нийтийн ашиг сонирхлын маргаанд бүтээлчээр хэрэглэх нь энэ төрлийн хэрэг маргааны хөгжилд тустайн дээр хуулийг нэг мөр ойлгоход чухал ач холбогдолтой.
- Шүүхээс нэг нэхэмжлэлд өөр өөр үндэслэлээр, гэхдээ нэг удаагийн шийдвэрээр бус удаа дараалсан шийдвэрээр нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон захирамж гарган буцаасан, хүлээн авахаас татгалзсан байна. Энэ нь шүүгч өөрийн үзэмжээр хэрэг, маргаанд хандаж байгаа, хууль хэрэглээний соёлгүй байдлыг харуулж байна.

¹⁶ Захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох





- Бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон хийгээд буцаасан захирамжид дурдсан шалтгааныг хэрхэн арилгах, хэрхэн хуульд нийцүүлэх талаар тодорхой дурдаагүй нь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд нэхэмжлэх эрх бүхий этгээдэд хүндрэл, чирэгдэл учруулж байна.
- Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамждаа ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.2-т заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахад саад болж буй зөрчлийг тодорхой дурдаж, түүнийг арилгах арга замыг тодорхой заах шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Энэ заалтыг хэрэгжүүлсэн нөхцөлд ТББ, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах бусад этгээдийн чадвар нэмэгдэх, хэтдээ эрх зүйн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх юм.
- Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж буй нэхэмжлэгчээс субъектив эрх буюу өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж байгааг тайлбарлахыг шаардаж байгаа нь үндэслэлгүй юм.
- Зарим шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагын хууль зүйн үндэслэлээ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32¹⁷ дугаар зүйлийг үндэслэсэн байдаг. Энэ заалтыг хэрэглэж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхүүд буруутгаагүй

¹⁷ Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

/Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

/Энэ заалтад 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

2/ байгаль орчныг хамгаалах талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Хурал, Засаг даргад уламжлах;

3/ экологийн сургалт, хүмүүжлийн ажлыг өөрөө болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

4/ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, зөвлөмж, аргачлал боловсруулж холбогдох байгууллагад танилцуулж шийдвэр гаргуулах.



байна. Түүнчлэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл заалтыг зөвхөн хохирол нөхөн төлүүлэх боломжийн хүрээнд тайлбарлах нь учир дутагдалтай. Тухайлбал, хуулийн 32 дугаар зүйлд “...байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх...”, ойн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д “ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэхээр... шүүхэд нэхэмжлэл гаргах” гэж ТББ-д эрх олгосон. Тиймээс ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйл заалтын хүрээнд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд болох шаардлагаа хангаад Байгаль орчны тухай хуулийн 32 зүйлд заасан эрхийн хэрэгжилтийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой гэж үзэхээр байна.

- Шүүх хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэхгүй байх, улмаар нэхэмжлэгчид тавих шаардлагыг харилцан адилгүй байдлаар авч үзэх, нийтийн ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж буйд дүгнэлт хийлгүйгээр хэрэг маргааныг шийдвэрлэсээр байвал хууль тогтоогчоос энэхүү хуулийг хүчингүй болгох, өөрчлөх, эрх зүйн үйлчлэлийг дордуулах эрсдэл байхыг үгүйсгэхгүй.

Б. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлсон байдалд хийсэн дүгнэлт

- Шүүх нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэлийг хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэсэн нөхцөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, талуудын мэтгэлцээн, шүүхийн хэлэлцүүлэг нь ихэвчлэн ердийн хэрэг маргааны нэгэн адил үргэлжилж, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа, эс үйлдэхүй нь хууль зөрчсөн эсэх асуудлын хүрээнд л явагдаж байна. Нийтийн ашиг сонирхол, түүнд эрсдэл учирсан хийгээд учирч болох асуудлаарх нотлох баримт, дүгнэлт дутмаг байгаа нь цаашдаа сөрөг үр дагаврыг үүсгэхээр байна. Жишээлбэл, бусдад олгосон тусгай





зөвшөөрөл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хуулийн дагуу олгогдсон, журмын дагуу хийгдсэн хэдий боловч байгаль орчин, нийтийн ашиг сонирхолд хор хохиролтой болохыг хангалттай нотолсон бол түүнийг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, захиргааны шийдвэр, үйл ажиллагаа агуулга, хэлбэр, шийдвэр гаргах үйл явцын хувьд хууль зөрчөөгүй байсан ч нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчиж болзошгүй нөхцөлийг үүсгэж байгаа бол хэрхэх нь тодорхойгүй байгаа юм.

- Шүүх шийдвэрээ хэт хангалтгүй бичиж байгаа нь олон талын сөрөг үр дагаврыг үүсгэх эрсдэлтэй. Шүүхийн шийдвэрт захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр нь хууль зөрчсөнөөр нийтийн ашиг сонирхлыг хэрхэн зөрчиж байгаа, тухайн шийдвэрийг Захиргааны ерөнхий хууль болоод бусад хууль тогтоомжийн хүрээнд яагаад хууль бус гэж үзсэн, тухайн хэрэг маргааны тухайд нийтийн ашиг сонирхол гэдгийг хэрхэн ойлгож байгаа, тухайн нэхэмжлэгчийг ямар үндэслэлээр нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд гэж үзсэн, ТББ-ын дүрмийн зорилго нь нэхэмжлэлийн агуулгатай тохирсон эсэх зэрэг асуудлыг шүүхийн шийдвэрт бүрэн дүгнээгүй, зарим шийдвэрийн хувьд бүр огт дурдаагүй байна. Шүүхийн шийдвэрийг зөв арга зүйгээр, ойлгомжтой, хууль хэрэглээний хувьд чанартай бичих нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий нэхэмжлэгч нар цаашид нэхэмжлэлээ илүү сайн боловсруулах, шүүхийн мэтгэлцээнийг илүү өндөр түвшинд өрнүүлэх, хэтдээ нийтийн эрх ашгийн өмгөөллийн хөгжилд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.
- Хуулийг нэг мөр хэрэглэх талаар зарим асуудал байгаа боловч хууль хэрэгжиж эхэлснээс хойш энэ төрлийн хэрэг маргааны хувьд тодорхой практик тогтож, ТББ-ууд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, энэ төрлийн өмгөөлөл хөгжиж эхэлж байгаа энэ цаг мөчид шүүхийн чиг үүрэг, оролцоо, гүйцэтгэх үүрэг асар чухал юм.



- Нэхэмжлэгч нь ТББ л бол нэхэмжлэлийн шаардлагатай бүрэн танилцаж ойлголгүйгээр хэрэг үүсгэх эсэхийг шийдэхдээ ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан нөхцөлийг шалгаж хүлээн авахаас татгалзаж байна. Гэтэл нэхэмжлэлийн шаардлага нь ТББ өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүхээр хамгаалуулах зорилготой байсан ба хуулийг зөв ойлгож хэрэглээгүйгээс ТББ-ын бусад асуудлаар шүүхэд хандах эрхийг хязгаарлах эрсдэлтэй.

4.1.3 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үе шаттай холбоотой дүгнэлт

- Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нэхэмжлэл гаргаж буй нэхэмжлэгч нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх зохицуулалттай хэдий ч ТББ-ууд улсын тэмдэгтийн хураамж төлөх үзэгдэл нийтлэг байна.
- ЗХШХШтХ-иар шүүх хэргийг бүх талаас нь бүрэн судлах, хэргийг үнэн зөв шийдвэрлэх, захиргаа-иргэн гэсэн хүч тэнцвэргүй хоёр этгээдийн мэтгэлцэх боломжийг тэгш хангах үүднээс нотлох баримтыг өөрийн санаачилгаар бүрдүүлэх гэх мэт ажиллагаа хийх эрхтэй. Судалгаагаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах маргааны тухайд шүүх өөрийн санаачилгаар ажиллагаа хийсэн тохиолдол нэн цөөн байгаа нь шүүх цаашид нийтийн ашиг сонирхлыг хамгаалах маргаанд ач холбогдол өгч, бүтээлчээр хандахыг сануулсан хэрэг юм.
- Урьдчилсан хэлэлцүүлгээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй тохиолдол зөвхөн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах маргааны хүрээнд бус бусад маргааны тухайд ч нийтлэг байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ үе шатанд ийнхүү нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй нь хууль зүйн үндэстэй эсэх асуудлыг цаашид нарийвчлан судлах шаардлагатай.





4.1.4 Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн тухай

- Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухайд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах маргааны талаарх ойлголт дутмаг байна. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нэг жилийн хугацаанд үргэлжилсэн байдлаас үзэхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралтай, энэ нь ТББ-аас нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үйл ажиллагаанд төвөгтэй байдлыг үүсгэж байна. Түүнчлэн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн захирамж гарсан байхад түүнийг зөрчиж актыг биелүүлсэн байх ба буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгааг харуулна.

4.2. СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

4.2.1. Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр

- ТББ-ын шүүхэд төлөөлөн хамгаалах нийтийн ашиг сонирхлыг ерөнхий шинжтэй ЗХШХШтХ-иас, тусгай шинжтэй нарийвчилсан хуулиар тодорхойлон заах чиг хандлагыг баримтлах. Тухайлбал, нийтийн үйлчилгээний чанар хүртээмж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг асуудлаар нийтийн ашиг сонирхол шүүхэд төлөөлөн хамгаалах зохицуулалтыг тухайн салбарын болон төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомжид хуульд тусгах.
- Байгаль орчны тухай хууль тогтоомжид заасан ТББ-аас шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн тухай зохицуулалтыг цаашид ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн шалгууртай уялдуулах.
- Хэдийгээр ТББ нь өөрийн нэрийн өмнөөс төрийн байгууллагаас мэдээлэл гаргуулах нэхэмжлэл гаргасан боловч зорилго нь



нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн бол улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх.

- ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан “...дүрмийн зорилгод нийцсэн байх”, “...тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх”, 52 дугаар зүйлийн 52.5.5-т заасан “...маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх...” шаардлагыг харилцан адилгүй ойлгож байгаа тул эдгээр шаардлагыг тогтоох шалгуурыг гаргах эсхүл шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл практик тогтоож нэг мөр шийдвэрлэх. Шалгуур тогтоохдоо ТББ-д хүндрэл учруулсан шаардлагагүй хязгаарлалт бий болгохоос зайлсхийх.
- Цаашдаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.2-т заасан шаардлагыг хялбаршуулах, ялангуяа нэхэмжлэлийг хүлээн авахад нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл байдлыг үндсэн шалгуур болгон авч үзэх зохицуулалт тусгах.
- Нэхэмжлэгч ТББ-ын нэхэмжлэлийн шаардлагад дурдсан тодорхой ашиг сонирхлыг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан байгаль орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч гэсэн ашиг сонирхлын аль алинд нэгэн зэрэг хамруулан авч үзэх, улмаар чухам аль ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж байгааг тогтооход хүндрэлтэй байгааг харгалзан эдгээр ашиг сонирхлын хүрээг хэрхэн тогтоох, ТББ-ын гаргаж байгаа нэхэмжлэлийн шаардлагыг чухам аль ашиг сонирхолд хамаарахыг тогтоох арга, аргачлалыг салбарын материаллаг хуулиар бий болгох.

4.2.2 Шүүхээс хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх чиглэлээр

- Шүүх хуулийг нэг мөр ойлгох, хэрэглэх, нэгдмэл-интегрити байх зарчмын хүрээнд нэг ижил хэрэг тохиолдол дээр өөр өөр шийдвэр гаргах байдлаас зайлсхийх нь чухал байна.





Шүүхийн хууль хэрэглээний энэхүү ялгаатай байдлыг судалгааны эргэлтэд оруулах нь хэргийн оролцогчид хууль хэрэглээний талаарх мэдлэг, ур чадвараа дээшлүүлж хуулийг зөв тайлбарлан мэтгэлцэх замаар шүүхэд нөлөөлөх боломжтой.

- Нэхэмжлэлийг буцаах, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа нэхэмжлэгчийн гаргасан зөрчлийг тодорхойлж, түүнийг залруулах арга замыг зааж өгөх гэсэн хуулийн заалтыг нэг мөр хэрэгжүүлэх, нэхэмжлэлд байгаа зөрчлийг нэг удаагийн захирамжаар нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.
- ТББ нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар шүүхэд хандсан байхад тухайн ТББ-ын эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн талаар тайлбарлаж, нотлохыг шаардахгүй байх. Эсхүл ТББ-ын эрх, ашиг сонирхол гэдгийг нийтийн ашиг сонирхол гэсэн агуулгаар ойлгож байгаа эсэх талаар нэхэмжлэгчид тодорхой тайлбарлах.
- Шүүхийн шийдвэрт ТББ нь ЗХШХШТХ-ийн 18.3-т заасан шалгуурыг хангасан буюу нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзсэн үндэслэлийг талууд хуулийн 18.3-т заасан асуудлаар маргасан эсэхээс үл хамаарч бичих нь зүйтэй. Нээлттэй хуралдсан шүүхийн шийдвэр нийтэд ил байдаг тул ТББ-ууд нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах бэлтгэл ажлыг хангахад чухал ач холбогдолтой.

4.2.3 ТББ-ыг мэргэшүүлэх, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр

- ТББ нь нэхэмжлэл гаргахаас өмнө бэлтгэл ажлыг сайтар хангах, хуульчтай хамтран ажиллах, өмнөх хэрэг тохиолдол, маргааныг сайтар судлан харьцуулалт хийж нэхэмжлэл гаргах нь зүйтэй. Энэ төрлийн хэрэг маргааныг хөгжилд ТББ-ын үүрэг оролцоо нэн их агаад учир нь ЗХШХШТХ-д заасан агуулгын хүрээнд цор ганц нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд юм.



- ТББ-ууд хуульд заасан дөрвөн агуулга бүхий нийтийн ашиг сонирхлыг явцуу байдлаар авч үзэлгүйгээр дэлгэрүүлэн ойлгож олон төрлийн асуудлаар нийтийн ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргах боломжтой байна.
- ТББ-ууд тухайн орон нутагтаа хууль зүйн аргаар төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанд хяналт тавих, таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт, мэдээллийн ажлыг тасралтгүй зохион байгуулах.
- ТББ-ууд нэхэмжлэл гаргах эрхтэй болохоо нотлоход шаардлагатай ТББ-ын үүсгэн байгуулах баримт бичгүүд, тэдгээрийн бүртгэл, үйл ажиллагаа нэг бүрийг бэхжүүлэх гэх мэт зохион байгуулалтын ажлыг сайжруулах.
- Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа хууль тогтоомжид заасны дагуу явагдсан ч тэрхүү шийдвэрийг хэрэгжүүлснээр нийтийн ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй нь илэрхий гэж үзвэл түүнийг нотолсон баримтын хүрээнд шүүхэд мэтгэлцэх боломжтой байна.
- Нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн хийгээд зөрчигдөж болзошгүй нөхцөл байдлыг нэхэмжлэлд илүү тодорхой тусган, баримтаар нотлоход анхаарах.
- Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах чиглэлээр дүрмийн зорилгоо эргэн харж, нэмэлт өөрчлөлт оруулах замаар шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжоо өргөжүүлэхэд анхаарах. Гэхдээ өөрчлөлт орсноос хойш 3 жилийн дараа эрхээ хэрэгжүүлэх боломжтой байгаа тул 3 жил болох хүртэл хугацаанд одоо байгаа дүрмийн зорилгын хүрээнд ажиллаад хугацаа болмогц өргөн хүрээнд үргэлжлүүлэн ажиллах боломжтой байдлаар өөрчлөх асуудлыг судлах нь зүйтэй.



ХАВСРАЛТ 1. ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Шийдвэр 1:

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2018.06.07-ны 128/ШШ2018/0361

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлага: ...тоот ашигт малтмал ашиглах дөрвөн тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгуулахыг даалгах. Шаардлагаа: тусгай зөвшөөрөл эзэмшигчид Ашигт малтмалын тухай хуульд заасан нөөц болон тусгай хэрэгцээнд авч, хайгуулын талбайд соёлын өв байгаа нь тогтоогдсон түүнчлэн хууль, гэрээ зөрчсөн, татвар тайлагнаагүй, үнэлгээ тооцоход шаардлагатай мэдээллийг нуун дарагдуулсан, худал тайлагнасан байхад зөвшөөрөл олгосон тул хүчингүй болгуулах гэжээ. Хариуцагч болоод гуравдагч этгээд компанид тусгай зөвшөөрөл олгоогүй, компанийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрийг сольсон, аймгийн засаг даргаас зөвшөөрөл авсан, бид ямар ч хууль зөрчөөгүй ба энэ нь нэхэмжлэгчийн эрхийг зөрчөөгүй хэмээн тайлбарлажээ.

Шийдвэрлэсэн байдал: Хайгуул бүхий газарт хамгаалалтын бүс тогтоосон, тусгай хэрэгцээнд авсан, газрын хэвлийд соёлын өв хадгалагдаж байна хэмээгээд *дугаар бүхий тусгай зөвшөөрлүүдийг цуцлах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгасугай* гэжээ.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн §106.1, 106.3, 106.3.4, 106.3.12, 107.5

Шийдвэр 2:

Шүүхийн шийдвэр: Баянхонгор аймаг дахь ЗХАШШ, 2018.11.06, 111/ШШ2018/0028

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлага: ТББ-аас 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн дугаар бүхий Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх

уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Жаргалант сумын засаг дарга, “А” ХХК-тай байгуулж, Баянхонгор аймгийн Засаг даргын баталсан гэрээг илт хууль бус болохыг тогтоож өгнө үү гэжээ. Хариуцагч нэхэмжлэгчийг ЗХШХШТХ-ийн 18.3-т заасны дагуу нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд болох нь улсын бүртгэлийн байгууллагаас ирүүлсэн ТББ нь үйл ажиллагааны тайлан өгч байгаагүй гэсэн лавлагаагаар тогтоогдож байна гэжээ. Гэрээг хуулийн дагуу байгуулсан гэж тайлбарлана.

Шийдвэрлэсэн байдал: нэхэмжлэгч нь эл асуудлаар сүүлийн 3 жилийн хугацаанд удаа дараалан захиргааны байгууллагад албан бичиг хүргүүлж, хариу авч байсан тул нэхэмжлэл гаргах эрхтэй болох нь нотлогдож байна гэжээ. Түүнчлэн анх Ж компани Засаг даргатай ашиг малтмалын олборлох гэрээ байгуулсан атлаа тэр эрхээ А компанид шилжүүлсэн, эрх шилжүүлж авсан А компани нь тэр эрхийнхээ хүрээнд Засаг даргатай байгуулсан дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээ нэрийн дор олборлолтын үйл ажиллагаа явуулахаар байгаа нь хууль бус, нөгөө талаар А компанийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, төрийн байгууллагаас удаа дараалан үйл ажиллагааг нь зогсоох арга хэмжээ авч байсан гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн. Нийтийн ашиг сонирхолтой холбогдуулж дүгнэлт хийгээгүй.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн §106.1, 106.3.2, 106.3.12

Шийдвэр 3:

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2018.03.07, 128/ШШ2018/0152

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлага: Туул голын хамгаалалтын бүсэд 92 хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдож, хайрга олборлосноос болоод байгаль орчин болон хүн амын эрүүл мэндэд хохирол учирч байна. Хан-Уул дүүргийн 12, 13 дугаар хороонд оршин суудаг иргэдийн шаардлагаар энэхүү нэхэмжлэлийг гаргаж байгаа. Компаниудын буруутай үйл ажиллагааны улмаас Туул гол гэлтгүй Бөхөг, Түргэний голууд ширгэсэн, хүн мал усгүй болсон, цүнхэлд хүүхэд унаж нийтийн ашиг сонирхол барсан. Иймд “Б”, “С”, “Г” компаниудын дугаар бүхий тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэрээ гаргахыг Нийслэлийн Засаг даргад даалгах, тусгай зөвшөөрлөөр явуулж байгаа үйл ажиллагаанд гарсан зөрчлийг хууль тогтоомжийн дагуу таслан зогсоох шийдвэрээ хуульд нийцүүлэн гаргахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт даалгуулах гэжээ. Хариуцагч тайлбартаа: удаа дараа шалгалтын үйл ажиллагаа явуулах үед компаниудад зөрчил илрээгүй, зөрчил байгаа нөхцөл цуцлах үндэстэй гэжээ. Гуравдагч этгээд тайлбартаа: нэхэмжлэгч нэхэмжлэл гаргах эрхгүй, ямар эрх ашиг зөрчигдсөн нь тодорхойгүй, иргэдийн амьдарч буй суурьшлын



бүстэй манай талбай давхцаагүй, иргэд биднийг дарамталж дайрдаг, бид хууль зөрчөөгүй гэжээ.

Шийдвэрлэсэн байдал: НИТХын Тэргүүлэгчдээс тогтоосон усны хамгаалалтын бүстэй компанийн талбай давхцсан тул нэг компанийн зөвшөөрлийг хүчингүй болгож, давхцаагүй үлдэх хоёр компанийн зөвшөөрлийг хэвээр үлдээсэн.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн §106.1, 106.3.13

Шийдвэр 4:

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2017.09.21, 688 шийдвэр

Нийтийн ашиг сонирхол: Хүүхдийн эрх

Нэхэмжлэлийн шаардлага: нэг/ ЗГ-ын 63-р тогтоолын нэг дэх заалт хууль бус болохыг тогтоолгох, хоёр/ Төв аймгийн Аргалант суманд зохион байгуулагдсан морин уралдаан хууль бус байсан болохыг тогтоолгох, гурав/ тодорхой хугацаанд хүүхдээр морь унуулах, аливаа хэлбэрийн морин уралдаан зохион байгуулахыг хориглосон хэм хэмжээний акт гаргахыг даалгах гэжээ. Хариуцагч хаврын уралдаан зохион байгуулах хугацаа өнгөрсөн, хүүхэд эндэх, бэртэх эрсдэлийг бууруулсан, хэрэг маргааныг давж заалдах шатны шүүх шийдэх учиртай гэжээ.

Шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүх:

Нэгдүгээр шаардлага: нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

Хоёрдугаар шаардлага: Дүнжингарав хурдан морины уралдаан нь захиргааны актын үндсэн шинж болох захирамжилсан шинж өөртөө агуулаагүй учир ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-т заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон.

Гуравдугаар шаардлага: ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.2-т заасны дагуу “...тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус” бол шүүгч нэхэмжлэл хүлээн авахаас татгалзана гэсний дагуу давж заалдах шатны шүүхээр шийдвэрлүүлэх нь зүйтэй байна гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон.

Давж заалдах шатны шүүх:

Нэгдүгээр шаардлага: Анхан шатны шийдвэрийг үндэслэлтэй гэж үзсэн.

Хоёрдугаар шаардлага: Анхан шатны шийдвэрийг үндэслэлтэй гэж үзсэн.

Гуравдугаар шаардлага: Төрийн эрх мэдэл хуваах онолын дагуу давж заалдах шатны шүүх ЗГ-т хандаж хэм хэмжээний акт гаргахыг даалгаж

болохгүй. Иймд анхан шатны шүүхийн шийдвэрийн энэ хэсгийг хүчингүй болгов.

Хяналтын шатны шүүх:

Нэгдүгээр шаардлага: Шийдвэр, магадлалыг үндэслэлтэй гэж үзсэн.

Хоёрдугаар шаардлага: Шийдвэр, магадлалыг үндэслэлтэй гэж үзсэн.

Гуравдугаар шаардлага: Шийдвэр, магадлалыг үндэслэлтэй гэж үзсэн. Гэхдээ хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1 дэх заалтыг баримталж захиргааны хэргийн шүүхийн маргаан биш гэж үзсэн нь буруу гэжээ. Тайлбартаа: хуульд ийнхүү захиргааны хэм хэмжээний акттай холбоотойгоор гаргах нэхэмжлэлийн шаардлагыг тодорхой заасан боловч хууль тогтоогчоос захиргаанд хэм хэмжээ тогтоох эрхийг хуулиар шилжүүлэхдээ үүрэг болгосон, тэгэхэд захиргаа нь уг үүргийг биелүүлэхгүй эс үйлдэхүй гаргасны улмаас хууль хэрэгжихгүй, үүний улмаас бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн нь тогтоогдсон тохиолдолд захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэхээр байна гэжээ. Нийтийн ашиг сонирхлын талаар тусгайлан дүгнээгүй.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн §106.1, 106.3, 106.3.13, 109.2

Шийдвэр 5:

Шүүхийн шийдвэр: Дорнод аймаг дахь ЗХАШШ, 2019.01.03, дугаар 01

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлага: А сумын Засаг даргыг МУЗЗНДНТУТХ-д заасан эрхээ хэрэгжүүлэхгүй байгаа эс үйлдлийг тогтоолгох, Газрын тосны тухай хууль, ашигт малтмалын тухай хуулийн зарим зүйл заалтыг сурталчлан таниулж биелэлтийг хангаж, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Д компанитай гэрээ байгуулж олон нийтэд ил байршуулан ажиллахыг даалгах.

Шийдвэрлэсэн байдал: Нэхэмжлэгч нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг дурдаад Засаг дарга нь холбогдох хуулиар гэрээ байгуулахаар заасан тул аж ахуй нэгжтэй гэрээ байгуулах нь зүйтэй гээд нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн. Нийтийн ашиг сонирхлын талаар тусгайлан дүгнээгүй.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн §106.1, 106.3.12, 107.1, 107.5



Шийдвэр 6:

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2018.09.27. Дугаар 128/ШШ2018/0597

Нийтийн ашиг сонирхол: Нийтийн өмч

Нэхэмжлэлийн шаардлага: Үндэсний аудитын газар нь төрд хохирол учруулсан буруутай этгээдээс төлбөрийг гаргуулах үүргээ биелүүлээгүй эс үйлдэхүй гаргасан болохыг тогтоож, хохирлыг нөхөн төлүүлэх тухай захиргааны акт гаргахыг даалгах гэжээ. Хариуцагч дээд шатны байгууллагаас тодорхой үйл ажиллагаа явуулаагүй байхад доод шатны буюу манай байгууллага нэхэмжлэлд заасан асуудлыг шийдэх боломжгүй гэжээ маргажээ.

Шийдвэр 7:

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2016.10.04. Дугаар 739

Нэхэмжлэлийн шаардлага: сурах бичгүүд нь хууль тогтоомж, стандартад нийцээгүй агуулга, арга зүй, зөв бичих зүйн гэх мэт алдаатай, сурагчдад боловсрол олгоход сөргөөр нөлөөлж байна гээд,

Нэг. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/240 дугаар тушаалаар батлагдсан Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн “Иргэний боловсрол” хичээлд холбогдох 6.1 ба 6.2 дахь хэсгийг хүчин төгөлдөр бусад тооцуулах,

Хоёр. ЕБС-ийн 1-5 дугаар ангийн “Иргэний боловсрол (ёс суртахууны унших эх)” сурах бичгүүдийг Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журмын дагуу бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах MNS5418:2008 стандарт шаардлагад нийцүүлэн дахин зохиож хэрэглээнд нэвтрүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд даалгах гэжээ. Хариуцагчаас сурах бичгийг маш олон судлаач, эрдэмтэд хянасан, судалгаа хийж туршсан тул алдаагүй гэжээ.

Шийдвэрлэсэн байдал: Сурах бичиг хууль тогтоомж, стандартад нийцсэн талаар дүгнэлт гаргуулж шаардлага хангахгүй байгаа сурах бичгийг хэрэглээнээс хасаж, шаардлага хангуулан дахин зохиож хэвлэх, бусад шаардлагын тухайд хуульд нийцсэн байна гээд нэхэмжлэлийн шаардлагын нэг дэх хэсгийг хангахгүй орхиж, хоёр дахь хэсгийг хангаж шийдвэрлэжээ.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн §106.1, 106.3.12

Шийдвэр 8:

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2017.09.04. Дугаар 653

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлага: ТББ-аас Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Бөөрөлжүүтийн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, байгаль орчинд учирсан хохирлыг тооцон гаргаж олон нийтэд мэдээлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд даалгах. Хариуцагчийн зүгээс нэхэмжлэгч нь хариуцагчийг буруу тодорхойлсон гэжээ.

Анхан шатны шүүх: Нэхэмжлэгч нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нь нийтэд илэрхий гэж төлөөлөх эрхийг дүгнээд холбогдох хуулийн дагуу хариуцагчид мэдээллийг нийтэд хүргэх үүрэгтэй гээд нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүх: Анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй гэж үзсэн.

Хяналтын шатны шүүх: Хариуцагчийг зөв тодорхойлоогүй байхад нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдсэн нь буруу хэмээгээд анхан шатны шүүхэд дахин хянуулахаар буцаасан.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн §106.1, 106.3.14

Шийдвэр 9:

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2016.07.22. Дугаар 539

Нэхэмжлэлийн шаардлага: Онон голын сав газар, ойн сан бүхий газарт “Г” ХХК-нд 779 га талбай бүхий ашигт малтмал олборлох тоот тусгай зөвшөөрлийг Уул уурхайн яам Ашигт малтмалын газраас 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдөр олгожээ. Тусгай зөвшөөрлийг олгохдоо Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх ашиглахыг хориглох тухай хууль зөрчсөн тул тусгай зөвшөөрлийг цуцалж өгнө үү.

Анхан шатны шүүх: Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэр нь хууль зөрчөөгүй байна гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Нийтийн ашиг сонирхлын талаар тусгайлан дүгнэлт хийгээгүй.

Хэрэглэсэн хуулийн зүйл, заалт: ЗХШХШТХ-ийн §106.1, 106.3, 106.3.14



Шийдвэр 10:

Шүүхийн шийдвэр: Дорнод аймаг дахь ЗХАШШ, 2016.09.06, дугаар 13.

Нэхэмжлэлийн шаардлага: Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ИТХ, Засаг даргын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталсан шийдвэр, төлөвлөгөөний дагуу газар эзэмших эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгуулах. “С” ХХК-нд уурхайн эдэлбэр газрыг хууль зөрчиж олгосон ба ийнхүү олгосноор байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж, малчид бэлчээр, хадлангүй болоход хүрч байна.

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэгч: ТББ, иргэд

Шүүхийн шийдвэр: Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газар эзэмших эрх олгох үйл явц нь хуульд нийцсэн байх тул нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй орхисон.

Шийдвэр 11:

Шүүхийн шийдвэр: НЗХАШШ, 2017.03.10, Дугаар 173

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлага: Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн өдрийн хуралдааны “Х” ХХК-ийн судалгааны төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг хүчингүй болгуулах.

Нэхэмжлэгч: “Д” ТББ

Анхан шатны шүүхийн шийдвэр: Нэхэмжлэлийн шаардлагыг хангалгүй нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийсэн байгууллага нь хуулийн дагуу ажилласан, төсөл нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх асуудлаар үнэлгээ хийсэн байгууллага судалгаа хийж дүгнэлт гаргасан, үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог хангаж тэмдэглэл үйлдсэн байх тул үнэлгээ хийх үйл явц хуульд нийцсэн байна гэж үзсэн.

Давж заалдах шатны шүүх /2017.05.24, 221/МА2017/0366/: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүх /2017.09.27, дугаар 328/: Шийдвэр, магадлалыг хүчингүйд тооцож дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан. Учир нь “хэрэгт нэхэмжлэгчийн шаардлага, хариуцагчийн татгалзлаа үндэслэж байгаа нотлох баримтууд авагдаагүй, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай нотлох баримтыг цуглуулаагүй, маргааны зүйлд үнэлэлт, дүгнэлт хийлгүйгээр хэргийг шийдвэрлэсэн байна” гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр /2018.01.22 дугаар 40/: “...хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай бөгөөд ийнхүү нэмж тодруулах зүйл нь шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн байх тул дахин шинэ акт гартал байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг түдгэлзүүлж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ” гэжээ.



ХАВСРАЛТ 2. ШУУД БУС ХАМААРАЛТАЙ НЭХЭМЖЛЭЛТЭЙ ХОЛБОГДОН ГАРСАН ЗАХИРАМЖУУД

Тохиолдол 1¹⁸:

Нэхэмжлэлийн агуулга: Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргаас ирүүлсэн огноо, тоот албан бичгийн хариу болгож Төв аймгийн Угтаалцайдам сумын нутагт бичил уурхайн зориулалтаар үйл ажиллагаа явуулах боломжтой эсэх талаар дүгнэлтийг Төв аймгийн Засаг даргад хүргүүлсэн байдаг. Иймд дүгнэлтийг хууль бус болохыг тогтоолгон, хүчингүй болгож өгнө үү.

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Захирамжийн үндэслэл:

...иргэд нэхэмжлэл гаргаж буй эсэх, эсхүл иргэдийг төлөөлөн итгэмжлэгдсэн төлөөлөгч иргэн нэхэмжлэл гаргаж байгаа эсэх, иргэдийг төлөөлөн төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргаж байгаа эсэхийг нэг мөр, тодорхой, ойлгомжтой болгон ирүүлэх нь зүйтэй байна.

Тохиолдол 2¹⁹:

Нэхэмжлэгч: “Б” ТББ

Нийтийн ашиг сонирхол: Хүүхдийн эрх

Нэхэмжлэлийн агуулга: Манай байгууллага боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Энэ жил боловсролын хүрээлэнгээс зарласан Сурах бичиг зохиох тендерийг шударга бус, хууль зөрчин зохион байгууллаа. Боловсролыг тэргүүлэх салбар болгох, хөдөлмөрийг үнэлэх талаар төр засгаас гаргасан тогтоол журмууд маш олон. Гэвч тэдгээр журмууд ойлгомжгүй, асуудлыг шийдвэрлэх түвшинд хүрч чаддаггүй батлагддаг. Үүний нэг бол “ЕБС-ийн сурах бичиг зохиох хэвлүүлэх түгээх журам” юм. Сурах бичиг хэвлэх, зохиох үйл ажиллагаа нь хууль, журам зөрчдөг төрөөс зохион байгуулсан тендер нь хууль зөрчсөн, эцэстээ энэ нь Монголын нийт сурагчдын эрх ашгийг хөндөж байна. Энэхүү ажилд бид ШӨХТГ, Хүний эрхийн Үндэсний комисст хандаад байгаа бөгөөд “зөрчил арилгуулах шийдвэр” гарсан. Иймд Боловсролын хүрээлэнгээс 2018 онд зарласан сурах бичиг зохиох тендерийг хууль бус болохыг тогтоож, тендерийг хуулийн хүрээнд дахин зарлахыг хариуцагч Боловсролын хүрээлэнд даалгаж өгөх.

¹⁸ НЗХАШШ, 2018.06.11, дугаар 128/ШШ2018/3706

¹⁹ НЗХАШШ, 2018.06.15, 128/ШШ2018/3837

Захирамжийн үндэслэл:

ТББ-аас шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ ЗХШХШтХ-ийн 52 дугаар зүйлийн 52.2.4-т заасан “нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл”-ийг мөн зүйлийн 52.5.1-52.5.7 дахь хэсгүүдэд зааснаар тодорхойлон ирүүлээгүй байна. Өөрөөр хэлбэл, “...захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан ямар акт, хууль бус ямар эс үйлдэхүй нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн талаар дурдаагүй байх тул шүүхээс түүний эрхийг зөрчсөн захиргааны актыг тодорхойлох боломжгүй байна. Иймд ТББ нь захиргааны байгууллагын ямар акт түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн хийгээд зөрчиж болзошгүй ямар эрхээ хамгаалуулахыг хүсэж байгаа талаар үндэслэлийг тодорхой тусгасан хуульд заасан бүрдүүлбэрийг хангасан нэхэмжлэл ирүүлэх боломжийг олгон, уг хугацааг 14 хоногоор тогтоох нь зүйтэй” гэж үзлээ.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШтХ §52.2, 52.3, 52.5, 52.3

Тохиолдол 3²⁰:

Нэхэмжлэлийн агуулга:

Нэг. ТББ нь 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр МУЗГ, УУХҮЯ-нд холбогдуулан дугаар хороонд амьдарч буй иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж буй компани, иргэдийн хууль бус үйлдлийг таслан зогсоохыг хүссэн өргөдлийг шийдэж өгөхгүй байгаа үйлдлийг хууль бус болохыг тогтоолгох, ТББ-ын өргөдлийг журмын дагуу шийдэж хариу өгөхгүй байгаа тул хариу өгч захиргааны акт гаргахыг даалгах шаардлага гаргасан бөгөөд шүүх бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон боловч нэхэмжлэгч бүрдүүлбэр хангаагүй тул буцаасан.

Хоёр. Мөн агуулгаар нэхэмжлэгч шүүхэд дахин нэхэмжлэл гаргахад “нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан” хэмээн хүлээн авахаас татгалзсан.

Гурав. Нэхэмжлэгч УУХҮЯ-нд холбогдуулан гурав дахь удаагаа ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.4 дэх заалтыг үндэслэн дахин нэхэмжлэл гаргасан ба энэ удаа ТББ-аас шаардлагаа тодорхойлохдоо манай байгууллагаас гаргасан өргөдөл, гомдолд төрийн байгууллага хариу өгөхгүй байна гэсэн агуулгаар тодорхойлсон байдаг.

Татгалзсан үндэслэл: ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.6-д “нэхэмжлэлд заасан үйл баримт, захиргааны үйл ажиллагааны талаар, эсхүл уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шийдвэр болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол байгаа” гэсний дагуу татгалзсан.

²⁰ НДЗХАШШ 2018.04.18-ны өдрийн 128/ШЗ2018/2483 захирамж

Давж заалдах шатны шүүхийн тогтоол²¹:

Нэхэмжлэгч захирамжид давж заалдах гомдол гаргасан ба шүүх үзэхдээ ТББ нь төрийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдлынхоо хариуг авах агуулга бүхий нэхэмжлэл гаргасан, аливаа иргэн, байгууллага өөрийн гаргасан өргөдлийн хариуг авах эрхтэй гэж үзэн гомдлыг хангажээ.

Тохиолдол 4²².

Нэхэмжлэлийн агуулга: Орхон аймгийн иргэн М тус аймагт үйлчилгээ үзүүлдэг нийтийн тээврийн үйлчилгээний компанийн автобус нь Авто тээврийн тухай хууль, Монгол Улсын холбогдох стандартыг зөрчсөн гэсэн үндэслэлээр “Орхон аймгийн Авто тээврийн төвийн “Т” болон “Б” ХХК-тай байгуулсан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгүүлэх гэрээг хүчингүй болгуулах, уг компаниудын нийтийн тээврийн үйл ажиллагааг зогсоож, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр үйлчилгээг гүйцэтгүүлэхийг Орхон аймгийн Засаг даргад даалгаж өгнө үү.

Захирамжийн үндэслэл: “...Авто тээврийн төвийн “Т”, “Б” ХХК-иудтай байгуулсан гэрээ нь нэхэмжлэл гаргагчийн субъектив эрхтэй холбоогүй, захиргааны байгууллагатай эрх зүйн харилцаа үүсээгүй байна” гэж үзэж хүлээн авахаас татгалзжээ.

Тохиолдол 5²³.

Нэхэмжлэгч: “Э” ТББ

Нэхэмжлэлийн агуулга: МУЗГ-аас 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар импортоор оруулж ирж байгаа автомашины бүртгэлийг зөвхөн авто худалдааны цогцолбор дахь Авто тээврийн үндэсний төвийн салбарт зохион байгуулахыг шийдвэрлэсэн. Ерөнхий сайдад хандаж МУЗГ-ын энэхүү асуудлын хүрээнд гарсан 7 дугаар хуралдааны тэмдэглэлийн 1-р хэсэгт тэмдэглэгдсэн заалтыг эргэж харж, хүчингүй болгож өгөхийг хүсэхэд хүсэлтийг хүлээн авах боломжгүй гэсэн хариу ирсэн. Бид Да хүрээ худалдааны төвд бүртгэл хийхийг хүссэн 600 гаруй иргэдийн гарын үсэг цуглуулсан ба Да хүрээ худалдааны төвд үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн санал, нөхцөл боломжийг судлалгүйгээр шийдвэр гаргасныг эсэргүүцэж байна. Иймд ЗГ-ын шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү.

Татгалзсан үндэслэл: ЗГ-ын хуралдааны тэмдэглэл нь захиргааны акт биш тул шүүх хянахгүй. ЗГ-ын хуралдааны 7 дугаар тэмдэглэл нь хуралдааны явцыг баримтжуулсан тэмдэглэл байна.

²¹ ЗХДЗШШ, 2018.05.15-ны өдрийн 221/ШТ2018/0350 тогтоол

²² Орхон аймаг дахь ЗХАШШ, 2017.02.02, 34 дүгээр захирамж

²³ НЗХАШШ, 2018.04.16, 128/ШЗ2018/2415

ХАВСРАЛТ 3. НЭХЭМЖЛЭЛИЙН БҮРДҮҮЛБЭР ХАНГУУЛАХААР ХУГАЦАА ТОГТООСОН ЗАХИРАМЖ

Тохиолдол 1²⁴:

Нийтийн ашиг сонирхол: Нийтийн эрүүл мэнд

Нэхэмжлэлийн шаардлагын агуулга: “Ч” ТББ нь нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлохдоо: ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад ял эдэлж байх хугацаандаа хөгжлийн бэрхшээлтэй болсон ялтанд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралдаанаар орж Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгох боломжгүй болгосон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/213, А/130 тоот тушаалыг тус тус хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Захирамжийн үндэслэл: Нэгд, нэхэмжлэгч ЗХШХШТХ-ийн 18.3.1-д зааснаар ЧДХБИХ ТББ нь өөрийн дүрэм, сүүлийн гурван жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан талаар баримтыг ирүүлээгүй. **Хоёрт**, мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.5.1-д заасны дагуу нэхэмжлэгч ТББ нь хариуцагчаар Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг татсан атлаа нэхэмжлэлийн шаардлагаа Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын гаргасан захиргааны актыг хүчингүй болгуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргасан нь ойлгомжгүй байна. Иймд нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн үндэслэлээ тодруулж дээр дурдсан баримтуудыг ирүүлэх шаардлагатай байх тул ЗХШХШТХ-д заасны дагуу бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох нь зүйтэй гэж үзэв.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШТХ §52.5.1, 53.3

Тохиолдол 2²⁵:

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн агуулга: БОАЖЯ-ны 2017 оны “Ц” ХХК-ийн Баянхонгор аймаг дахь Заг сумын нутагт орших дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн алтны шороон ордны байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан үйлдлийг илт хууль бус болохыг тогтоолгох

Захирамжийн үндэслэл:

Нэгд, ЗХШХШТХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.5-д заасны дагуу нэхэмжлэгчийн болон нийтийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн

²⁴ НЗХАШШ, 2018.01.23, 128/Ш32018/0550 захирамж

²⁵ НЗХАШШ, 2018.09.21, 128/Ш32018/6147 захирамж



хөндөгдөж байгаа болон уг маргаан бүхий актыг хүчингүй болгуулснаар тэдний ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн сэргэх талаар нэхэмжлэлдээ тодорхой дурдаагүй.

Хоёрт, ИХ-ийн 26 дугаар зүйлийн 26.5-д Хуулийн этгээдийн удирдах байгууллагын эрх зүйн байдлыг хууль буюу үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно гэж тус тус заасан байх бөгөөд ТББ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлд Үүсгэн байгуулагчаас ТББ байгуулах тухай шийдвэр гаргаж байгууллагын дүрмийг баталснаар ТББ-ыг үүсгэн байгуулсанд тооцох бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ гэж заасан байхад нэхэмжлэгчийн нэхэмжлэлд хавсарган ирүүлсэн баримтаас үзэхэд “З” ТББ нь хуулийн этгээд мөн эсэх талаарх баримтыг нэхэмжлэлд хавсаргаж ирүүлээгүй болохыг дурдах зүйтэй.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШтХ §52.5.5, 52.3. 52.5, 52.3

Тохиолдол 3²⁶:

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлагын агуулга:

1. БОАЖЯ-ны 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 08/18 дугаартай мэдээлэл хүссэн албан бичигт хариу ирүүлээгүй эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоолгох;

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийн орлого, байгаль орчныг нөхөн сэргээхэд зарцуулсан мөнгөн хөрөнгийн зарлагын талаарх 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд ил тод болгож, мэдээллийг даалгах;

3. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нөхөн сэргээлтийн тусгай дансанд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь заалтын дагуу мөнгөн хөрөнгийг жил бүр төсөл хэрэгжүүлэгч тус бүрээс төвлөрүүлэх үүргээ биелүүлээгүй, “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу тусгай дансны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг жил бүр хийлгэх үүргээ биелүүлээгүй, мөн зориулалтын бусаар зарцуулж байгаа үйлдлийг хууль бус болохыг тогтоолгох.

Захирамжийн үндэслэл: ЗХШХШтХ-ийн 18.3.2-т заасны дагуу нэхэмжлэгч “Х” ТББ нь сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй, мөн нэхэмжлэлийн шаардлага

²⁶ НЗХАШШ, 2018.10.19, 128/ШЗ2018/6898 захирамж

тус бүрдээ холбогдуулан нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй эсэх, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг тодруулах зайлшгүй шаардлагатай байх тул нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнд хавсаргасан баримтыг үндэслэн захиргааны хэрэг үүсгэх боломжгүй байна. Иймд “Х” ТББ нь нэхэмжлэлийн шаардлага тус бүртэй холбогдуулан нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй эсэх, тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан талаарх /2015, 2016, 2017 оны Татварын албан хүргүүлсэн тайлан/ тайлбар, баримтаа нотлох баримтын шаардлага хангуулан нэхэмжлэлд хавсаргаж, шүүхээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлээ дахин гаргах нь зүйтэй байна.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШтХ § 53.3

Тохиолдол 4²⁷:

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлагын агуулга: “УУА” ТББ-аас Монгол Улсын Засгийн газар, Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яаманд холбогдуулан “Налайх дүүргийн дугаар хорооны иргэдийн амьдарч буй компани, иргэдийн үйлдлийг таслан зогсоож өгөхийг хүссэн өргөдлийг шийдвэрлээгүй эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, УУА ТББ-аас Налайх дүүргийн дугаар хорооны иргэдийн асуудлыг шийдвэрлүүлэхээр гаргасан өргөдлийг холбогдох журмын дагуу шийдвэрлэж хариу өгөхийг холбогдох захиргааны акт гаргахыг даалгах” гэсэн шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан.

Захирамжийн үндэслэл: ЗХШХШтХ-ийн 53.3-д зааснаар дараах үндэслэлээр нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар шийдвэрлэсэн.

- УУА ТББ нь хуульд заасан нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тул УТХ-аас чөлөөлж өгнө үү гэсэн хүсэлтийг гаргасан хэдий ч сүүлийн 3 жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй.
- ЗХШХШтХ-ийн 52.5.1-д даалгах нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгчийн хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн талаар дурдсан байх шаардлагатай бөгөөд нэхэмжлэгч УУА ТББ-ын ямар эрх ашиг хөндөгдсөн, захиргааны хэргийн шүүхээс ямар шийдвэр гаргуулж зөрчигдсөн эрхээ сэргээлгэхийг хүсэж байгааг тодруулах шаардлагатай.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШтХ § 52.5.1, 53.3,

²⁷ НЗХАШШ, 2017.05.17, 128/ШЗ2017/3347 захирамж



ХАВСРАЛТ 4. НЭХЭМЖЛЭЛИЙГ БУЦААХ ТУХАЙ ЗАХИРАМЖ

Тохиолдол 1²⁸:

Анх шүүхээс бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон захирамжаар шаардсан баримтууд: ТББ нь нэхэмжлэлийн шаардлага тус бүртэй холбогдуулан нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй эсэх, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг тодруулж, сүүлийн 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан талаарх /2015, 2016, 2017 оны Татварын албанд хүргүүлсэн тайлан/ тайлбар баримтаа нотлох баримтын шаардлага хангуулан нэхэмжлэлд хавсаргаж, шүүхээс тогтоосон хугацаанд нэхэмжлэл дахин гаргах нь зүйтэй байна. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангах хугацааг 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хүртэл 14 хоногоор тогтоосугай.

Захирамжийн дагуу нэхэмжлэгчээс шүүхэд ирүүлсэн тайлбар: Нэхэмжлэгч бүрдүүлбэр хангуулах захирамжийг биелүүлэх боломжтой эсэх талаар шүүхэд ирүүлсэн тайлбартаа: “үйл ажиллагааны тайланг холбогдох төрийн байгууллагаас авахаар хүсэлт гаргасан, тогтоосон хугацаанаас хойш хариу ирэхээр байна” гэжээ.

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүйн улмаас буцаасан захирамжийн үндэслэл:

ТББ нь сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан талаарх //2015, 2016, 2017 оны Татварын албанд хүргүүлсэн тайлан“ тайлбар, баримтаа нотлох баримтын шаардлага хангуулан нэхэмжлэлд хавсаргаж, шүүхээс тогтоосон хугацаанд ирүүлээгүй, нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаагүй байна. Иймд ТББ нь сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан эсэх нь тодорхойгүй учраас захиргааны хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах боломжгүй тул ЗХШХШТХ-ийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэлийг буцаах нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

Тохиолдол 2²⁹:

Анх шүүхээс бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон захирамжаар шаардсан баримтууд: “О ТББ нь нэхэмжлэгч болохын хувьд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.3.2-т заасан шаардлагуудыг хангасан байх, ингэснээр шүүхээс нэхэмжлэл гаргах эсэхийг дүгнэхээр байна” гэжээ.

²⁸ НЗХАШШ, 2018.11.07, 128/ШЗ2018/7408 захирамж

²⁹ НЗХАШШ, 2018.04.06, 128/ШЗ2017/2216 захирамж

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүйн улмаас буцаасан захирамжийн үндэслэл:

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоох тухай шүүгчийн захирамжийн хүрээнд тогтоосон хугацаанд нэхэмжлэлээ дахин гаргаж ирүүлсэн байх боловч бүрдүүлбэрийн шаардлагын зарим хэсэг тодорхой бус, гүйцэд биш байх тул нэхэмжлэлийг буцааж шийдвэрлэв.

Тохиолдол 3³⁰:

Нэхэмжлэлийн шаардлага: 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/213, А/130 тушаалыг тус тус хүчингүй болгуулах

Анх шүүхээс бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоосон захирамжаар шаардсан баримтууд: ТББ-ын дүрэм болон сүүлийн 3 жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан эсэх талаар баримтыг шүүхэд ирүүлэх

Буцаасан захирамжийн үндэслэл: Тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн бүрдүүлбэр ханган ирүүлээгүй байх тул нэхэмжлэлийг буцаан шийдвэрлэв.

Тохиолдол 4³¹:

Нэхэмжлэлийн шаардлага: БОАЖЯ-ны 2017 оны “Ц” ХХК-ийн Баянхонгор аймаг дахь Заг сумын нутагт орших дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн алтны шороон ордны байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан үйлдлийг илт хууль бус болохыг тогтоолгох.

Буцаасан захирамжийн үндэслэл: Тус шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын сарын 21-ний өдрийн 6147 дугаар шүүгчийн захирамжаар ЗХШХШТХ-н 53 дугаар зүйлийн 53.3-т “Нэхэмжлэл нь энэ хуулийн 52.2, 52.3, 52.4-т заасан бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно” гэж заасны дагуу 14 хоногийн хугацааг шүүхээс тогтоожээ. ТББ нь шүүхээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж шүүхэд дахин ирүүлээгүй байх тул ЗХШХШТХ-н 53 дугаар зүйлийн 53.4-т зааснаар нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаагүй гэж үзэж, нэхэмжлэлийг буцаах нь зүйтэй байна.

³⁰ НЗХАШШ, 2018.02.13, 128/ТМ2018/1029 захирамж

³¹ НЗХАШШ, 2018.10.05, 128/Ш32018/6512 захирамж



ХАВСРАЛТ 5. НЭХЭМЖЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗАХ ЗАХИРАМЖ

Тохиолдол 1³²:

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлагын агуулга: А улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг дахь Могойн гол орчимд эзэмшиж буй нэр бүхий компаниудын хайгуулын тусгай зөвшөөрлүүд болон олгосон шийдвэрүүдийг хүчингүй болгуулах, Үндэсний хөгжлийн газрын “Н” ХХК-тай байгуулсан концессын гэрээ болон, концессын гэрээ байгуулах эрх олгосон тогтоолыг хүчингүй болгуулах, “Н” ХХК-д төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгосон тогтоолыг хүчингүй болгуулах.

Татгалзсан үндэслэл: “Х ТББ нь нэхэмжлэлдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийг хавсарган ирцүлсэн байх боловч уг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн... дугаар гэрчилгээнд тус ТББ-ыг 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр бүртгэсэн байх тул нэхэмжлэл гаргах эрх үцсээгүй этгээд нэхэмжлэлийг гаргасан байна гэж үзлээ” гэжээ.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШтХ §18.3, 18.3.2; 54.1.5

Тохиолдол 2³³:

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн агуулга: “А” компанийг “Н” дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох төслийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн албан бичгийн хувь зэрэг холбогдох мэдээ мэдээллүүдийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам ямар нэгэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, үндэслэлгүйгээр хуулийн хугацаанд гаргаж өгөөгүй эс үйлдэл нь хууль бус болохыг тогтоолгох.

Татгалзсан үндэслэл: ...гэтэл “Ш” ТББ-ын нэхэмжлэл болон түүнд хавсаргасан баримтаас харахад 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр гэрчилгээ авсан байгаа нь сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан гэх шаардлагыг хангахгүй байгаа тул хүлээн авахаас татгалзсугай.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШтХ §18.3, 18.3.2; 54.1.5

³² НЗХАШШ, 2017.02.16-ны өдрийн 128/ШЗ2017/1353 дугаар захирамж

³³ НЗХАШШ, 2017.12.28-ны өдрийн 128/ШЗ2018/0061 дугаар захирамж

Тохиолдол 3³⁴:

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн агуулга: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017.12.26-ны өдрийн “Тусгай зориулалтаар болон ахуйн зориулалтаар амьтан агнах, барих хуваарь батлах тухай” а/370 тоот тушаалын 1-р хавсралтын холбогдох хэсгийг хүчингүй болгуулах.

Татгалзсан үндэслэл: Нэхэмжлэлд хавсаргасан “А ТББ-ын дүрэмд үүсгэн байгуулсан он сар нь 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдөр байх тул хүлээн авахаас татгалзсугай” гэжээ.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШТХ §18.3, 18.3.2; 54.1.5

Давж заалдах гомдлыг шийдвэрлэсэн байдал

Нэхэмжлэгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжид гомдол гаргажээ.

Тогтоолд: “ТББ нь ЗХШХШТХ-ийн §18.3.1, 18.3.2-г хангасан байх шаардлагатай бөгөөд “А” ТББ-ыг үүсгэн байгуулсан хугацаанаас тооцон үзэхэд §18.3.2-т заасан шаардлагыг хангаагүй байна гэж дүгнэсэн анхан шатны шүүхийн дүгнэлт зөв байна” гэжээ.

Тохиолдол 4³⁵:

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн агуулга: Манай ТББ нь хүний эрх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт, судалгаа, сурталчилгааны үйл ажиллагаа явуулжирсэн ба ЗХШХШТХ-ийн 18.3-т заасныг үндэслэн энэхүү нэхэмжлэлийг гаргаж байна. Манай байгууллагаас Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг дэвсгэрт, “Т” гэх талбайд “Б” ХХК-нд тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон нь хууль бус тул цуцлуулах хүсэлтээ АМГТ-ны газарт хүргүүлсэн боловч цуцлах боломжгүй гэжээ. Энэ нутаг дэвсгэр нь 145 ширхэг хиргисүүр бүхий соёлын өвийг хадгалж байдаг бөгөөд Соёлын өвийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.2-ыг зөрчиж ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон нь хууль бус. Иймд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.1.2 болон Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.7-д заасныг үндэслэн Б компанид олгосон тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалж өгнө үү.

Татгалзсан үндэслэл: “нэхэмжлэлд хавсаргасан баримт болох хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ ёсоор Т ТББ нь 2014 онд анх үүсгэн байгуулагдахдаа баталсан ТББ-ын дүрмийн 2.1-д хүний эрх, эрх чөлөө, ардчилсан, чөлөөт нийгмийн үнэт зүйл, зарчмыг эрхэлсэн, хүний эрхийг

³⁴ НЗХАШШ, 2018.05.11-ний өдрийн 3020 дугаар захирамж

³⁵ НЗХАШШ, 2018.09.27-ний өдрийн 128/ШЗ2018/6274 дугаар захирамж



хангах, хамгаалах, эрх зүйн үнэт зүйлсийг бэхжүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилгоор үйл ажиллагаа явуулна гэсэн байна. Харин 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд орсон өөрчлөлтөөр байгаль орчноо хайрлан хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг дэмжих үйл ажиллагааны чиглэлийг нэмж оруулсан байна. Мөн ТББ нь 2016, 2017, 2018 онуудад татварын албанд гаргасан тайландаа үйл ажиллагаа явуулаагүй гэж тайлагнасан болох нь тогтоогдож байна. Иймд ТББ нь... сүүлийн 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх хуулийн шаардлагыг хангахгүй гэж үзэх үндэслэлтэй тул нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэлээ” гэжээ.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШтХ §18.3, 18.3.2; 54.1.5

Тохиолдол 5³⁶:

Нийтийн ашиг сонирхол: Нийтийн өмч

Нэхэмжлэлийн агуулга: “Ш” ТББ, “А” ТББ, нэр бүхий 3 иргэд шүүхэд нэхэмжлэл гаргасан. Нэхэмжлэлдээ Ж сумын Ц багийн 80 айлын орон сууцны м.кв талбайтай хэмжээ бүхий балансын үнэтэй орон сууцыг аймгийн эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хүмүүст хөнгөлөлттэй үнээр, зарим тохиолдолд 100 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдах тогтоол гаргасан. Тэгэхдээ эдгээр орон сууцыг хувьчилж байгаа маягаар шийдвэр гаргасан. Гэтэл эдгээр байр нь хувьчлагдах орон сууцны жагсаалтад орох үндэсгүй. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 75, 76 дугаар тогтоолоор “Б” компанийн захиалгаар, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар, тус компани болон “Э” компанийн хамтран барьсан 80 айлын орон сууцнаас 6 өрөө орон сууцыг хувьчилж худалдах, ингэхдээ 1 айлын орон сууцыг нь АИТХ-ын, нөгөөг нь ЗДТГ-ын хөрөнгийн данснаас хасах, 80 хувийнх нь үнийг төрөөс гаргахаар шийджээ. Эдгээр тогтоол нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, орон сууц хувьчлах тухай хуулиудыг зөрчсөн тул АИТХ-ын дугаар бүхий тогтоолуудыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Татгалзсан үндэслэл:

Нэг. Хүчингүй болгуулахаар хандсан ИТХ-ын дугаар бүхий тогтоолуудын үйлчлэл нь нэхэмжлэгч нэр бүхий иргэдийн субъектив эрхийг хөндсөн шинжгүй, тэдэнд шууд үр дагавар үүсгээгүй байх тул энэ талаар маргах эрхгүй, мөн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээдэд хамаарахгүй байх тул нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан гэж үзэх үндэстэй.

³⁶ Ховд аймаг дахь ЗХАШШ, 2017.09.05-ны өдрийн 276 захирамж

Хоёр. “Ш” ТББ-ын дүрэмд байгууллагын зорилгыг “Орон нутгийн хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын хөгжлийг дэмжих, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, нийгэмд чиглэгдсэн соёл гэгээрлийн үйл ажиллагаа явуулах” гээд зорилгоо хэрэгжүүлэхийн тулд 6 төрлийн үйл ажиллагааг явуулахаар тусгажээ. Үүний дотор нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой үйл ажиллагаа буюу “нийтийн өмчийг хамгаалах” асуудал хамаарахгүй байна. Иймд “Ш” ТББ нь нийтийн өмчийг хамгаалах асуудлаар нэхэмжлэл гаргах эрхгүй байна. Нэгэнт нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх хуулийн шаардлагыг хангахгүй байх тул дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг шалгах шаардлагагүй гэж үзлээ.

Гурав. “Ш” ТББ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдөр дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлдээ “нийтийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхол, нийтийн өмчийг хамгаалах” үйл ажиллагаа явуулахаар нэмэлт өөрчлөлт оруулж, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлсэн талаар баримтыг шүүхэд ирүүлсэн болохыг дурдах нь зүйтэй байна. “А ТББ нь байгаль орчин, орон нутаг, ард иргэдийн амьдрах орчин, эрүүл ахуй, хүний эрхийг сахин хамгаалах, сайжруулах талаар судалгаа хийх, мэргэжлийн зөвлөмж арга зүй боловсруулах, сургалт сурталчилгаа явуулах, тэдэнд хууль зүйн болон бусад чиглэлээр зөвлөгөө өгөх, тулгамдсан асуудлуудыг нь зохих шатны байгууллага, удирдлагуудад тавьж шийдвэрлүүлэх, ард иргэдийн дуу хоолой болох зэргээр тэдэнд тусалж үйлчлэх, хамтран ажиллах зорилго бүхий нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм” гэжээ.

Тохиолдол 6³⁷:

Нэхэмжлэлийн төрөл: Нийтийн эрүүл мэнд

Нэхэмжлэлийн агуулга: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017.05.03-ны өдрийн А/115, А/176, 142 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын “Амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ” хэсгийн 2 ба 4-т заасан “Бэлгийн гэмт хэргийн үзлэг”, “Гэмтлийн зэрэг тогтоох үзлэг” гэснийг хүчингүй болгуулах.

Татгалзсан үндэслэл: маргаан бүхий тушаалын хавсралт нь улсын хэмжээнд үйлчлэх захиргааны хэм хэмжээний акт тул ЗХШХШТХ-ийн 112.1.1-н дагуу давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэнэ.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШТХ § 54.1.2

³⁷ НЗХАШШТ 2017.12.20-ны өдрийн 128/ШТ32017/0163 дугаар тогтоол



Тохиолдол 7³⁸**Нэхэмжлэлийн төрөл:** Нийтийн эрүүл мэнд

Нэхэмжлэлийн агуулга: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргадаг загвар жагсаалт болон эмчилгээний зааварт орсон гепатитын вирусийн бүх эмийг Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт-д бүрэн хамруулах, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргадаг загвар жагсаалт болон эмчилгээний зааварт орсон гепатитын вирусийн бүх эмийн үнийн 40 хувиас багагүй хэмжээний хөнгөлөлтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлэхийг даалгах

Татгалзсан үндэслэл: *“Улсын хэмжээний, эсхүл хоёр болон түүнээс дээш засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд цйлчлэх захиргааны хэм хэмжээний акттай холбоотой маргаан тул Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрлэнэ”* гэжээ.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШтХ § 54.1.2**Тохиолдол 8³⁹:****Нийтийн ашиг сонирхол:** Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн шаардлага: “А” ХХК-д тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийг хүчингүй болгуулах.

Татгалзсан үндэслэл: *“...түүнчлэн ЗХШХШтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.4.1-д итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх гэж заасныг хангаагүй болохыг дурдах нь зүйтэй. Иймд ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.5-д нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй болон нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан бол шүүгч нэхэмжлэл хүлээн авахаас татгалзана гэж заасны дагуу ТББ-ын тэргүүн Э-ийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй байна”* гэжээ.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШтХ § 27.4.1

³⁸ НЗХАШШ 2017.05.16-ны өдрийн 3303 дугаар захирамж

³⁹ НДЗХАШШ 2017.02.16-ны өдрийн 128/ШЗ2017/1353 захирамж

Тохиолдол 9⁴⁰:

Нийтийн ашиг сонирхол: Нийтийн өмч

Нэхэмжлэлийн агуулга: “Ш” ТББ, “А” ТББ, нэр бүхий 3 иргэд АИТХ-аас хууль зөрчиж гаргасан гэх орон сууц хувьчлах дугаар бүхий тогтоолуудыг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан.

Татгалзсан үндэслэл: “Нэхэмжлэлд “А” ТББ-ыг төлөөлж тус байгууллагын удирдах зөвлөлийн дарга Г-ээс олгосон итгэмжлэлийн дагуу Д гарын үсэг зурсан байна. ЗХШХШТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.2-д “Хууль, эрх зүйн бусад акт болон үцсэгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлнө.” гэж, 27.4-д “Итгэмжлэл нь дараах шаардлагыг хангасан байна: 27.4.1. итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх; 27.4.2. олгосон он, сар, өдрийг заах; 27.4.3. хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх; 27.4.4. захиргааны ямар маргаанд оролцохыг тодорхой заах; 27.4.5. итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах”; 27.5-д “Энэ хуулийн 27.4-т заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна” гэж тус тус заасныг хангахгүй байх тул Д нь “А” ТББ-ыг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд байна гэж үзлээ. Мөн “А” ТББ-ын удирдах зөвлөлийн дарга Б-ээс урьдчилсан хэлэлцүүлэгт оролцуулахаар М, Ц нарт олгосон олгосон итгэмжлэл нь хуульд заасан шаардлага хангахгүй байсныг дурдаад энэ нь нэхэмжлэгчийн шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлагыг хангаагүй үндэслэлд хамааралгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн дээрх хоёр ТББ-ыг төлөөлж нэхэмжлэл гаргасан төлөөлөгч нар нь нэхэмжлэлд гарын үсэг зурахдаа төлөөлж байгаа байгууллагын нэрийг бус зөвхөн өөрийн нэрийг бичсэн нь хэлбэрийн хувьд алдаатай болсныг дурдаж байна” гэжээ.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШТХ § 27, 54.1

Товч тайлбар, дүгнэлт: Энэ тохиолдлын хүрээнд гарсан захирамжид дараах дүгнэлтүүдийг өгөх зорилгоор дэлгэрэнгүй байдлаар дурдлаа.

Нэг. Шүүх итгэмжлэл хуулийн шаардлага хангахгүй байна гэж дүгнэхдээ үйл баримтыг тодорхой дурдалгүйгээр зөвхөн хуулийн зүйл заалт бичсэн нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч захирамжтай танилцаад итгэмжлэлийг хэрхэн өөрчилж, хуульд нийцүүлсэн нөхцөлд шүүх хүлээн авахыг захирамжаас ойлгох боломжгүй байна. Судлаачийн зүгээс ч мөн адил, удирдах зөвлөлийн даргыг шүүхэд төлөөлөх эрхгүй гэж шүүх үзсэн үү, эсхүл ТББ-ын Гүйцэтгэх захирлаас итгэмжлэл олгоогүй, итгэмжлэл

⁴⁰ Ховд аймаг дахь ЗХАШШ, 2017.09.05-ны өдрийн 276 захирамж

хэлбэрийн шаардлага хангаагүй гэх мэт ямар үндэслэлээр фактын хувьд хууль зөрчсөнийг ойлгох боломжгүй байгаа юм.

Хоёр. Итгэмжлэл нь хуулийн шаардлага хангахгүй шалтгааны улмаас нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь ТББ-ын хууль зүйн мэдлэг, чадавхын асуудал бөгөөд цаашид “жижиг” хэмжээний алдаанаас шалтгаалж шүүхэд хандах цаг хугацаа алдах эрсдэлтэй болохыг анхаарах нь зүйтэй.



ХАВСРАЛТ 6. ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХГҮЙ ЭТГЭЭДИЙН ГАРГАСАН НЭХЭМЖЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХААС ТАТГАЛЗСАН ЗАХИРАМЖ

Тохиолдол 1⁴¹

Нийтийн ашиг сонирхол: Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн агуулга: “...нэр бүхий компаниудын хайгуулын тусгай зөвшөөрлүүд болон олгосон шийдвэрүүдийг хүчингүй болгуулах, Үндэсний хөгжлийн газрын “Н” ХХК-тай байгуулсан концессын гэрээ болон, концессын гэрээ байгуулах эрх олгосон тогтоолыг хүчингүй болгуулах, “Н” ХХК-д төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгосон тогтоолыг хүчингүй болгуулах”

Хариуцагч: Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний хөгжлийн газар, Зам тээвэр хөгжлийн яам, Монгол Улсын Засгийн газар

Нэхэмжлэгч: Хөвсгөл аймгийн 4 багийн иргэдийн нийтийн хурал

Татгалзсан үндэслэл: “...ЗХШХШтХ-ийн 3.1.3-д зааснаар захиргааны байгууллага нь зөвхөн хуульд тусгайлан заасан бол гэсэн нөхцөлөөр Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна. Маргааны зүйл, нэхэмжлэлийн агуулгаас үзэхэд аливаа багийн иргэдийн Нийтийн Хуралд холбогдох хуулиар тусгайлан эрх олгоогүй байна, хүрээлэн буй орчинтой холбоотой холбоотой нэхэмжлэлийг дүрмийн зорилгодоо нийцсэн, сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гаргах эрхтэй байгаагаас үзвэл, захиргааны байгууллага болох багийн иргэдийн Нийтийн Хурал нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдээс тусдаа буюу хуульд зааснаар нэхэмжлэл гаргах эрх нь үүсэхээр байна” гэжээ.

Тохиолдол 2

Нэхэмжлэлийн агуулга: Нэр бүхий компанийн хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлуулах

Нэхэмжлэгч: Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга, сумын нэр бүхий иргэд.

Татгалзсан үндэслэл: Шүүхээс эдгээр нэхэмжлэгч нарыг нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэх эрхгүй этгээд гэж дүгнэсэн.

⁴¹ НдЗХАШШ, 2017.08.04, дугаар 4937



Тохиолдол 3⁴²:**Нийтийн ашиг сонирхол:** Хүрээлэн буй орчин

Нэхэмжлэлийн агуулга: Манай ТББ нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын ИТХ-аар “Ойгоос мод бэлтгэх хуваарь батлах” хурлын ажиллагаанд оролцуулахыг шаардсан албан бичиг илгээсэн. Гэвч бидний хүсэлтийг хүлээн авалгүйгээр ИТХ-ын тогтоол баталсан. Тогтоол гаргахдаа Ойн тухай хуулийн 9.3-т заасныг зөрчсөн, ойн мэргэжлийн байгууллага нь ойн менежментийн төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргасан байх, тэр төлөвлөгөөг хэлэлцэж байж шийдвэр гаргах ёстой байсан. Мөн хуулийн 4.12-д зааснаар мод бэлтгэх, ойн баялгийг ашиглахдаа ойн санг хамгаалах зардлыг ойн нөхөрлөлүүдэд төлөх үүрэгтэй, энэ талаар тогтоолдоо зааж өгөөгүй. Ойн тухай хуулийн 32.3-т сумын Хурал ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг тогтоох ёстой. Гэтэл хурлын тэргүүлэгчид энэ асуудлыг шийдвэрлэх тогтоол гаргасан. Хурлын 27 төлөөлөгч шийдвэрлэх асуудлыг Тэргүүлэгчид шийдвэрлэсэн нь хууль бус, хууль зөрчсөн. Иймд Хонгор сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 23 тоот тогтоолыг хүчингүй болгож өгнө үү.

Шүүх үзэхдээ: “ТББ-ын дүрэмд заасан үйл ажиллагаа, улсын бүртгэлийн гэрчилгээ зэргээс үзэхэд ТББ нь байгуулагдаад 1 жил болоогүй, нэхэмжлэлийн шаардлага нь дүрмийн зорилготой нийцээгүй ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2, 54 дүгээр зүйлийн 54.1.5-д заасныг баримтлан шүүхэд гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж үзлээ”.

Тохиолдол 4⁴³:

Нэхэмжлэлийн агуулга: Нэхэмжлэгч Иргэн С, “О” ТББ нар анх тус тусдаа нэхэмжлэл гаргасан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийг нэгтгэсэн байна. Тэд шаардлагадаа ашиг малтмалын газрын Геологи уул, уурхайн Кадастрын хэлтсийн (хуучин нэрээр) даргын тоот шийдвэр, “С” ХХК-нд олгосон тоот тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах гэжээ.

Нийтийн ашиг сонирхлын төрөл: Хүрээлэн буй орчин

Шүүх үзэхдээ: “ТББ-ын нэхэмжлэлийн шаардлагын тухайд: дугаар бүхий актууд гарснаар Хөвд, Хуршуутын голын байгалийн тэнцэл алдагдаж, нутгийн иргэдийн Үндсэн хуульд заасан “...эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах... эрх зөрчигдөж

⁴² Дархан-Уул аймаг дахь ЗХАШШ, 2017.12.04, дугаар 62

⁴³ НдЗХАШШ, 2018.10.29, 128/ШШ2018/0669

болзошгүй...” гэх үндэслэлээр дээрх тусгай зөвшөөрлийг олгосон шийдвэр, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасныг шүүх хүлээн авах боломжгүй байна. Учир нь ЗХШХШгХ-ийн 18.3-т заасан шаардлагыг хангаагүй байна.... Гэтэл хэрэгт авагдсан нотлох баримтаар ТББ нь анх 2010 онд өдөр байгуулагдсан бөгөөд “О” төслийн хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээг хэрэгжүүлэхдээ талууд МУ-ын хууль, олон улсын гэрээ конвенц, олон улсын стандарт, гэрээний өөрийн зүйл заалтуудад хэрхэн нийцүүлж ажиллаж байгаад хяналт тавих, үнэлгээ өгөх, зөвлөмж гаргах, санал гомдол хүргүүлэх зорилготой” гэж зорилго, үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон байжээ. Харин дээрх үйл ажиллагааны зорилго чиглэлээ 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлаараа “..уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин ба хүний нийгэмд учрах нөлөөллийг олон улсын байгаль орчин... стандартад нийцүүлж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчлийг арилгуулах нөлөөллийн үйл ажиллагаа, эрх нь хөндөгдсөн талуудын эрх ашгийг хамгаалах...” гэж, 2018 оны өдрийн хурлаар ТББ нь уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин ба хүний нийгэмд нөлөөллийг Монгол Улсын хууль, олон улсын байгаль орчин ба хүний эрхийн гэрээ конвенцын эрх зүйн норм, олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын хамгааллын бодлогын стандартад нийцүүлж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчлийг арилгуулах нөлөөллийн үйл ажиллагаа, эрх нь хөндөгдсөн талуудын эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах судалгаа, сургалт явуулах, үндэсний, гадаадын болон олон улсын байгууллагуудын хүрээнд үйл ажиллагаа явуулна” гэж өөрчилсөн. Түүнчлэн ТББ-ын үйл ажиллагааны тайлан бусад нэхэмжлэлд хавсаргасан баримтаас үзвэл нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага нь дүрмийн зорилготой бүрэн нийцээгүйгээс гадна дүрэмд тодорхойлсон асуудлаар гурваас доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагааг явуулсан байх хуулийн шаардлагыг хангаагүй буюу Ө аймгийн Г сумын иргэдийн эрх ашгийг хөндсөн гэх маргаан бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд, түүнийг олгохоор шийдвэрлэсэн шийдвэрүүдийг хүчингүй болгуулах асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий чиг үүргийг шүүхэд төлөөлөн хэрэгжүүлэх боломжгүй байна” гэжээ.

Иргэн С-ийн нэхэмжлэлийн шаардлагын тухайд: Энэхүү маргааны үйл баримт болон бодит байдалд дүгнэлт хийхэд нэхэмжлэгч С нь сумын ЗД-ын захирамжаар 50000 м.кв газрыг эзэмшдэг бөгөөд газар дээрээ төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тарьдаг. Ашиг малтмалын тусгай зөвшөөрөл бүхий газар нь түүний газартай давхацсан талаар баримт ирүүлээгүй, газрын мэдээллийн санд бүртгэгдээгүй байх тул захиргааны байгууллагын шийдвэрийн улмаас нэхэмжлэгч С-ийн эрх хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэхгүй гэжээ.



Тохиолдол 5⁴⁴

Нэхэмжлэлийн төрөл: Нийтийн эрүүл мэнд

Нэхэмжлэлийн агуулга: элэгний D вирусийн тоолох шинжилгээ, элэгний В вируст уудаг эмүүдийг, элэгний D вирусэд тарих тариаг, элэгний хатуурлыг тодорхойлох шинжилгээг, элэгний MRI, донорын элгэнд хэрэглэгдэх эмийг, элэг солиулсны дараах хэрэглэх шаардлагатай эмийг тус тус эрүүл мэндийн даатгалын сангаас зардал төлбөрийг нь хариуцах эм тусламж үйлчилгээний багцад тооцон тусламж үйлчилгээний жагсаалтад оруулахыг даалгуулах

Нэхэмжлэгч: иргэн Д, Н, М, Б, Б, Д

Татгалзсан үндэслэл: ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.2-д “тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус”, 109 дүгээр зүйлийн 109.2-т “энэ хуулийн 54.1-д заасан үндэслэл хэргийг хянан шийдвэрлэх явцад эсхүл шүүх хуралдааны үед тогтоогдвол... хэргийг хэрэгсэхгүй болгоно ” гэж зааснаар захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэх нь зүйтэй байна. Хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн хэдий ч маргаж буй асуудлаараа Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж, маргаанаа шийдвэрлүүлэх боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй байна.

Хэрэглэсэн хуулийн заалт: ЗХШХШТХ § 54.1.2, 54.2

⁴⁴ НЗХАШШ 2018.10.01-ний өдрийн 128/ШЗ2018/6367 дугаар захирамж

ХАВСРАЛТ 7. НЭХЭМЖЛЭЛИЙН БҮТЭЦ, БҮРДҮҮЛБЭРИЙН САНАЛ

Энэхүү судалгаан дээр үндэслэн нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хэрхэн бүрдүүлсэн нөхцөлд хамгийн сайн нэхэмжлэл болж чадах вэ гэсэн өнцгөөр зөвлөмж боловсруулахыг эрмэлзлээ. Гэхдээ шүүх нэхэмжлэлийн шаардлагын бүрдүүлбэрт харилцан адилгүй байдлаар хандаж байгаа одоогийн нөхцөлд ийнхүү зөвлөмж өгөхөд хүндрэлтэй байгааг дурдах нь зүйтэй. Тухайлбал, зарим шүүгч дараалсан гурван жилийн санхүүгийн тайлан шаардахад нөгөө нь шаардалгүйгээр захиргааны хэрэг үүсгэсэн байх ба бид энэхүү зөвлөмжид ТББ-ыг нэхэмжлэлдээ заавал санхүүгийн тайлан хавсарга, эсхүл шаардлагагүй гэж зөвлөх боломжгүй болж байгаа гэх мэт. Ямартаа ч нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдээс, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргах нэхэмжлэлд “нэхэмжлэлийн бүтэц”-ийн хувьд дараах зүйлсийг зайлшгүй анхаарах шаардлагатай болохыг нийтлэг байдлаар тусгалаа.

1 Захиргааны хэргийн шүүхийн нэрийг зөв томьёолсон эсэх?

- Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд
- Аймаг дах захиргааны хэргийн анхан шатны шүүхэд
- Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд



2 Хариуцагчийг зөв тодорхойлсон эсэх?

- Нэхэмжлэлд дурдсан хариуцагч нь тухайн хэргийн жинхэнэ хариуцагч биш бол шүүх нэхэмжлэгчийн зөвшөөрснөөр хариуцагчийг солих, ийнхүү зөвшөөрөөгүй бол хамтран хариуцагчаар хэрэг татан оролцуулах үүрэгтэй санах



3 Нэхэмжлэлийн шаардлагаа зөв тодорхойлох эсэх?

- Захиргааны акт, захиргааны гэрээг хүчингүй болгуулах
- Захиргааны акт, захиргааны гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох
- Эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох,
- Захиргааны акт гаргуулахыг даалгах
- Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох
- Захиргааны хэм хэмжээний актыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох гэх мэт



4 Нэхэмжлэлийн үндэслэлээ оновчтой тодорхойлсон эсэх?

- Маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн эсэх.
- Нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсэн, зөрчигдөж болзошгүйг тодорхойлсон эсэх, нотлох баримт бүрдүүлсэн эсэх



5	Нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгуулах, хууль бус болгохыг тогтоолгох нэхэмжлэл гаргасан тохиолдолд захиргааны хэргийн харьяаллын шүүхэд гаргасан эсэх? (Энэ тохиолдолд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх тусгай журмаар хянан шийдвэрлэдэг)	<input checked="" type="checkbox"/>
6	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн, эсхүл чөлөөлөгдөх хүсэлтээ нэхэмжлэлд тодорхойлсон эсэх?	<input checked="" type="checkbox"/>
7	Нэхэмжлэлд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх?	<input checked="" type="checkbox"/>
8	Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн эрх зүйн чадварыг тодорхойлохуйц гэрчилгээ, дүрмийн хуулбарыг нотариатаар баталгаажуулан хавсаргасан эсэх?	<input checked="" type="checkbox"/>
9	Хангалттай сонирхол илэрхийлснийг тодорхойлох баримтыг баталгаажуулж, хавсаргасан эсэх?	<input checked="" type="checkbox"/>
10	Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй эсэх?	<input checked="" type="checkbox"/>
11	Итгэмжлэлээр төлөөлж буй тохиолдолд, итгэмжлэл нь ЗХШХШТХ-ийн 27.4-т заасныг хангасан эсэх?	<input checked="" type="checkbox"/>
12	Өмгөөлөгч оролцох тохиолдолд хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан, хавсаргасан эсэх?	<input checked="" type="checkbox"/>
13	Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулсныг нотолсон эсэх?	<input checked="" type="checkbox"/>
14	Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилсан эсэх?	<input checked="" type="checkbox"/>

ТББ-ууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараах зүйлд анхаарлаа хандуулж, зохион байгуулах нь зүйтэй байна. Үүнд:

1. Хэрэв Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах алсын хараатай байгаа нөхцөлд ТББ-ын нэр, хийгээд зорилго, үйл ажиллагааны чиглэлийг хэт нарийвчлахгүй байх. Тухайлбал зөвхөн нэг голыг хамгаалах гэж томъёолохоос зайлсхийх;
2. Үйл ажиллагааны тайланг улсын бүртгэлийн хуульд заасны дагуу илгээж байх;
3. Татвар, санхүүгийн тайланг мөнгөн гүйлгээ хийгдсэн эсэхээс үл хамаарч илгээж байх;

4. Хийсэн аливаа үйл ажиллагааны талаарх бүхий л мэдээллийг тухай бүр баримтжуулж, нийтэд мэдээлж байх зэргээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан болохоо бүхий л баримтаар дэмжих;
5. Байгууллагын баримт бичгийн бүртгэлийг стандартын дагуу хөтлөх;
6. Нэхэмжлэлийн шаардлагыг заавал хууль, эрх зүйн мэдлэгтэй хүний зөвлөгөөний үндсэн дээр тодорхойлох;
7. Тухайн акт, эс үйлдэхүйн улмаас нийтийн ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн хийгээд зөрчигдөж болзошгүйг мэргэжлийн хувьд тодорхойлж, судлах, улмаар шүүхэд тайлбарлах;
8. Бусад шийдвэр хэрэг маргаан, тэдгээрийг шийдвэрлэсэн шүүхийн захирамж, тогтоол, шийдвэрийг тухай бүр сайтар судлах.
9. ТББ-ын туулж ирсэн замнал, үйл хэрэг, дүрмийн зорилго, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн хийгээд зөрчигдөж болзошгүй тухай тайлбар, түүнийг яагаад хамгаалах ёстой вэ гэсэн эдгээр холбоосыг сайтар хадгалж, илэрхийлж чадсан нөхцөлд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилго хангагдах, илүү мэргэжлийн байх нь дамжиггүй.

Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн оролцож болох талаар нарийвчилсан зөвлөмж хүргүүлэх боломжгүй байна. Учир нь захиргааны хэрэг үүсгүүлж чадсан л бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц бусад захиргааны хэрэг маргаантай ижил байгаа талаар өмнө дурдсан. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар арга барилаар оролцох, ямар хүсэлт гаргах гэхчлэн бүхий л асуудалд тухай бүрдээ хуульчтайгаа сайтар зөвлөлдөн ажиллах нь чухал аж. Нэхэмжлэгч нар нэхэмжлэл гаргах эрхтэй болохоо нотлох хийгээд өөрийн нэхэмжлэлийн шаардлагаа дэмжих баримтын нэр төрлийн талаар өмнө дурдсан байгаа болно. Магад хэтдээ ТББ-ууд өргөн цар хүрээтэйгээр мэргэжлийн түвшинд маргаан өрнүүлсэн нөхцөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц илүү боловсронгуй болох нь зүйн хэрэг.

